



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2021 он



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2021 он

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	9
Нэг. Хураангуй	10
Хоёр. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн товч танилцуулга	12
Гурав. Эдийн засгийн гүйцэтгэл, цаашдын хандлага.....	13
3.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал.....	13
3.2. Макро эдийн засгийн 2021, 2022 оны төсөөлөл.....	14
Дөрөв. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төслийн товч танилцуулга	16
Бүлэг 1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого.....	17
Бүлэг 2. Хүний хөгжлийн бодлого.....	17
Бүлэг 3. Эдийн засгийн бодлого	18
Бүлэг 4. Засаглалын бодлого	19
Бүлэг 5. Ногоон хөгжлийн бодлого.....	20
Бүлэг 6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого.....	20
Тав. Төсөв, санхүү, мөнгөний бодлогын уялдаа	21
5.1. Сангийн болон төсвийн бодлого	21
5.2. Мөнгөний болон макро зохистой бодлого	22
5.3. Бүтцийн өөрчлөлтийн бодлого	23
5.4. Засгийн газрын төлөвлөгөөт ажил	25
Зургаа. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэл	28
6.1. Вакцинжуулалт	28
6.2. Голлох түүхий эдийн үнийн өөрчлөлт	28
6.3. Засгийн газрын өрийн хязгаарлалт	29
6.4. Цаг агаарын хүчин зүйлээс шалтгаалж гарах хүндрэл.....	29
Долоо. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тооцоо.....	30

II. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА	31
Нэг. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал.....	32
1.1. Макро эдийн засгийн 2020 оны урьдчилсан гүйцэтгэлд хийсэн шинжилгээ...	32
1.2. Бодит салбарын хөгжил	49
1.3. Хүн, нийгмийн хөгжил.....	64
1.4. Байгаль орчин, ногоон хөгжил	78
1.5. Засаглал, хууль, эрх зүйн шинэтгэл	82
1.6. Гадаад харилцаа	83
1.7. Батлан хамгаалах.....	84
Хоёр. Хувийн хэвшлийн эдийн засаг дахь оролцоо	86
Гурав. Макро эдийн засгийн 2021-2024 оны хандлага	90
3.1. Дэлхийн эдийн засгийн төлөв.....	90
3.2. Макро эдийн засгийн өсөлт	93
3.3. Улсын төсөв, хөрөнгө оруулалт	95
3.4. Бодит салбарын хөгжил	96
Дөрөв. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын арга хэмжээ.....	97
Бүлэг 1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого.....	97
Бүлэг 2. Хүний хөгжлийн бодлого.....	98
Бүлэг 3. Эдийн засгийн бодлого	101
Бүлэг 4. Засаглалын бодлого	106
Бүлэг 5. Ногоон хөгжлийн бодлого.....	107
Бүлэг 6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого.....	108
III. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ	109

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
АНДМУТБ	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
АХБ	Азийн хөгжлийн банк
АХ-2050	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГДХО	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХО	Дотоодын хөрөнгө оруулалт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗГҮАХ	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГҮАХ-АХТ	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
МУТЖҮЧ	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЭ	Нэгдсэн эмнэлэг
ОУБ	Олон улсын байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ФАТФ	Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зорилт, арга хэмжээний биелэлт	12
Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, батлагдсан төсвийн дүн, тэрбум төгрөг	21
Хүснэгт 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл	22
Хүснэгт 4. Макро зохистой бодлогын шийдвэр	23
Хүснэгт 5. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө	25
Хүснэгт 6. Нүүрсний экспортыг эхлүүлсэн боомт	36
Хүснэгт 7. Ковид-19 цар тахлын үеийн төсвийн дэмжлэгийн тухай	36
Хүснэгт 8. Төсвийн зардлын эрэмбийн тухай	37
Хүснэгт 9. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал	42
Хүснэгт 10. Жилийн дундаж инфляц, 2016-2020 он	43
Хүснэгт 11. Худалдааны түнш орнууд, нийт дүнд эзлэх хувь	46
Хүснэгт 12. Монгол Улсын малын тоо, мянган толгой	50
Хүснэгт 13. Хураан авсан ургацын хэмжээ, мянган тонн	51
Хүснэгт 14. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөг	54
Хүснэгт 15. Дэд салбарын үйлдвэрлэл	59
Хүснэгт 16. Зам тээврийн салбарын зарим үзүүлэлт	59
Хүснэгт 17. Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоо, өсөлт	67
Хүснэгт 18. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөг	67
Хүснэгт 19. Ерөнхий боловсролын сургууль болон сурагчийн тоо	70
Хүснэгт 20. Дээд боловсролын сургалтын байгууллагуудад суралцагчдын тоо	72
Хүснэгт 21. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага	76
Хүснэгт 22. Ойн нөхөн сэргээх ажил, 2016-2020 он	81
Хүснэгт 23. Цөлжилтийн үйл явцын хандлага, хувь	82
Хүснэгт 24. Дэлхийн эдийн засгийн өсөлт, хувь	90
Хүснэгт 25. Экспортын голлох бүтээгдэхүүний үнийн төсөөлөл, тонн/ам.доллар	92
Хүснэгт 26. Макро эдийн засгийн голлох үзүүлэлтийн төсөөлөл	95
Хүснэгт 27. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, 2021-2022 он, тэрбум төгрөг	95
Хүснэгт 28. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, салбараар, хувь	96

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Эдийн засгийн өсөлт, үйл ажиллагааны салбараар, 2018-2020 он	32
График 2. ДНБ-ий бүтэц, эцсийн ашиглалтаар, хувь	33
График 3. Нэг хүнд ногдох ДНБ, 2016-2020 он, сая төгрөг	33
График 4. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, ажилгүй байгаа шалтгаан, 2020 оны эцэст, дүнд эзлэх хувь	39
График 5. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшин, хүйс, 2020 оны эцэст, дүнд эзлэх хувь	39
График 6. Ажилгүйдлийн түвшин, насны бүлгээр	40
График 7. Ажилгүйдлийн түвшин.....	40
График 8. Ядуурлын хамралтын хүрээ, хувь	41
График 9. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин, 2016-2020 он, мянган төгрөг.....	42
График 10. 2020 оны инфляцын бүтцийн задаргаа, сараар.....	43
График 11. Мөнгөний нийлүүлэлт, тэрбум төгрөг	44
График 12. Төгрөгийн болон валютын хадгаламж, сар бүрийн эцэст, их наяд төгрөг..	44
График 13. Нийт зээл, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар	45
График 14. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл, нийт зээлд эзлэх хувь	45
График 15. Төлбөрийн тэнцэл, 2017-2020 он, сая ам.доллар	46
График 16. Экспорт, импорт, худалдааны тэнцэл, 2016-2020 он, сая ам.доллар	47
График 17. Экспортын зарим бүтээгдэхүүний үнийн дүн, мянган ам.доллар	47
График 18. Импортын зарим бүтээгдэхүүний үнийн дүн, мянган ам.доллар	48
График 19. Активын үлдэгдэл, их наяд төгрөг	48
График 20. Пассивын үлдэгдэл, өсөлт, их наяд төгрөг	49
График 21. Хүнд үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	56
График 22. Цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ.....	58
График 23. Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, тэрбум төгрөг.....	61
График 24. 2010-2020 оны аялал жуулчлалын салбарын орлого (сая ам. доллар)	63
График 25. Хүн амын дундаж наслалт	64
График 26. Халдварт өвчнөөр өвчлөгсөд.....	65
График 27. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 2019 он.....	66
График 28. Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтын тоо, мянган хүүхэд	69
График 29. Ерөнхий боловсролын сургуулийн дундаж бүлэг дүүргэлт, хот хөдөөгөөр	71
График 30. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт	73
График 31. Нийт олгосон патентын тоо.....	73
График 32. Нийгмийн даатгалд хамрагдагсдын тоо, мянган хүн.....	75
График 33. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ, төрлөөр, мянгаар	75
График 34. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, төрлөөр, мянгаар	76
График 35. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсад, 2016-2020 он, мянган хүн ...	77

График 36. Нийгмийн халамжийн үйлчилгээний зардлын дүн, 2018-2020 он, тэрбум төгрөгөөр	77
График 37. Ойн сав газрын төрлийн ангилал, 2020 он	80
График 38. Хувийн хэвшлийн ДНБ-д эзлэх хувь	86
График 39. Хувийн хэвшлийн ДНБ-д эзлэх хувь, бүсээр, 2019 он	86
График 40. Салбар болгоны хувийн хэвшлийн оролцоо	87
График 41. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал, сая ам.доллар ...	87
График 42. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал, салбараар, сая ам.доллар ..	88
График 43. Хөрөнгө оруулагчдыг хамгаалах, тэдгээрийн гомдлыг шийдвэрлэх тал дээр үзүүлэх дэмжлэг, төлсөн татварын дүнгийн ангиллаар	89
График 44. Хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны хүртээмжтэй, үр дүнтэй байдал, төлсөн татварын дүнгийн ангиллаар..	89
График 45. Түүхий эдийн үнийн хандлага	91
График 46. Түүхий эдийн үнийн хандлага	92
График 47. Зэс, хөнгөн цагааны үнийн хандлага, ам.доллар/тонн	92
График 48. Нефть, нүүрсний үнийн хандлага, ам.доллар/тонн.....	93
График 49. ДНБ-ий төсөөлөл, их наяд төгрөг.....	94

I
БҮЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

НЭГ. ХУРААНГУЙ

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төслийг үүгээр танилцуулж байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс мөрдөгдөж эхэлснээр Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн эх үүсвэрийн хамт тусгасан хөгжлийн жилийн төлөвлөгөөг жил бүрийн 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зохицуулалт үйлчилж байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд 6 бүлгийн хүрээнд 23 зорилго дэвшүүлж, 263 арга хэмжээг төлөвлөлөө. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан арга хэмжээнүүдийг тодорхойлохдоо тодорхой байх, хэмжигдэхүйц, зорилгодоо хүрч болохуйц байх, бодитой байх, цаг хугацаатай байх гэсэн төлөвлөлтийн үндсэн шалгуурыг баримталснаас гадна зорилтот түвшин, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтад нь тодорхойлсон.

“Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” нэрээр анх удаа өргөн мэдүүлж буй энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа бодлогын үндсэн 3 зарчмыг баримталлаа. Нэгдүгээрт, Ковид-19 цар тахалтай үргэлжлүүлэн тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагаврыг саармагжуулахыг зорив. Хоёрдугаарт, макро эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах бодлогыг баримталсан. Гуравдугаарт, хөгжлийг урт, дунд хугацаанд хязгаарлаж буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилтыг тавив. Эдгээр бодлогын зарчим нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт үндэслэснээс гадна Засгийн газрын Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөтэй нийцтэй байна.

Ковид-19 цар тахалтай үргэлжлүүлэн тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагаврыг саармагжуулах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгын хүрээнд 3 асуудлыг анхаарлаа. Нэгдүгээрт, бүх нийтийн вакцинжуулалтыг эрчимжүүлж, олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх, сургууль, цэцэрлэгийн танхимын сургалтын үйл ажиллагааг 9 дүгээр сараас үе шаттай эхлүүлэх зэрэг төсөөллийг авч үзэв. Хоёрдугаарт, нийтийн эрүүл мэндийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх, бэлэн байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөгөөний төсөлд тусгав. Гуравдугаарт, цар тахлын нөхцөлд нийцүүлэн бизнесийн үйл ажиллагааны стандартыг шинэчлэх, цахимжуулах зэрэг бодлогын арга хэмжээг авахаар төлөвлөлөө.

Макро эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах хүрээнд 3 зарчим баримтлав. Нэгдүгээрт, төсвийн тогтвортой байдал, гадаад өрийн хязгаарыг мөрдөж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах бодлогыг баримтлав. Хоёрдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл, Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөнд тусгагдсан, 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээг харгалзан үзэв. Гуравдугаарт, төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах бодлогын төсөлтэй уялдуулсан. Жилийн төлөвлөгөөний төсөлд Монголбанкнаас санал авсны зэрэгцээ

санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг энэхүү төлөвлөгөөнд тусгасан болно.

Хөгжлийг урт, дунд хугацаанд хязгаарлаж буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх 3 дахь зарчмын хүрээнд бодлогын асуудлыг салбар тус бүрээр оруулав. Төрийн байгууллагуудаас ирүүлсэн арга хэмжээ нь Монгол Улсад хэрэгжиж буй урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдаж буй байдал, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмэр, үр дүн, ач холбогдол, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага, урьдчилсан нөхцөл байгаа эсэх, бэлтгэл хангагдсан байдал, санхүүгийн эх үүсвэр баталгаатай эсэх зэрэг нөхцөл, шаардлагуудыг харгалзан үзсэн.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг 2022 оны төсөвт тусган хэрэгжүүлснээр дунд хугацааны хөгжлийн зорилт хангагдана. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд боловсруулсан энэхүү төлөвлөгөөг хувийн хэвшилтэй хамтран үр дүнтэй хэрэгжүүлснээр нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, эдийн засгийн бүтцээ өөрчлөх дунд хугацааны зорилтод хүрэх алхам болох юм. Өөрөөр хэлбэл, бодлогын арга хэмжээг улсын төсөвт бүрэн тусгаж, хэрэгжилтийг хангаснаар цар тахлын үеийн хүндрэлээс эдийн засгаа гаргаж, нийтийн эрүүл мэндийг хамгаалж хувийн хэвшлийг хөгжүүлэх, иргэдийн амьжиргааг сайжруулах боломж бүрдэнэ.

--oOo--

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2019 оны 57 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан нийт 127 арга хэмжээнээс 77

нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-тай, 113 нь Засгийн газрын 2016-2020 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртэй, 28 нь салбарын Төрөөс баримтлах бодлоготой, 5 нь бусад бодлогын баримт бичигтэй уялдсан байна. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг баримтлан зорилт, арга хэмжээний биелэлтэд хийсэн үнэлгээнээс үзэхэд 2020 оны жилийн эцсийн байдлаар 20 зорилт, 127 арга хэмжээний биелэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 75.9 хувьтай байна.

Хүснэгт 1. Зорилт, арга хэмжээний биелэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлт, бүлгээр	Хэрэгжилтийн хувь
Макро эдийн засгийн бодлого	56.7
Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	53.7
Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	74.0
Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	74.0
Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	91.9

Эх сурвалж: Үндэсний аудитын газар

Үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хувиар авч үзвэл:

- 64 арга хэмжээ - 100.0 хувь буюу бүрэн биелж,
- 5 арга хэмжээ - 90.0 хувь,
- 26 арга хэмжээ - 70.0 хувь,
- 11 арга хэмжээ - 50.0 хувь,
- 14 арга хэмжээ - 30.0 хувь,
- 7 арга хэмжээ - 0 хувийн биелэлттэй гэж тус тус үнэлэгдсэн.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан

зорилт, арга хэмжээний биелэлтийг гаргахад дараах асуудлыг цаашид анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Арга хэмжээг хамтран хэрэгжүүлж буй төрийн байгууллага хоорондын ажлын уялдааг хангаж ажиллах;
- Зорилт, арга хэмжээний биелэлтийн хувийг холбогдох журмын дагуу зорилтот түвшинтэй бодитоор харьцуулж үнэлэх;
- Үндсэн чиглэлийн биелэлтийг тайлагнахдаа гүйцэтгэлийг зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлттэй уялдуулан тухайн жилийн байдлаар тайлагнах.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

Энэхүү хөгжлийн жилийн төлөвлөгөө нь дэлхий дахинд үүсээд буй Ковид-19 цар тахлаас үүдэлтэй Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулж, эдийн засгийг тогтворжуулах, эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг засч сайжруулан эдийн засгийн тэлэх боломжийг бүрдүүлэх, улмаар дунд хугацааны тогтвортой өсөлтийг хангахад чиглэгдэж байна.

3.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал

2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын эдийн засаг 5.3 хувиар агшив. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2010 оны зэрэгцүүлэх үнээр 18.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.0 их наяд төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна. Эдийн засгийн өсөлт ийнхүү саарахад боловсруулах үйлдвэрлэлийн жилийн өсөлт 10.9 хувиас 1.3 хувь хүртэл буурсны зэрэгцээ бөөний болон жижиглэнгийн худалдаа 11.1 хувиар, уул уурхай, олборлолт 9.4 хувиар, барилга 7.4 хувиар тус тус агшсан нь голлон нөлөөлжээ.

Нэг хүнд ногдох ДНБ 2020 онд 6.3 хувиар буурчээ. Эдийн засгийн өсөлт хурдацтай сэргэж эхэлсэнтэй холбоотойгоор нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт 2017-2019 онд дунджаар 4.1 хувиар өссөн хэдий ч цар тахалтай холбоотойгоор 2020 онд огцом агшиж, зэрэгцүүлэх үнээр 5.6 сая төгрөгт хүрчээ.

Эдийн засаг дахь нийт ажилгүйдлийн түвшин 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 7.6 хувьтай байна. Улаанбаатар хот дахь ажилгүйдлийн түвшин 8.6 хувь байгаа бол хөдөөгийн ажилгүйдлийн түвшин 5.0 хувьтай байна. Цар тахлаас үүдэлтэй хөл хорио нь ажиллах хүч ихтэй салбар болох бөөний болон жижиглэнгийн худалдаа,

машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр ба агуулахын салбарын ажиллагсдад нэн хүндээр туссан байна.

Эдийн засаг 2021 оны эхний хагаст зогсонги байх хэдий ч хоёрдугаар хагаст сэргэх хүлээлттэй байна. Ковид-19 цар тахлын тархалт нэмэгдэж, хөл хорио тавигдсанаар уул уурхайн бус салбарын идэвхжилэхний хагаст төдийлөн нэмэгдэхээргүй байна. Эдийн засгийн цаашдын төлөв хэрхэн өөрчлөгдөх нь дотоодод тархсан Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас голлон хамаарч байна.

Засгийн газраас 2020 онд Ковид-19 цар тахлыг даван туулахад зориулсан арга хэмжээнээс дурдвал: Ковид-19 цар тахлын хүндрэлийг даван туулах зорилтын хүрээнд (i) иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, (ii) амьжиргааг дордуулахгүй байх, (iii) ажлын байрыг хадгалах, (iv) эдийн засгийн идэвхжлийг дэмжих чиглэлд багц бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, эрүүл мэндийн салбарт нэн зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардалд улсын төсвөөс 17 тэрбум төгрөг, 570 тоног төхөөрөмж авахад Азийн хөгжлийн банк (АХБ)-наас 4.2 тэрбум төгрөг, 68 тоног төхөөрөмж авахад Дэлхийн банк (ДБ)-наас 6.0 тэрбум төгрөг, 8800 оношлуур, 118 мянган хамгаалах хэрэгслийг авахад бусад хандивлагч улс болон олон улсын байгууллагаас 6.0 тэрбум төгрөгийн санхүүжилт аваад байна.

Эдийн засаг агшиж, дотоод эрэлт хумигдсанаар жилийн дундаж инфляц өмнөх оноос 3.6 нэгж хувиар буурав. Инфляц 2020 оны эцэст 2.3 хувьтай, 2021 оны 2 дугаар сард 2.0 хувьтай байна. Засгийн газраас хүүхдийн мөнгөний дүнг нэмэгдүүлж, хүнсний талоньг 2 дахин нэмэгдүүлж, нийгмийн халамжийн

сангаас сар бүр олгодог халамжийн дүнг нэмэгдүүлснээр мөнгөний нийлүүлэлт өмнөх оноос 3.3 их наяд төгрөг буюу 16 хувиар өсч, 2020 оны 12 дугаар сарын эцэст 24.2 их наяд төгрөг боллоо. Эх үүсвэрээр нь авч үзвэл, төгрөгийн хадгаламж 20 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр, валютын хадгаламж 33.0 хувиар буюу 1.2 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 786.9 сая ам.долларын ашигтай гарав. Төлбөрийн тэнцлийн урсгал болон хөрөнгийн дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 3.5 дахин буурч 571.8 сая ам.доллар, санхүүгийн дансны тэнцэл 1.8 дахин буурч 1,504.2 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад валютын цэвэр албан нөөц 4,534 сая ам.доллар хүрлээ. Энэ нь сүүлийн 3 сарын дундаж импортын 10.7 сарын хэрэгцээг хангах түвшин юм.

3.2. Макро эдийн засгийн 2021, 2022 оны төсөөлөл

Дэлхийн эдийн засгийн сэргэлт үргэлжилж, эдийн засгийн өсөлт 2021, 2022 онд харгалзан 7.6 ба 4.6 хувь гарах төлөвтэй байна. Цар тахлын дараагийн давлагаа, мутацид орсон вирус зэрэг шинэ эрсдэл үүсч байгаа хэдий ч дэлхий нийтийн вакцинжуулалт, эдийн засгийн бодлогын дэмжлэгтэй холбоотойгоор Олон улсын валютын сан (ОУВС)-гийн шинэчилсэн төсөөлөл өмнөх төсөөллөөс бага зэрэг нэмэгдсэн байна. Улс орнууд цар тахлын дараах эдийн засгаа сэргээхээр ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс нэмэгдүүлэх гол хүчин зүйл болжээ.

Дэлхийн эдийн засгийн төлөв сайжирснаар дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн төсөөлөл сайжирлаа. Сүүлийн 6 сарын хугацаанд

суурь металлын үнийн индекс 30.0 хувиар өслөө. Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын аж үйлдвэрлэлийн салбарын сэргэлт, өндөр хөгжилтэй орнуудын төсвийн тэлэлт нь металлын үнэ өсөхөд нөлөөллөө. Барилга, үйлдвэрлэлийн салбарт түлхүү ашиглагддаг, зэс, төмрийн хүдэр болон цахилгаан машины батарей үйлдвэрлэлийн орц болох кобальт, никелийн үнэ илүү хурдацтай нэмэгджээ. ОУВС-гийн 2021 оны 4 дүгээр сарын төсөөллөөр суурь металлын үнийн индекс 2022 онд 4.5 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

Суурь төсөөллөөр Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2021 онд 7.6 хувь, 2022 онд 4.6 хувь байх тооцоололтой байна. Засгийн газраас цар тахлын тархалтыг хумих зорилгоор 2021 оны 2, 3 дугаар сард тогтоосон хатуу хөл хорио нь эхний хагас жилийн эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй байсан ч вакцинжуулалтын хурд нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт 2 дугаар хагаст огцом сэргэх төлөвтэй байна. Харин 2022 онд дотоод эрэлт сэргэн уул уурхайн бус салбар идэвхжих хандлагатай байгаа хэдий ч Оюутолгойн зэсийн баяжмал, түүний алтны агууламж буурсны улмаас уул уурхайн үйлдвэрлэл буурахаар байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулахаар байна. Энэ оны болон ирэх оны эдийн засгийн өсөлтийг Монголбанк 2021 оны 2, 3 дугаар сард харгалзан 6.1 хувь, 5.3 хувь, ДБ 2021 оны 1 дүгээр сард харгалзан 4.3 хувь, 5.4 хувь, АХБ 2020 оны 9 дүгээр сард 2021 оны өсөлтийг 4.8 хувь, 5.7 хувь тус тус байхаар төсөөлж байна.

Монголбанкны тооцооллоор инфляц 2021, 2022 оны эцэст 7.2 болон 5.8 хувьтай байх төсөөлөлтэй байна. Иймд Монголбанкны 2021 оны 3 дугаар сарын байдлаар тооцсон инфляцын хүлээлтийг тооцоо судалгаандаа авч ашиглав. Инфляцын түвшин 2021 онд бага зэрэг өсөхөөр байгаа нь энэ онд шатахууны

үнэ нэмэгдэх төсөөлөлтэй байгаатай холбоотой. Ирэх оны хувьд дотоод эрэлт тогтворжиж, инфляц зорилтот түвшний орчимд тогтворжих хандлагатай байна.

Эдийн засгийн өсөлт дунд хугацаанд тогтворжиж 2023, 2024 онд 6.3 болон 6.4 хувьтай байх төсөөлөлтэй байна. Эдийн засгийн өсөлт 2021 оны сүүлийн хагасаас сэргэн 2022 онд тогтворжиж

эхэлснээр эдийн засгийн өсөлт дунд хугацаанд буюу 2022-2024 онд дунджаар 6.0 хувийн өсөлттэй байхаар байна. Засгийн газраас төсвийн тогтвортой байдлыг хангаж, инфляцын түвшинг дунджаар 6.0 хувьд барьж макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаснаар гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх төсөөлөлтэй байна.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахын зэрэгцээ хөгжлийн бодлогын дээрээс доош, доороос дээш төлөвлөх арга зүйг хослуулан ашиглалаа. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 10.2-т заасан (i) Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх, (ii) санхүүжилтийн баталгаат эх үүсвэртэй, төслийн хариуцагчтай, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжих төсөл, арга хэмжээний задаргаатай байх гэсэн хууль зүйн шаардлагыг хангах замаар төлөвлөлтийг боловсруулав.

Жилийн төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулахдаа олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдын тоон болон чанарын судалгаанд үндэслэн хөгжлийг хязгаарлаж буй тулгамдсан, зангилаа асуудлууд, гарч буй хүндрэлүүдийг эрэмбэлэн тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн нэмэгдэл өртөг өндөртэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортод гаргах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, тэдгээрээр дамжуулан макро түвшний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох дунд хугацааны хөгжлийн зорилтыг хангах арга хэмжээг уялдуулан томъёоллоо.

Арга хэмжээг тодорхойлохдоо тодорхой байх, хэмжиж болохуйц байх, зорилгодоо хүрч болохуйц байх, бодитой байх, цаг хугацаатай байх гэсэн төлөвлөлтийн үндсэн шалгуурыг баримталснаас гадна арга хэмжээний зорилтот түвшин,

шаардагдах хөрөнгийг хамтад нь тооцсон болно.

Дээрээс доош чиглэсэн төлөвлөлтийг боловсруулахдаа урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн залгамж чанар, уялдаа холбоос болон тогтвортой байдлыг хангасан. Үүнд, Алсын хараа-2050, урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө зэрэг баримт бичгүүд орсон болно.

Төлөвлөлтөд эдийн засгийн өсөлтийн хувилбаруудыг 2016 оны Нийгмийн тооцооны матрицыг 2020 оны холбогдох тоон үзүүлэлтээр шинэчлэн байгуулж, үр дүнг нь ашигласан. Ингэснээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох ДНБ-ий төсөөллийг үйлдвэрлэлийн голлох 20 салбар болон эцсийн ашиглалтын бүрэлдэхүүний түвшинд тооцлоо. Тооцооллын загварт Засгийн газрын зардлын бүрэлдэхүүн хэсгүүдээс гадна дотоод, гадаад хөрөнгө оруулалт, экспорт, импортын голлох бараа, түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ, инфляц, ажиллах хүчний өсөлт, ажилгүйдлийн түвшин зэргийг тусгасан. Тооцоолол үндсэн хувилбараас гадна өөдрөг болон гутранги хувилбараар мөн хийгдсэн.

Доороос дээш төлөвлөлт буюу яам, агентлаг, орон нутгийн түвшинд арга хэмжээг төлөвлөхдөө Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.5 дахь заалтад заасны дагуу төрийн захиргааны төв, төрийн

захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудаас 1800 гаруй санал авч, нэгтгэсэн.

Төрийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг төлөвлөгөөний нэгдсэн төсөлд тусгахдаа тухайн арга хэмжээ нь Монгол Улсад хэрэгжиж буй урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдаж буй байдал, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмэр, үр дүн, ач холбогдол, уг арга хэмжээг хэрэгжүүлэх нэн тэргүүний хэрэгцээ шаардлага байгаа эсэх болон арга хэмжээг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл, бэлтгэл хангагдсан байдал, санхүүгийн эх үүсвэр баталгаатай эсэх зэрэг нөхцөл, шаардлагуудыг харгалзан үзсэн болно.

Бүлэг 1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого

Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Энэ зорилгын хүрээнд эрүүл мэнд, боловсрол, бизнесийн салбарын 8 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд тэдгээр нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Дээрх арга хэмжээ нь нийтдээ 300.3 тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 2.7 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 297.6 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр тус тус санхүүжигдэх бөгөөд 2 аймагт Зоонозын өвчин судлалын төв, хил дагуух 10 боомтод тандалтын нэгж байгуулагдаж, 5 аймгийн Нэгдсэн эмнэлэг (НЭ), Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (БОЭТ)-д

бодит хугацааны полимеразын гинжин урвал (БХПГУ) төхөөрөмжтэй болж, лабораторийн чадавх нэмэгдсэн байна.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг хангах, судалгаа, шинжилгээний ажлыг идэвхжүүлж бодлогын төлөвлөлтийг сайжруулах, орон нутгийн дэд бүтцийг сайжруулах нөхцөл бүрдэнэ.

Бүлэг 2. Хүний хөгжлийн бодлого

Энэхүү бүлгийн хүрээнд хүн төвтэй нийгмийн хөгжлийг цогц байдлаар авч үзсэн бөгөөд иргэдийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, боловсрол, нийгмийн хамгаалал, түүнчлэн эрдэм шинжилгээ, судалгаа, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг багтаасан 6 зорилго, 75 арга хэмжээг тусгасан.

Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ нь нийтдээ 148.1 тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 123.65 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 21.9 тэрбум төгрөг болон 2.55 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрээр тус тус санхүүжигдэх бөгөөд энэ хүрээнд Улаанбаатар хотод сүрьеэгийн эмнэлэг, эрхтэн шилжүүлэн суулгах төв, зүрх судасны мэргэшсэн төв, Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг, орон нутагт шаардлагатай 10 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулагдана.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр халдварт өвчний өвчлөл, хүн амын дундах элэгний В, С вирусийн халдварын тархалтыг бууруулж, гадаад улс руу урсах эрүүл мэндийн зардлыг багасгаж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны

салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нь нийтдээ 28.4 тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 3.4 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 25 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр тус тус санхүүжигдэх бөгөөд энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлж, нийслэлийн усан бассейн бүхий спорт цогцолборын ажлыг үргэлжлүүлж, Баянзүрх, Налайх дүүргийн спортын цогцолборыг ашиглалтад оруулна.

Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нь нийтдээ 83.2 тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 27.7 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 5.5 тэрбум төгрөг болон 50.0 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрээр тус тус санхүүжигдэх бөгөөд энэ хүрээнд 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байрыг төвлөрсөн болон бие даасан ариун цэврийн байгууламжтай болгож, зорилтот бүлгийн өрхийн хүүхдэд зориулсан 10 бүлэг нээж, сургууль, цэцэрлэгийн сүлжээний дэд бүтэц, тоног төхөөрөмжийг сайжруулах ажлууд хийгдэнэ.

Шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нь нийтдээ 2.05 тэрбум төгрөгийн улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжигдэх бөгөөд энэ хүрээнд инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах ажлыг эрчимжүүлж, хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор, их сургуулиудыг түшиглэн хөгжүүлнэ.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр багш нарын ур чадвар дээшилж, сурагчдын үнэлгээг олон улсын аргачлалаар үнэлдэг болохоос гадна нийгмийн эмзэг бүлгийн

хүн амд чиглэсэн боловсролын үйлчилгээг үзүүлж, сургууль цэцэрлэг, дотуур байр ариун цэврийн байгууламжаар хангагдана.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулж, хөдөлмөр эрхлэлтээр дэмжигдсэн дундаж давхаргын хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нь нийтдээ 14.03 тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 3.2 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 10.6 тэрбум, 250 сая төгрөгийн бусад эх үүсвэрээр тус тус санхүүжигдэх бөгөөд энэ хүрээнд нийгмийн даатгал болон нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх эрх зүйн шинэчлэл хийгдэж, бүртгэл, мэдээллийн тогтолцоо цахимжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв 6 аймагт байгуулагдана.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ялангуяа өрхөд үйлдвэрлэл эрхлэх, аж ахуйгаа хөтөлж, ажлын байраа өргөжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж бүрдэж, халамжаас-хөдөлмөр эрхлэх иргэдийн тоо нэмэгдэж, өрх бүрийн гишүүд ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдэнэ.

Монгол өв соёлыг дээдэлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нь нийтдээ 15.7 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх бөгөөд соёлын салбарт томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлж, соёлын барилга, байгууламж баригдана.

Бүлэг 3. Эдийн засгийн бодлого

Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангахын тулд бодит салбаруудыг дэмжсэн бүтээн байгуулалтын арга хэмжээг оновчтой төлөвлөж, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн 91 арга хэмжээ тусгагдсан бөгөөд нийтдээ 8,472.7

тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 372.5 тэрбум, орон нутгийн төсвөөр 87.8 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 1,325.03 тэрбум төгрөг, концесс, төрхувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 1,052.9 тэрбум төгрөг болон 5,634.5 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрээр тус тус санхүүжигдэнэ.

Эдийн засгийн салбаруудын бүтээн байгуулалтын арга хэмжээний хүрээнд Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор болон Газрын тос дамжуулах хоолой барих ажлыг үргэлжлүүлж, Эрдэнэт үйлдвэр Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-ыг түшиглэн уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн парк, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр болон исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэрийг барьж, байгуулна.

Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах зорилгоор Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц, Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, дулааны II цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлж, Чойр-Сайншанд 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар тус тус нэмэгдүүлнэ.

Аялал жуулчлалын салбарт ач холбогдол бүхий зам барилгын ажлыг эхлүүлж, “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I, II”-ийг хэрэгжүүлж, “Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор”-ын ажлыг цогц байдлаар дуусгаж, олон улсад таниулах ажлыг зохион байгуулж, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бэлдэж чадавхжуулна.

Хөдөө аж ахуйн салбарт усалгаатай талбайг 500 га-д, махны нөөцийг 20.0 мянган тонн, өвлийн улиралд хүн амд

нийлүүлэх шингэн сүүг 22.0 сая литрт тус тус хүргэнэ. Цахим хөдөө аж ахуй, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлж, 10 загвар хоршоотой болсон байна.

Тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр зам, 250 км тусгай зориулалтын авто зам, Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэж, цахилгаанаар цэнэглэх 20 цэг, хийгээр цэнэглэх 10 станц байгуулна.

Барилга, хот байгуулалтын салбарт импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, тогтвортой, ухаалаг, ногоон хот, ногоон барилгын үйл ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх үндсэн зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан. Тухайлбал, барилгын хавтгай шилний үйлдвэр, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.

Бүлэг 4. Засаглалын бодлого

Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, чадавхжуулах, нийгэмд шударга ёсыг тогтоох, хуулийн засаглалыг бэхжүүлэх, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, цахим үйлчилгээг хөгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ил тод, шударга, хараат бус байдлыг бэхжүүлэх зэрэг зорилго, арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь иргэн төвтэй засаглалын үндсэн суурь байх бөгөөд хэрэгжүүлэх 59 арга хэмжээ тусгагдсан.

Дээрх арга хэмжээ нь нийтдээ 193.1 тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 74.1 тэрбум, орон нутгийн төсвөөр 248 сая төгрөг, гадаадын зээл, тусламжаар 111.4 тэрбум төгрөг болон 7.3 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрээр тус тус санхүүжигдэх бөгөөд төрийн үйлчилгээг цахимжуулж, сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбох, хаягийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох, хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд мэдээлэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлэх болон хилийн чанад дахь иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, цахим үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Бүлэг 5. Ногоон хөгжлийн бодлого

Энэхүү бүлгийн хүрээнд эх байгалиа хайрлан хамгаалж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн 18 арга хэмжээ тусгагдсан бөгөөд тэдгээр нь нийтдээ 315.6 тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 149.4 тэрбум, орон нутгийн төсвөөр 23.6 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 1.2 тэрбум төгрөг, концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 141.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр тус тус санхүүжигдэнэ.

Энэ хүрээнд Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулах, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, ой хамгаалал, ойжуулалтын ажлыг чанаржуулах, ойн нөхөн сэргээлт хийх, уул уурхайн олборлолтын улмаас эвдэрч орхигдсон талбайг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээнүүд тусгагдсан.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотын агаар дахь PM_{2.5}

тоосонцрын агууламжийг 50 мкг/м³, PM₁₀ тоосонцрын агууламжийг 107 мкг/м³-д хүртэл бууруулж, орон нутагт 200-аас доошгүй га талбайд цөлжилтийг сааруулж, 8.0 мянгаас доошгүй га талбайд ойжуулалт нөхөн сэргээлт хийж, уул уурхайн олборлолтын улмаас эвдэрч орхигдсон 2,000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.

Бүлэг 6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого

Энэхүү бүлгийн хүрээнд Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх, бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн 12 арга хэмжээ тусгагдсан бөгөөд нийтдээ 449.5 тэрбум төгрөгөөр, үүнээс улсын төсвөөр 96.1 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 353.35 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр тус тус санхүүжигдэнэ.

Энэ хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт дулаан хангамжийг сайжруулах, ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, орон сууц барьж байгуулах, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах зэрэг арга хэмжээнүүд тусгагдсан.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барьж, “Ногоон нуур 1,008 айлын орон сууц төсөл” хэрэгжиж, “Залуус-1” орон сууцны хорооллын зураг төсөл, инженерийн бэлтгэл ажил хангагдаж, 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам, сүлжээ, дулаан түгээх төв шинээр баригдаж, 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

ТАВ. ТӨСӨВ, САНХҮҮ, МӨНГӨНИЙ БОДЛОГЫН УЯЛДАА

5.1. Сангийн болон төсвийн бодлого

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар улсын болон орон нутгийн төсвийг хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөх эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсон. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.5.1-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах, 9.5.3-т улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв,

хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах үүрэгтэй гэж заасан. Түүнчлэн, мөн хуулийн 9.4.3-т заасны дагуу үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх зохицуулалттай.

Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, батлагдсан төсвийн дүн, тэрбум төгрөг

	2020	2019	2018	2017	2016	2015	2014	2013	2012	2011
Үндсэн чиглэл	11,022.1	8,750.3	7,771.4	5,376.2	4,054.1	1,224.0	889.1	4,345.0	3,530.7	3,836.9
Батлагдсан төсөв	11,653.3	11,266.1	12,411.1	15,346.0	11,361.9	6,797.9	6,608.4	5,820.4	4,889.9	3,605.4
Зөрүү дүн	-631.2	-2,515.8	-4,639.7	-9,969.9	-7,307.8	-5,896.9	-5,705.8	-1,475.5	-1,359.2	231.5
Зөрүү (хувь)	-5	-22	-37	-65	-64	-87	-86	-25	-28	6

Эх сурвалж: Жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоол, төсвийн тухай хууль

Дээрх хүснэгтэд Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаж батлагдсан төсвийг сүүлийн 10 жилийн байдлаар харуулсан бөгөөд 2011 оноос бусад онд тухайн жилийн батлагдсан төсөв нь үндсэн чиглэлд тусгагдсан дүнгээс харьцангуй өндөр, ялангуяа 2014-2018 онд 37.0-87.0 нэгж хувиар зөрүүтэй байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн төсөлд заасан хязгаарлалтыг үндэслэн боловсруулав. Энэхүү баримт бичигт нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээг 2022 онд 14.9 их наяд төгрөгөөр, төсвөөс санхүүжих халамжийн зардлын нийт дүнг 851.3 тэрбум төгрөгөөр тус тус баталсан.

Хүснэгт 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2022*	2023*	2024*
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ (хувь)	4.6	6.3	6.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ (тэрбум төгрөг)	13,206.4	14,515.2	15,958.4
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	28.9	28.8	27.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ (тэрбум төгрөг)	14,852.0	15,925.1	17,113.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.5	31.6	29.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ (тэрбум төгрөг)	900.4	1,073.0	1,188.2
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	2.1	2.1
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (тэрбум төгрөг)	-1,645.6	-1,409.8	-1,154.9
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-3.6	-2.8	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ (тэрбум төгрөг)	3,768.9	4,151.5	4,761.2
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.2	8.2	8.2
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр (тэрбум төгрөг)	27,073.7	27,961.9	29,984.7
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	59.2	55.5	50.2
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ (тэрбум төгрөг)	851.3	902.4	956.5
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.9	1.8	1.7

Эх сурвалж: Сангийн яам

Хөгжлийн төлөвлөгөөнд Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн нөөц боломжтой уялдуулан 6 бүлэг, 23 зорилго, 263 арга хэмжээний хүрээнд нийтдээ 10 их наяд 22 тэрбум 668 сая 100 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр тусгалаа. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 870 тэрбум 427 сая 400 мянган төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 111 тэрбум 688 сая төгрөг, гадаадын зээл, тусламжаар 2 их наяд 151 тэрбум 611 сая 700 мянган төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 1 их наяд 194 тэрбум 290 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 5 их наяд 694 тэрбум 651 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

5.2. Мөнгөний болон макро зохистой бодлого

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд Монголбанкны саналыг авч, холбогдох арга хэмжээний төслийг нэгтгэлд тусгав. Монголбанкны Ерөнхийлөгч 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 1-1-211 тоот албан бичгээр ирүүлсэн (1) банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэх, (2) мөнгөугаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, (3) санхүүгийн шинэ технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэх зэрэг ажлыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилго нь Мөнгөний бодлоготой нийцтэй байна.

* Төсөөлөл

Монголбанкнаас эдийн засгийг хямралаас гаргаж, дунд хугацааны тогтвортой байдлыг хангах үндсэн чиглэлийг баримталж байна. Инфляцыг нэмэх, хасах 2 нэгж хувийн интервалтай 6 хувийн орчимд тогтворжуулах зорилгод шилжин инфляцын хэлбэлзлийг бууруулж, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн нөхцөлтэй уялдсан бага түвшинд тууштай бууруулах бодлогыг хэрэгжүүлэх нь эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндэс болно.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө нь Монголбанкнаас хэрэгжүүлж буй макро зохистой бодлоготой нийцэж байна. Дэлхийн улс орнууд олон улсын санхүүгийн зах зээлийн хямралын дараа санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн макро зохистой бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Монгол Улс энэхүү туршлагын дагуу макро зохистой бодлогын эрх зүйн орчныг Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд тусгаж, холбогдох шийдвэрийг 2018 оноос гарган хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4. Макро зохистой бодлогын шийдвэр

№	Бодлогын шийдвэр	Хэрэгжиж эхэлсэн огноо	Зорилго
1	Иргэдийн хэрэглээний зээлд Өр-орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох	6/15/2018	Иргэдийн өрийн дарамтыг хязгаарлаж улмаар санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх
2	Ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх	1/1/2019	Өрхийн өр, импортыг нэмэгдүүлж, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх
3	Тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 60 хувиар шинэчлэн тогтоох	4/1/2019	Сүүлийн жилүүдэд хурдацтай өсч, өндөр түвшинд хүрсэн хэрэглээний зээл, иргэдийн өрийн дарамтыг цалингийн өсөлттэй уялдуулан аажмаар бууруулах

Эх сурвалж: Монголбанк

5.3. Бүтцийн өөрчлөлтийн бодлого

Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгоход мөнгө, сангийн бодлогоос гадна бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Эдийн засгийн ихэнх асуудлыг төсөв, мөнгөний бодлогоор шийдвэрлэх боломжтой ч урт, дунд хугацааны олон тулгуурт эдийн засгийн өсөлтийг бий болгоход төсөв, мөнгөний бодлого дангаараа хангалтгүй байдаг. Иймд эдийн засгийн өрсөлдөх чадвар, бүтээмж, зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх

нийлүүлэлтийн талын бодлогыг давхар хэрэгжүүлдэг. Бүтцийн өөрчлөлтийн бодлогыг оновчтой тодорхойлохын тулд эдийн засгийн, ялангуяа голлох салбар, зах зээлийн цогц судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэж, бодлогын санал боловсруулдаг билээ.

Бүтцийн өөрчлөлтийн бодлогын суурь судалгааны нэг нь эдийн засгийн өсөлтийн шинжилгээ байдаг. Засгийн газраас хөгжлийн бодлогын олон зорилт дэвшүүлдэг хэдий ч ихэнх тохиолдолд (i) эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг зөв оношилж, онилж

чаддаггүй, (ii) улс төрийн хүчин зүйлс, төрийн чадавхаас шалтгаалан энэхүү бодлогоо хэрэгжүүлэх боломж, бололцоо хязгаарлагдмал байдаг. Иймд эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг тодорхойлж, уг асуудлыг нэн тэргүүнд шийдэх нь хөгжлийн бодлогын нэг чухал зорилт юм. Энэ хүрээнд дэлхийн улс орнуудын 1990-2005 онуудад авч хэрэгжүүлсэн эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын шинэчлэл нь ямар нөхцөлд үр нөлөөтэй, ямар нөхцөлд үр нөлөө багатай байсныг судалсны мөрөөр эдийн засгийн өсөлтийг хурдасгах стратегийг хүний хөгжил, бүтээмж, институцийн хөгжил талаас нь шинжилж, эдгээрийг хязгаарлаж буй дотоод хүчин зүйлсийг тодорхойлон үзлээ.

Сүүлийн 15 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийн шинжилгээ (growth diagnostics)-ний дүгнэлтээр хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хэрэгцээ шаардлагыг цохон тэмдэглэсэн байна. Эдгээр судалгаануудад бага орлоготой, байгалийн баялагтай, шилжилтийн эдийн засагтай Монгол Улсын нөхцөл байдлыг үнэлж, эдийн засгийн өсөлт нь хэдхэн салбараас хамааралтай, хөрөнгө оруулалтын дийлэнх нь уул уурхай, барилгын салбарын цөөн тооны компанид төвлөрдөг, тээвэр логистикийн салбар нь найдваргүй, өндөр зардалтай, гадаад худалдаа, гаалийн үйлчилгээ нь шат дамжлага, цаг хугацаа их шаарддаг, авлига өндөр, татварын систем нь бизнесийн орчинд ээлгүй, зохицуулалт сул байгаагаас хувийн хөрөнгө оруулалт бусад салбарт ордоггүй, санхүүгийн зуучлалын үр ашиг бага байгаагаас санхүүжилтийн зардал өндөр байхад хүргэж байна гэж дүгнэсэн. Өөрөөр хэлбэл, эдгээр асуудал нь тогтвортой, олон тулгууртай эдийн засгийн өсөлтийг бий болгох боломжийг хязгаарлаж байна гэж үзсэн.

Судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсын эдийн засгийг үндсэн 4 хүчин зүйлс хязгаарлаж байна гэж дүгнэв. Судалгааны ажлуудын үр дүнд үндэслэн эдийн засгийн өсөлтийг (i) макро эдийн засгийн тогтворгүй орчин, (ii) дэд бүтцийн хангалтгүй байдал, (iii) бизнесийн таагүй орчин, (iv) уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны доройтол зэрэг хүчин зүйлс хязгаарлаж байна гэж үзлээ.

Макро эдийн засгийн тогтворгүй орчин суурь асуудал гэж дүгнэв. Уул уурхайн салбарын өсөлтийг дагасан төсөв, мөнгөний бодлого хөөс-хагарал гэсэн мөчлөгийг үүсгэж ирсэн нь эдийн засгийн тогтвортой, олон тулгуурт өсөлтийг хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл, төсвийн болон мөнгөний бодлого нь бизнесийн мөчлөгийн оргил, уналтын жилүүдэд нэг чиглэлд хэрэгжиж ирснээс эдийн засгийг тогтворжуулахгүй, савлуулах, хөгжлийг ухраах нөхцөл байдалд хүргэж ирлээ.

Эдийн засгийн суурь дэд бүтэц хангалтгүй, зах зээлтэй сул холбогдож байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хоёр дахь гол хүчин зүйл гэж үзэв. Үе үеийн засгийн газар уул уурхайн салбараас орж ирсэн орлогыг эдийн засгийн суурь дэд бүтцийг сайжруулахаас илүүтэй халамжийн бодлогод зарцуулж ирснээр эдийн засгийн бүтээмжийг дорвитой нэмэгдүүлж чадсангүй. Цахилгаан, дулаан, усан хангамжтай холбогдсон, найдвартай байдал болон үр ашиг нь эдийн засаг дахь бүтээмж, салбарын хөрөнгө оруулалтыг тодорхойлж байна. Түүнчлэн гадаад, дотоодын зах зээлд холбогдох тээвэр, логистик, мэдээллийн технологийн үйлчилгээний хүртээмж, зардал нь эдийн засгийн өсөлтийг хязгаарласан хэвээр байна. Тухайлбал, экспортын голлох бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, нийлүүлэлтийн тоо хэмжээг олборлох үйлдвэрлэлийн хүчин чадал, технологи

биш автомашин, төмөр замын тээврийн хүчин чадал, гаалиар нэвтрэх тоо, хугацаа хязгаарлаж байна.

Дараагийн хязгаарлалт нь бизнесийн орчин гэж дүгнэв. Хууль эрх зүйн орчин тогтворгүй, байнга өөрчлөгддөг болон авлига бүх түвшинд буурахгүй байгаа нь гадаадын хөрөнгө оруулагч, дотоодын бизнес эрхлэгчдийн нэн тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн төрийн бодлого, хуулийг хэрэгжүүлэх чадавх хангалтгүй, хуулийн хэрэгжилт, гүйцэтгэлийг хангуулах эрх зүйн чадамж сул, төрийн өмчит компаниудын зах зээл дээрх оролцооны үр дүн хангалтгүй, халамжийг хэт хавтгайруулан хөдөлмөрийн оролцоог бууруулсан нь зах зээлийн үр ашгийг багасгаж байна.

Уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны доройтол нь дөрөв дэх хязгаарлах хүчин зүйл болж байна. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт Монгол Улсад хүчтэй мэдрэгдэж, шуурга, үер, ган, зуд зэрэг байгалийн гамшиг үе үе тохиолдохын зэрэгцээ ой мод, усны эх үүсвэр хомсдох, хөрс эвдэрч бэлчээр доройтох зэргээр байгалийн нөөц багасч байгаа нь хөдөө аж ахуйн салбарт томоохон сорилт болж байна. Тухайлбал, “Монгол Улсын бэлчээрийн тогтвортой байдал” судалгаагаар бэлчээрийн ургамлын гарц багасч, шим тэжээлтэй ургамлын хувь багасахын зэрэгцээ зуны

халуунаас үүдэн мал бэлчих цаг багасч байгаа нь малын амьдын жин буурах, улмаар ашиг шим нь багасахад нөлөөлж байна. Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдол нь хөдөлмөрийн бүтээмжийг бууруулж, эдийн засгийн өсөлтийг хязгаарлах нэг хүчин зүйл болсон хэвээр байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан арга хэмжээнүүд бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, уул уурхайн бус салбарыг дэмжих зорилгын хүрээнд санхүү, хөдөлмөрийн зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр арга хэмжээ авахаар төлөвлөлөө.

5.4. Засгийн газрын төлөвлөгөөт ажил

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөнд дэвшүүлсэн Ковид-19 цар тахлын хүндрэлийн үед нийтийн эрүүл мэндийг хамгаалж, ажлын байрыг хадгалах, бизнесийг дэмжих, улмаар дунд хугацааны тогтвортой өсөлтийг хадгалахад чиглэсэн арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа харгалзан үзлээ.

Хүснэгт 5. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө

№	Голлох салбар, зах зээл	Дүн (тэрбум төгрөг)	Зорилго, нөхцөл
1	Ажлын байрыг дэмжих	2,000.0	- Ажлын байрыг хадгалах - Зээлийн хүү 3 хувь, хугацаа 3 жил - Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 1 жил - 500 сая төгрөг хүртэлх зээл
2	Залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	500.0	- 2 сарын хугацаанд 1 сая төгрөгийн тэтгэлэгт хамрагдана. - 1 сард 5,000 хүн сургалтад хамруулна. - Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны хөтөлбөрт хамруулна.

3	Орон сууцжуулах	3,000.0	- Зээлийн хүү 6 хувь, хугацаа 30 жил - Сар тутам 100 тэрбум төгрөгийн санхүүжилт - 217 мянган өрх орон сууцны хэрэгцээтэй
4	Монголбанкны дахин санхүүжилт (Репо)	2,000.0	- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих: 3 тэрбум төгрөг хүртэлх - Буцаан худалдах нөхцөлтэй үнэт цаас барьцаалсан санхүүжилт
5	Хөдөө аж ахуйг дэмжих	500.0	- Хаврын тариалалтын зээл - Ноолуур бэлтгэлийн зээл - Малчдыг дэмжсэн зээл - Өрхийн тариалан хөдөлгөөнийг өрнүүлж хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх
6	Стратегийн ач холбогдолтой төслүүд	2,000.0	- Эрдэнэс таван толгой ХК-ийн бонд - Алтанбулаг, Замын-Үүд боомтын шинэчлэл - Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос хангах дамжуулах хоолой - Солонго I, II, Баянголын амны орон сууцны хороолол - Эрдэнэбүрэн 90МВт-ын усан цахилгаан станц - Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц - Байгалийн хий дамжуулах хоолой - Улаанбаатар хот: Нийтийн ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл, төв цэвэрлэх байгууламж гэх мэт.
Нийт дүн		10,000.0	

Эх сурвалж: Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар танилцуулав. Ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд 5 дугаар сарын 17-ны байдлаар нийт 5,796.1 тэрбум төгрөгийн 52.7 мянган зээлийн хүсэлт ирүүлснээс 12,413 зээлдэгчид 882.1 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Эдгээр зээлдэгчдийн 2,129 нь аж ахуйн нэгж, 10,284 нь иргэн байна. 439.4 тэрбум төгрөгийн 3,585 хүсэлтээс татгалзсан бол 1,666.1 тэрбум төгрөгийн 11,633 хүсэлт судлагдаж байна. Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ 35.5 сая төгрөг бол аж ахуйн нэгжийнх 242.8 сая төгрөг байна.

Монголбанкны урт хугацаат репо санхүүжилтийн хүрээнд 5 дугаар сарын 17-ны байдлаар нийт 640.1 тэрбум төгрөгийн 2,676 зээлийн хүсэлт ирүүлснээс 1,957 зээлдэгчид 383.2 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Эдгээр зээлдэгчдийн 1,255 нь аж ахуйн нэгж, 702

нь иргэн байна. 85.1 тэрбум төгрөгийн 380 хүсэлтээс татгалзсан бол 171.8 тэрбум төгрөгийн 339 хүсэлт судлагдаж байна. Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ 119.4 сая төгрөг бол аж ахуйн нэгжийнх 238.6 сая төгрөг байна.

Орон сууцны ипотекийн зээлийн хүрээнд 5 дугаар сарын 17-ны байдлаар нийт 697.0 тэрбум төгрөгийн 8,991 зээлийн хүсэлт ирүүлснээс 3,598 зээлдэгчид 263.9 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. 147.4 тэрбум төгрөгийн 1,911 хүсэлтээс татгалзсан бол 292.0 тэрбум төгрөгийн 3,787 хүсэлт судлагдаж байна. Иргэдийн авсан зээлийн дундаж хэмжээ 73.3 сая төгрөг байна.

Хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд 5 дугаар сарын 17-ны байдлаар нийт 271.9 тэрбум төгрөгийн 3,944 зээлийн хүсэлт ирүүлснээс 2,165 зээлдэгчид 30.8 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. 1.2 тэрбум төгрөгийн 46 хүсэлтээс татгалзсан бол 238.5 тэрбум төгрөгийн 1,733 хүсэлт судлагдаж байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2022-2024 онд 6 орчим хувьд хүргэхээр зорьж байна. Засгийн газар Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлснээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг 2019 оны түвшинд хүргэж сэргээх зорилт тавьж байгаа бөгөөд төлөвлөгөөг хэрэгжүүлснээр 2021 оноос бизнесийн идэвхжил сэргэж, эдийн засгийн өсөлт 5.2 хувиас давах төсөөлөлтэй байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд энэхүү цогц төлөвлөгөөний агуулга, арга хэмжээг тусгалаа. Засгийн газраас баримталж

буй ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, халамжаас бүтээмж рүү шилжих зорилтын хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл, санхүүжилтийг нэмэгдүүлэх, орлого багатай өрхийн гишүүдэд мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах, хүн амын бүлгүүд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, хилийн боомтын шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд хүний биометр мэдээлэлд суурилсан орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, цахилгаан станц, орон сууц зэрэг асуудлыг тусгалаа.

ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд (i) Ковид-19 цар тахлын эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, ялангуяа вакцинжуулалтын хурд, шинээр үүсч болзошгүй вирус, (ii) экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлт, (iii) байгаль цаг уурын гэнэтийн өөрчлөлт зэрэг хүчин зүйл эрсдэл учруулж болзошгүй байна.

6.1. Вакцинжуулалт

Монгол Улс Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ), Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-д үйлдвэрлэсэн Астразенека, БНХАУ-ын Синофарм үйлдвэрийн Вероселл, Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Спутник-В болон Пфайзер гэсэн 4 төрлийн вакцинаар ард иргэдээ вакцинжуулж байна. Монгол Улс одоогийн байдлаар вакцинжуулалтын хурдаараа зургаадугаар сарын 4-ний байдлаар Зүүн Азид тэргүүлж, дархлаажуулалт хийж буй дэлхийн 146 орноос 15 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Дархлаа тогтохын тулд вакцины 2 тун шаардагддаг. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас Синофарм болон Астразенека вакцины нэгдүгээр тунг хийлгэснээс хойш тус тус 3-4 долоо хоног болон 8-12 долоо хоногийн дараа хоёрдугаар тунг хийхийг зөвлөж байна. Уг хугацаа Пфайзер вакцины хувьд 3 долоо хоног байгаа бол Спутник вакцины хувьд 3 долоо хоногоос 3 сарын хооронд байгаа юм. Зургаадугаар сарын 4-ний байдлаар улсын хэмжээнд нийт насанд хүрсэн хүн амынхаа 89.3 хувийг нэгдүгээр тун, 66.7 хувийг хоёрдугаар тунд хамруулаад байна.

Нийт насанд хүрсэн бүх иргэнийг вакцинжуулахад 4.1 сая вакцин

шаардлагатайгаас 3.6 сая вакцины нөөц Монгол Улсад байгаа юм. Коронавирусын халдвар анх гарах үеэр нийт хүн амынхаа 60 хувийг вакцинжуулахад сүргийн дархлаа тогтож энгийн амьдралд шилжих боломжтой гэж тооцоолж байв. Үүний дагуу насанд хүрсэн бүх иргэнийг вакцинжуулснаар сүргийн дархлаа Монгол Улсад тогтох байсан боловч энэхүү төсөөлөл өөрчлөгдөх хэд хэдэн үндсэн шалтгаан үүсээд байна. Үүнд:

- Ковид19 вирусын шинэ мутаци гарч ирсэн бөгөөд цаашид нэмж гарах хандлагатай. Үүнээс шалтгаалан өвчний тархалт болон нас баралтад хүргэх хувь өөрчлөгдөх магадлалтай.
- Вакцины дархлаажуулах хувь ялгаатай. Улмаар Монгол Улсын хувьд сүргийн дархлаа тогтооход хүүхдийг зайлшгүй вакцинд хамруулах шаардлага бий болоод байна.
- Вакцины дархлаа үүсгэх хугацаа хэр урт байгаа нь тодорхойгүй тул вакцинжуулалтад хамрагдсан иргэд тодорхой хугацааны дараа дахин халдвар авах эрсдэл бий.
- Насанд хүрсэн хүмүүсийн тодорхой хувь нь вакцин хийлгэхгүй байх магадлалтай.

6.2. Голлох түүхий эдийн үнийн өөрчлөлт

Монгол Улсын нийт экспортын 90 хувийг эзэлж буй зэс, нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ төсөөллөөс доош буурвал гадаад худалдаа, төсвийн орлогоор дамжин эдийн засгийн бүхий л секторт сөргөөр нөлөөлнө. Хөрөнгө оруулалтын банкууд голлон түүхий эдийн үнийн төсөөлөлдөө (i) цар тахлын эрсдэл, (ii) голлох эдийн засгийн төсвийн дэмжлэг төсөөллөөс бага байх, (iii) байгаль орчны

шинэ зохицуулалтын эрсдэлийг голлон анхаарч байна. Энэ удаагийн жилийн төлөвлөлтөд дээрх эрсдэлийг харгалзан үзсэн үнийн төсөөллийг ашигласны зэрэгцээ цар тахлын улмаас хөрш орнуудтай хийж буй худалдаанд гааль, тээврийн хязгаарлалт тавигдах эрсдэлийг авч үзлээ.

6.3. Засгийн газрын өрийн хязгаарлалт

Монгол Улсын төсвийг их хэмжээгээр тэлснээр, төсвийн алдагдлыг нэмэгдүүлж, улмаар арилжааны өндөр хүүтэй гадаад, дотоод зээллэгээр төсвийн алдагдлыг санхүүжүүлэх нь өрийн дарамтыг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог. Хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлснээр Засгийн газрын өрийн үлдэгдлийн өнөөгийн үнэ цэн буурч, өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацаа уртасч, жигнэсэн дундаж хүүгийн түвшин буурах боловч цаашдаа Засгийн газрын өрийн үйлчилгээний зардал болон валютын ханшийн эрсдэл нэмэгдэж, төсөв болон төлбөрийн тэнцэлд дарамт учирдаг. Энэ нөхцөлд Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтыг хязгаарлах, Засгийн газрын

өрийн багцын гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах шаардлага байна.

6.4. Цаг агаарын хүчин зүйлээс шалтгаалж гарах хүндрэл

Монгол Улсад барилга, газар тариалан, аялалжуулчлал зэрэг эдийн засгийн зарим салбаруудын үйлдвэрлэл, үйлчилгээ цаг агаарын эрс тэс уур амьсгалын улмаас хязгаарлагддаг онцлогтой. Тухайлбал, хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас өндөр байх, өвөлжилт хүндрэх тохиолдолд хөдөө аж ахуйн салбарын өсөлт, бүтээмж төсөөлсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна. Мөн 2020 онд малын тоо толгой буурсан нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, хүнсний бүлгийн үнийг хөөрөгдөх эрсдэл байгааг харуулж байна.

Сүүлийн үед газар хөдлөлтийн идэвхжил нэмэгдэж байгаатай холбогдон иргэдийн аюулгүй орчинд байх нөхцөл бололцоог хангах, шаардлагатай арга хэмжээг урьдчилан авахад хөрөнгө санхүүгийн дутагдалтай байдал эрсдэл үүсгэж болзошгүй байна.

ДОЛОО. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөл нь 6 бүлэг, 23 зорилго, 263 арга хэмжээг тусгаснаас гадна арга хэмжээний суурь болон зорилтот түвшин, шаардагдах санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр, дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал болон хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг тусгасан.

Төрийн байгууллагуудаас ирүүлсэн төсөл, арга хэмжээний саналыг жилийн төлөвлөгөөний төсөлд тусгахдаа улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн нөөц боломжтой уялдуулан шаардлагатай саналыг тусгасан.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 10 их наяд 22 тэрбум 668 сая 100 мянган төгрөгийн санхүүжилт шаардагдахаас улсын төсвийн хөрөнгөөр 870 тэрбум 427 сая 400 мянган төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 111 тэрбум 688 сая төгрөг, гадаадын зээл, тусламжаар 2 их наяд 151 тэрбум 611 сая 700 мянган төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 1 их наяд 194 тэрбум 290 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 5 их наяд 694 тэрбум 651 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.



БҮЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА**

НЭГ. МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

1.1. Макро эдийн засгийн 2020 оны урьдчилсан гүйцэтгэлд хийсэн шинжилгээ


1.1.1. Эдийн засгийн өсөлт

Эдийн засаг 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5.3 хувиар агшлаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний нэрлэсэн дүн 2020 онд 37.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 322.3 тэрбум төгрөгөөр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 18.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.0 их наяд төгрөгөөр буюу 5.3 хувиар тус тус буурсан байна. 2018 болон 2019 онд харгалзан 5.2 хувь болон 7.2 хувиар өссөн эдийн засаг ийнхүү буурсан нь Ковид-19 цар тахлын нөлөөтэй холбоотой юм.

Эдийн засгийн агшилтад үйлчилгээний салбарын бууралт голлон нөлөөлжээ. Эдийн засгийн 5.3 хувийн бууралтад боловсруулах үйлдвэр, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдааны салбарууд голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн салбараас бусад салбар уналттай байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар нь авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн нэмэгдэл өртөг л 6.2 хувиар өссөн ба үүнд мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн 6.3 хувийн өсөлт, ялангуяа малын ашиг шимийн бүтээгдэхүүний 5.9 хувийн өсөлт түлхүү нөлөөлжээ. Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 1.1 хувиар буурсан ба үүнд нэхмэл бүтээгдэхүүний салбарын бууралт хамгийн ихээр нөлөөлөв. Уул уурхай, олборлолтын салбарын нэмэлт өртөг 9.4 хувиар буурахад нүүрс, газрын тосны экспорт, олборлолтын бууралт нөлөөлжээ. Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 7.1 хувиар буурахад тээврийн салбарын 20.1 хувийн бууралт, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 11.1 хувийн бууралт, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний 29.7 хувийн бууралт голчлон нөлөөлсөн байна.

График 1. Эдийн засгийн өсөлт, үйл ажиллагааны салбараар, 2018-2020 он




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эцсийн хэрэглээний хувийн жин нэмэгдэж, хуримтлалын хувийн жин буурчээ. ДНБ-ий 2020 оны гүйцэтгэлийг эцсийн ашиглалтын аргаар авч үзвэл эцсийн хэрэглээ 71.3 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 24.3 хувь, цэвэр экспорт 4.4 хувийг тус тус эзэлж, өмнөх оноос эцсийн хэрэглээний жин 4.7 нэгж хувиар,


бараа, үйлчилгээний цэвэр экспортын жин 10.4 нэгж хувиар тус тус нэмэгдэж, хөрөнгийн нийт хуримтлалын жин 15.1 нэгж хувиар буурчээ. Ийнхүү 2020 онд эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 18.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 5.4 хувь буюу 1.0 их наяд төгрөгөөр буурсан байна.

График 2. ДНБ-ий бүтэц, эцсийн ашиглалтаар, хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Нэг хүнд ногдох ДНБ, 2016-2020 он, сая төгрөг



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нэг хүнд ногдох ДНБ 2020 онд 6.3 хувиар буурчээ. Эдийн засгийн өсөлт хурдацтай сэргэж эхэлсэнтэй холбоотойгоор нэг хүнд ногдох ДНБ-ий

өсөлт 2017-2019 онд дунджаар 4.1 хувиар өссөн хэдий ч цар тахалтай холбоотойгоор 2020 онд огцом агшиж, зэрэгцүүлэх үнээр 5.6 сая төгрөгт хүрчээ.

1.1.2. Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл, хариу арга хэмжээ

Ковид-19 цар тахал нь дараах сувгаар дамжин эдийн засагт хүчтэй нөлөөлж байна. Үүнд:

1. Экспортын орлогын бууралт нь дотоодын аж ахуйн нэгжүүдийн орлого буурахад нөлөөлж, улмаар хөдөлмөрийн зах зээлээр дамжин өрхийн орлогод сөргөөр нөлөөлж байна. Төсвийн орлого болон валютын нөөцийг голчлон бүрдүүлдэг уул уурхайн голлох бүтээгдэхүүний үнэ болон эрэлт буурсан нь уул уурхайн салбар огцом агшихад нөлөөлөхийн зэрэгцээ хөл хорионы арга хэмжээний улмаас тээвэр, агуулах болон боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа саарсан;

2. Хилийн боомтуудыг хаасантай холбоотойгоор үйлдвэрлэлийн түүхий эд, орцын нийлүүлэлт доголдсон;

3. Иргэдийн хүлээлт болон болгоомжлолоос үүдэлтэй худалдан авалтын эрэлт багассан;

4. Засгийн газар, иргэд, аж ахуйн нэгж болон эдийн засгаа дэмжих зорилгоор төсвийн зардлаа нэмэгдүүлснээр төсвийн алдагдал өсөх, дотоод болон гадаад өр нэмэгдэх зэрэг томоохон эрсдэл байсаар байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг удаашруулахад хүргэж байна;

5. Цар тахлаас урьдчилан сэргийлж хөл хорио тогтоосон нь хувиараа хөдөлмөр эрхлэгч болон хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг өрхүүдэд илүү нөлөөлжээ. Энэ нь ядуурлын төвшин огцом нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Дэлхий нийтийн вакцинжуулалт эрчимжин зарим улс оронд халдварын тархалт буурч байгаатай холбогдуулан хөл хориог хэсэгчлэн цуцлах, бизнесийн үйл ажиллагааг нээх, эдийн засгийг аажмаар идэвхжүүлэх бодлого баримталж байна. Манай улсын хувьд ч мөн адил эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хатуу хөл хориог бууруулах,

ариутгал, халдваргүйжүүлэлтийн горим сахиж бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.

Засгийн газраас 2020 онд Ковид-19 цар тахлыг даван туулахад зориулсан арга хэмжээнүүд:

1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах:

Хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Засгийн газраас эрүүл мэндийн салбарт нэн зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардалд 17 тэрбум төгрөгийн санхүүжилт нэмж олгосон.

- Эрүүл мэндийн салбарт гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжийн нэн шаардлагатай 20.6 тэрбум төгрөгийн дараах эх үүсвэрийг шийдсэн.

- АХБ - 4.2 тэрбум - 570 тоног төхөөрөмж

- ДБ - 6.0 тэрбум - 68 тоног төхөөрөмж

- БНСУ - 4.5 тэрбум - 16 тоног төхөөрөмж

- Бусад ОУБ - 6.0 тэрбум - 8,800 оношлуур, 118,000 хувийн хамгаалах хэрэгсэл авсан.

- Коронавируст халдварын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортоор оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх арга хэмжээ авсан.

2. Иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ:

- Иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ

- Ажлын байрыг хадгалахад чиглэсэн арга хэмжээ

3. Иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ:

- Монгол Улсын иргэний 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлсөн;
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулсан Монгол Улсын иргэний 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлж, даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцсон;
- Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор хэмнэгдсэн зардлаас 18 хүртэлх насны 1.1 сая хүүхдэд сар бүр 10,000 төгрөгийн мөнгөн дэмжлэгийг 3 сарын хугацаанд олгосон бөгөөд нийт санхүүжүүлсэн дүн 34,2 тэрбум;
- Иргэдийн тог, цахилгааны төлбөрийг 9 дүгээр сарын 1-нийг хүртэл чөлөөлсөн.

4. Ажлын байрыг хадгалахад чиглэсэн арга хэмжээ

- Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс буурсан ч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгосон.
- Цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа

боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн хуулийн этгээдэд 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд даатгуулагчаас төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцсон.

- Албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад албан татвар төлөгчийн 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод, мөн хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлсөн.
- 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагыг торгох шийтгэл, алдангиас тус тус чөлөөлсөн.
- 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд татвар төлөгч нь төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн татвар төлөгчийг нэг удаа чөлөөлсөн.
- 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч аж ахуйн нэгжид түрээсээ бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах албан татварын хөнгөлөлт эдлүүлсэн.

- 2020 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд элсэн чихэр, ургамлын тос, бүх төрлийн хүнсний будаа, 15.0 /арван таван/ мянган тонн элит үрийн улаан буудай, 160.0 /нэг зуун жаран/ мянган тонн хүнсний улаан буудайг импортлоход гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн.
- Дотоодын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилгоор 2021 оны 7 дугаар сарын 1-нийг хүртэл бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос болон

өвс, мал амьтны тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаан буудай, улаан буудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортын барааны гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж дотооддоо борлуулсан хүнсний будаа, ургамлын тос, өвс, мал, амьтны бүх төрлийн тэжээлийг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлсөн.

5. Эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ:

- Нүүрсний экспортыг сэргээсэн.

Хүснэгт 6. Нүүрсний экспортыг эхлүүлсэн боомт

Хилийн боомтуудад хийгдсэн бэлтгэл ажил	Нүүрсний экспортыг эхлүүлсэн боомт
<ul style="list-style-type: none"> • Тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх • Жолооч нарын хүнсний хангамж, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах 	Замын-Үүд: 2020 оны 3 дугаар сарын 3
	Гашуунсухайт: 2020 оны 3 дугаар сарын 23
	Шивээхүрэн: 2020 оны 3 дугаар сарын 30
	Ханги: 2020 оны 3 дугаар сарын 31

Эх сурвалж: Сангийн яам

- Ариутгал, халдваргүйжүүлэлт, эрүүл ахуйн горимын дагуу иргэдийг эрүүл, аюулгүй орчинд үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлсэн үйлдвэр, үйлчилгээний газруудыг үйл ажиллагаагаа хэвийн

үргэлжлүүлэх боломжоор хангаж ажилласан.

- Хөнгөлөлттэй зээл тусламжийн эх үүсвэрийг ашигласан.

Хүснэгт 7. Ковид-19 үеийн төсвийн дэмжлэгийн тухай

Төсвийн дэмжлэг	Шинээр хэрэгжих төслүүд
ОУВС хөтөлбөрийн хүрээнд төсвийн дэмжлэг: - АХБ: 60.0 сая ам долларын үлдэгдэл санхүүжилт - Европын холбоо: 47.1 сая ам долларын тусламж	720.0 сая ам долларын хүнсний үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл, ХАА, дэд бүтэц зэрэг салбарт 14 төсөл хэрэгжүүлнэ.
Шинээр авах төсвийн дэмжлэг: - АХБ: 200.0 сая ам доллар хүртэл зээл (2020 оны 5 дугаар сарын 24 хүртэл)	
Бусад: - 100.0 сая ам доллар хүртэл зээл	

Эх сурвалж: Сангийн яам

- Эдийн засгийг төрөлжүүлэх, дэмжих, ажлын байр бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар

хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг идэвхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авсан (2020 оны нийт хөрөнгө оруулалт 3.1 их наяд төгрөг, 1,500 гаруй төсөл хөтөлбөрийн хүрээнд 15,000

гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, 150,000 гаруй үр шимийг нь хүртэх ажилчид).

- Дотоодын аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийхдээ нэн тэргүүнд үндэсний үйлдвэрлэгчийг шалгаруулж байх зарчим баримталсан.
- Барьцаа хөрөнгийн дутагдалтай 500 ААН-ийн 300.0 сая төгрөг хүртэлх зээлд (нийт 108,3 тэрбум төгрөг) 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл батлан даалт гаргасан.
- Малчдын ноолуур худалдан авахад зориулан нийт 233,000 малчин өрх, 47 ААН-д 3 хувийн хүүтэй 300.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2020 оны 4 дүгээр сарын 1-ээс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл үйлдвэрлэгчдэд олгосон.
- Хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд Хөдөө аж ахуйг дэмжих сангаас худалдах тоног төхөөрөмжийн үнийг 50 хувь хөнгөлсөн.

(Нийт 1,500 ААН-д 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 34.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн)

- Дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлж төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах, боловсролын алсын зайн сургалтын үйлчилгээг үзүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах хяналт бүхий цахим худалдааг дэмжих, импортын бүтээгдэхүүнийг орлохуйц, дотоодын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардлагатай үнэ, тарифын хөнгөлөлтийг үзүүлсэн. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
- Төсвийн тухай хуулийн 12.1.17-д заасны дагуу төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан төсвийн хэмнэлтийн горимд 2020 оны 2 дугаар сарын 19-нөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал шилжсэн.

Хүснэгт 8. Төсвийн зардлын эрэмбийн тухай

Ач холбогдлоор нь санхүүжилтийг эрэмбэлэн заавал олгох	Санхүүжилтийг бүрэн зогсоох
<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн салбарын санхүүжилт - Бүх төрлийн тэтгэвэр тэтгэмж, халамж - Цалин хөлс - Цахилгаан, дулааны зардал - Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал 	<ul style="list-style-type: none"> - Гадаад дотоод томилолт - Зочин төлөөлөгчийн зардал - Тавилга эд хогшлын зардал - Их засварын зардал - Хурал зөвлөгөөний зардал - Тэвчиж болох бусад бүх зардал

Эх сурвалж: Сангийн яам

Үүсээд буй нөхцөл байдалд дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн:

2021 оны 5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд өдөрт дунджаар 600 гаруй тохиолдол илэрч байгаа нь цаашид халдварын тохиолдлыг бууруулах, эдийн засгаа хамгаалах арга хэмжээг цаашид

үргэлжлүүлэн авах шаардлагатай болохыг харуулж байна.

Засгийн газраас боловсролын бүх түвшний танхимын сургалтын үйл ажиллагааг зогсоож, цахим болон теле хичээл оруулахаар шийдвэрлэсэн билээ. Боловсролын үйлчилгээнд гарсан энэхүү өөрчлөлт нь оюутан, сурагчдын гэр бүлийн

нөхцөл байдал, орлогын ялгаатай байдал, эцэг эхийн харилцан адилгүй анхаарал халамж зэргээс хамаарч суралцагчдын хичээлийн үр дүнд шууд нөлөөлж байна. Багш нар, сурагчдын цахимаар хичээл заах болон суралцах туршлага бага байгаа тул хичээлийн хоцрогдол үүсэх эрсдэлтэй байна. Цаашид танхимын хичээл хэзээ эхлэх нь тодорхойгүй байгаа нь хичээлийн хоцрогдлыг улам ихэсгэх эрсдэлтэй.

Засгийн газраас Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах үүднээс өрхийн амьжиргаа, эдийн засгийг дэмжих багц арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 2020 оны эхний 11 сарын байдлаар нийт бүртгэгдсэн гэмт хэргийн хохирогчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар буурч, эмэгтэй хохирогчдын тоо 28 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2020 оны эхний 11 сард 1,044 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.6 хувиар нэмэгдсэн, ГВХ гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас үйлдэгдсэн зөрчил 9,786 бүртгэгдэж, 2019 оны мөн үетэй харьцуулахад 18.9 хувиар өссөн байна.

Цагдаагийн шуурхай дуудлагын 102 утсанд нэг өдөрт ирдэг ГБХ-ийн дуудлагын тоо хатуу хөл хорио тогтоосон үед бусад өдрийнхөөс 2.4 дахин багассан байна. ГБХ-ийн дуудлага хатуу хөл хорио тогтоосон үед огцом буурсан хэдий ч өмнөх сартай харьцуулахад ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 42.7 хувь, зөрчлийн тоо 0.7 хувиар тус тус нэмэгдэж бүртгэгдсэн байна. Цар тахлын үед авч хэрэгжүүлж буй хөл хорио, хязгаарлалтын

улмаас хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нэмэгдэж байна¹.

Эдийн засгийн хувьд Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тодорхойлсон судалгааны ажлууд одоогоор хийгдээгүй байна.

1.1.3. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурал


Эдийн засаг дахь нийт ажилгүйдлийн түвшин 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 7.6 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурчээ. Хотын ажилгүйдлийн түвшин 8.6 хувь байгаа бол хөдөөгийн ажилгүйдлийн түвшин 5.0 хувьтай байна.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо 2020 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 30.0 мянга байсны 18.1 (60.4 хувь) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 11.9 (39.6 хувь) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Үүнээс бүртгэлтэй ажилгүй иргэдийн 9.5 (52.7 хувь) мянга нь эмэгтэйчүүд байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа нэгжүүд хэвийн байсан боловч хөл хорионы дэглэмээс шалтгаалж аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа алдагдах болон ихэнх иргэн биечлэн очиж үйлчлүүлэх боломжгүй зэргээс үүдэж ажил хайгч иргэдийн тоо буурсаар байна. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 12 дугаар сард 5.8 мянган хүн шинээр бүртгүүлсний 3.2 (54.6 хувь) мянга нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байгаа нь өмнөх сараас 400 (11.2 хувь) хүнээр буурчээ.

¹ НҮБ, Жендэрийн үндэсний хороо, АХБ-аас хийсэн Монгол Улсад Ковид-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөлөл судалгаа, 2021 оны 3 дугаар сар.

График 4. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, ажилгүй байгаа шалтгаан, 2020 оны эцэст, дүнд эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Бүртгэлтэй ажилгүй хоёр хүн тутмын нэг нь бүрэн дунд, гурван хүн тутмын нэг

нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой байна.

График 5. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшин, хүйс, 2020 оны эцэст, дүнд эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Насны бүлгээр авч үзвэл 15-24 насны ажилгүйдэл 2019 онд хамгийн өндөр байсан ба сүүлийн жилд 6.9 нэгжээр буурч 18.4 хувь болжээ. Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 53.9 хувийг

15-34 насны залуучууд эзэлж байна. Уг үзүүлэлт Сэлэнгэ, Өвөрхангай, Увс, Ховд, Говьсүмбэр, Өмнөговь, Дорнод аймагт улсын дунджаас 1.9-30.8 нэгж хувиар дээгүүр байна.

График 6. Ажилгүйдлийн түвшин, насны бүлгээр




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цар тахлаас үүдэлтэй хөл хорио нь ажиллах хүч ихтэй салбар болох бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр ба агуулахын салбарын ажиллагсад нэн хүндээр тусч байна². 2020 оны 4 дүгээр сард Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-аас хийсэн судалгаагаар 6,000 ажлын байрны тоо

буурсан байна. Зарим бизнес, аж ахуйн үйл ажиллагааг зогсоосноор хөдөлмөр эрхлэгчдийн 47 хувь нь цалин буурах, ажлын байраа алдах, түр зогсолт хийх зэрэг сөрөг үр дагавартай нүүр тулсан³. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 16 хувь нь орлогоо бүрэн алдсан бол дөрвөн аж ахуйн нэгж тутмын гурвынх нь орлого буурсан байна⁴.

График 7. Ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


² Б.Эрдэнэбат, Б.Соёлмаа, Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийн нөхцөл байдал, үзүүлэх нөлөө, хариу арга хэмжээний саналууд, 2020
³ Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Ковид-19 вирусн ажлын байрны нөлөөллийн судалгааны тайлан, 2020
⁴ А.Гантуяа, Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн жөндөрийн тэгш байдалд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөө, 2020

1.1.4. Ядуурал

Ядуурлын хамралтын хүрээний индекс буюу ядуурлын түвшин нь нийт хүн амд эзлэх ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын хувийг харуулдаг

бөгөөд уг үзүүлэлт 2018 онд 28.4 болж 2016 оныхоос 1.2 нэгж хувиар буурчээ. Бүсээр задалж харвал, 2018 онд Баруун бүс, Хангайн бүс, Төвийн бүс болон Зүүн бүст ядуурлын хамралтын хүрээ буурсан ч Улаанбаатар хотод ихэссэн байна.

График 8. Ядуурлын хамралтын хүрээ, хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүн амын хэрэглээ ядуурлын шугамаас хэдэн хувиар доогуур байгааг илэрхийлдэг ядуурлын гүнзгийрэлт 2018 онд 7.2 хувь болж, 2016 оныхоос 0.5 нэгж хувиар буурсан бол ядуучуудын тэгш бус байдлын зэргийг хэмждэг ядуурлын мэдрэмж 2.7 хувь болж, 2016 оныхоос 0.2 нэгж хувиар буурсан байна.

Хот суурин газарт ядуу хүн амын төвлөрөл нэмэгдэж байна. Хөдөө орон нутагт 2016-2018 оны хооронд ядуурал 4.1 нэгж хувиар буурсан бол хотод 0.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Ядуурлын түвшин хөдөө орон нутагт өндөр хэвээр байгаа боловч Монгол Улсын нийт хүн амын гуравны хоёр нь хот суурин газарт амьдарч байгаа нь ядуурал хот суурин газарт нэмэгдэхэд нөлөөлж байна. Хот суурин газарт амьдарч буй ядуусын эзлэх хувь 2016 онд 62.1 байсан бол 2018 онд

63.5 болж нэмэгдсэн бөгөөд 2018 оны байдлаар Улаанбаатар хотод нийт ядуу хүмүүсийн 41.8 хувь нь амьдарч байна. Бүс нутгийн хувьд авч үзэхэд Зүүн бүсэд ядуурал 6.6 нэгж хувиар, Баруун бүсэд 4.3 нэгж хувиар, Хангайн бүсэд 2.7 нэгж хувиар, харин Төвийн бүсэд ядуурлын түвшин 0.7 нэгж хувиар буурсан бол Улаанбаатар хотод 1.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

1.1.5. Дундаж цалин

2020 оны дөрөвдүгээр улирлын байдлаар хөдөлмөрийн насны 2.1 сая хүн байгаагаас 1.2 сая нь эдийн засгийн идэвхтэй байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 57 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53 хувь, ажилгүйдлийн түвшин 7.6 хувь байна.

Хүснэгт 9. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал


Үзүүлэлт	2019-IV	2020-IV	Өсөлт (хувь)
Ажиллах хүч	1,293,579	1,216,649	-5.95
Ажиллагчид	1,188,440	1,124,564	-5.37
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	11,107	8,198	-26.19
Ажилгүй хүн	105,139	92,085	-12.42
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	838,523	918,068	9.49
Боломжит ажиллах хүч	58,018	66,083	13.90
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	780,505	851,985	9.16
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	60.7	57.0	
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь	55.7	52.7	
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, хувь	12.9	13.0	
Ажилгүйдлийн түвшин, хувь	8.1	7.6	
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, хувь	9.	8.2	
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, хувь	12.1	12.3	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 оны эцсийн улирлын байдлаар сарын дундаж цалин улсын хэмжээнд 1,328.1 мянга байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад дундаж цалин 6.5 хувиар өсжээ. Эрэгтэйчүүдийн дундаж цалин 1,452.9 мянган төгрөг байгаа бол эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийнхээс 257.6 мянган төгрөгөөр бага буюу 1,195.3 мянган төгрөг байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл, хамгийн өндөр цалинтай нь уул уурхай олборлолтын салбар бөгөөд улсын дунджаас 1,664.9

мянган төгрөгөөр илүү буюу 2,934.0 мянган төгрөг, хамгийн бага цалинтай нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар бөгөөд улсын дунджаас 469.4 мянган төгрөгөөр бага буюу 799.7 мянган төгрөгийн сарын дундаж цалинтай байна. Аймгуудаар авч үзвэл, Орхон аймгийн дундаж цалин хамгийн өндөр ба улсын дунджаас 426.5 мянган төгрөгөөр илүү буюу 1,695.6 мянган төгрөг байхад хамгийн бага нь 867.6 мянган төгрөгийн дундаж цалинтай Архангай аймаг бөгөөд улсын дунджаас 401.5 мянган төгрөгөөр бага байна.

График 9. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин, 2016-2020 он, мянган төгрөг



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.1.6. Мөнгөний нийлүүлэлт, инфляц

2020 онд жилийн дундаж инфляц 3.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.6 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Жилийн

эцсийн инфляц өмнөх оноос 2.9 нэгж хувиар буурч 2.3 хувьд хүрсэн ба үүний 2.2 нэгж хувь буюу 95.7 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хүснэгт 10. Жилийн дундаж инфляц, 2016-2020 он


	2016	2017	2018	2019	2020
Инфляц	0.7	4.3	6.8	7.3	3.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цар тахлаас улбаалан өндөр байсан хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт харьцангуй тогтворжиж, дотоодын эрэлт буурч, тээврийн болон амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний үнэ буурч эрэлтийн гаралтай инфляц багассан нь

инфляц буурахад нөлөөлжээ. Инфляц 2021 оны 1 дүгээр сард 2.4 хувьтай байсан бөгөөд 37.5 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Харин Улаанбаатар хотын суурь инфляц оны эцэст 0.2 хувьтай гарсан нь 2020 оны хамгийн бага түвшин байжээ.

График 10. 2020 оны инфляцын бүтцийн задаргаа, сараар



Эх сурвалж: Монголбанк

Инфляцын хамгийн өндөр хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундааны үнийн өсөлт бүрдүүлж байгаа бол хамгийн

бага хувийг зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнийн өсөлт бий болгожээ.

График 11. Мөнгөний нийлүүлэлт, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 12 дугаар сарын эцэст 24.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.3 их наяд төгрөг буюу 16 хувиар өссөн бөгөөд үүнд валютын хадгаламж 1.2 (33.2 хувь) их наяд төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 2.2 (20.1 хувь) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Төгрөгийн хадгаламж 2020 оны 12 дугаар сарын эцэст 13.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 909.4 (7.3 хувь) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 2.2 (20.1 хувь) их наяд төгрөгөөр өсжээ. Төгрөгийн

хадгаламжийн 89.0 хувь (11.9 их наяд төгрөг) нь иргэдийн хадгаламж, 11.0 хувь (1.5 их наяд төгрөг) нь аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж байна. Валютын хадгаламж 4.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.2 (33.2 хувь) их наяд төгрөгөөр өсжээ. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 889.2 (4.9 хувь) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 (50.6 хувь) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

График 12. Төгрөгийн болон валютын хадгаламж, сар бүрийн эцэст, их наяд төгрөг




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын байдлаар 17.2 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс

4.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин чанаргүй зээл нийт өрийн үлдэгдлийн 11.7 хувийг эзэлж, өмнөх оноос 1.6 нэгж хувиар өсжээ.

График 13. Нийт зээл, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар




Эх сурвалж: Монголбанк

Хэвийн зээл 13.9 их наяд төгрөг буюу нийт зээлийн 80.9 хувийг эзэлж байгаа бол хугацаа хэтэрсэн зээл 1.3 их наяд төгрөг

болж өмнөх оны мөн үеэс 54.1 хувиар өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувийг эзэлж байна.

График 14. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл, нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

Хугацаа хэтэрсэн зээл 2019 онд өмнөх оноосоо буурсан ч 2020 онд 54 хувиар өссөн байна. Салбараар задалж үзвэл хувийн хэвшлийн зээлийн хугацаа хэтрэлт уг өсөлтөд хамгийн их нөлөөтэй байжээ.


1.1.7. Төлбөрийн тэнцэл, валютын хани, гадаад валютын нөөц

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 786.9 сая ам.долларын ашигтай гарлаа.

Төлбөрийн тэнцлийн урсгал болон хөрөнгийн дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 3.5 дахин буурч 571.8 сая ам.доллар, санхүүгийн дансны тэнцэл

1.8 дахин буурч 1,504.2 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад валютын цэвэр албан нөөц 4,534 сая ам.доллар хүрлээ. Энэ нь сүүлийн 3 сарын дундаж импортын 10.7 сарын хэрэгцээг хангах түвшин юм.

График 15. Төлбөрийн тэнцэл, 2017-2020 он, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

Урсгал дансны алдагдал буурахад гадаад худалдааны ашиг 53 хувиар буюу 609 сая ам.доллараар сайжирсан нь голлон нөлөөлжээ. Монгол Улс 2020 онд нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум ам.доллар болсны 7.6 тэрбум ам.долларыг экспорт, 5.3 тэрбум

ам.долларыг импорт эзэлж байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 6.4 хувь буюу 876.9 сая ам.доллараар буурч, экспорт 0.6 хувиар буюу 43.3 сая ам.доллараар, импорт 13.6 хувиар буюу 833.6 сая ам.доллараар тус тус багасжээ. Монгол Улсын нийт экспортын 72 хувийг БНХАУ-руу гаргасан экспорт эзэлж байна.

Хүснэгт 11. Худалдааны түнш орнууд, нийт дүнд эзлэх хувь


Экспорт болон импортын бүтэц	ОХУ	БНХАУ	Бусад
Экспорт	0.8 хувь	72.5 хувь	26.8 хувь
Импорт	26.4 хувь	35.8 хувь	37.8 хувь

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цар тахалтай холбоотойгоор дотоод эрэлт хумигдаж, импорт илүү хурдацтай саарснаар гадаад худалдааны тэнцэл

өмнөх оноос 52.9 хувиар сайжирсан байна. Ийнхүү худалдааны тэнцэл сүүлийн 3 жил дараалан өсч байна.

График 16. Экспорт, импорт, худалдааны тэнцэл, 2016-2020 он, сая ам.доллар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Экспорт 2020 онд өмнөх оноос 0.6 хувиар буурч 7.6 тэрбум ам.долларт хүрлээ. Экспортын

дийлэнхийг боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт, нүүрс, зэсийн баяжмалын бүтээгдэхүүний экспорт бүрдүүлжээ.

График 17. Экспортын зарим бүтээгдэхүүний үнийн дүн, мянган ам.доллар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Импорт 2020 онд 13.6 хувиар буюу 5.3 тэрбум ам.доллараар буурчээ. Импортын нийт үнийн дүнгийн дийлэнхийг хөнгөн тэрэгний импорт бүрдүүлсэн

бол дараа ньавто бензиний импорт орж байна. Цар тахлын тархалттай холбоотой хилийн хязгаарлалтууд болон эдийн засгийн бууралт гадаад худалдаа ийнхүү буурахад нөлөөлжээ.

График 18. Импортын зарим бүтээгдэхүүний үнийн дүн, мянган ам.доллар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Түүнчлэн үйлчилгээний худалдааны тэнцэл 1.4 тэрбум ам.доллар, анхдагч орлогын данс 1.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан нь урсгал тэнцлийн алдагдалд нөлөөлсөн байна. Урсгал дансны алдагдлыг шууд болон бусад хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байна.


Хөрөнгийн данс 2020 онд 105.8 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оноос 55.0 сая ам.доллароор буурсан байна. Санхүүгийн дансны тэнцэл 2020 онд 1.3

тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оноос 1.4 тэрбум ам.доллароор буурчээ. Тус бууралтад шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос 675.7 сая ам.доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

1.1.8. Санхүүгийн зах зээл

Банкны салбарын актив 2020 оны эцсийн байдлаар 36.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оныхоос 826 тэрбум төгрөг буюу 2.3 хувиар өсжээ.

График 19. Активын үлдэгдэл, их наяд төгрөг



Эх сурвалж: Монголбанк


Төв банкны үнэт цаасны өсөлт (73.7 хувь) болон цэвэр үнэт цаасны өсөлт (28.2 хувь) нийт активын өсөлтийг голлон бүрдүүлжээ. Харин банкны нөөц болон

дотоодын цэвэр зээл өмнө оны мөн үетэй харьцуулахад 34.2 хувь болон 5.8 хувиар буурсан байна. Банкнуудын татан төвлөрүүлсэн эх үүсвэр 32.0 их наяд

төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.1 хувь буюу 2.4 их наяд төгрөгөөр нэмэгдлээ.

Энэхүү өсөлтөд эх үүсвэрийн дийлэнх хувийг бүрдүүлдэг хадгаламж, харилцах нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

График 20. Пассивын үлдэгдэл, өсөлт, их наяд төгрөг



Эх сурвалж: Монголбанк

Нийт пассив өмнөх жилээс 2.4 хувиар өсөж 33.6 их наяд төгрөг болсон ба аж ахуйн нэгж, иргэдийн хадгаламж 28.9 хувиар өсөж 17.2 их наяд төгрөг болсон нь нийт пассивыг өсгөхөд хүргэжээ. Аж ахуйн нэгж, иргэдийн харилцах (-4.4 хувь), бусад санхүүгийн байгууллагад төлөх өглөг (-16.9 хувь), гадаад пассив (-24.5 хувь) болон бусад активууд (-17.7 хувь) өмнөх жилээс буурчээ.

2020 оны 12 дугаар сарын байдлаар хугацаатай хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 5.6 нэгжээр буурч 74.8 хувь болсон бол хугацаагүй хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 6.4 нэгжээр өсөж 25.2 хувь болжээ. Нийт хадгаламжийн 73.8 хувь нь төгрөгийн, 26.2 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Арилжааны банкнуудын тухайн жилийн ашиг 2020 оны эцсийн байдлаар 265.4 тэрбум байсан нь өмнөх оны мөн үеэс 8.1 дахин өссөн дүн юм.

1.2. Бодит салбарын хөгжил

1.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Мал аж ахуй. Мал аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засагт чухал ач холбогдолтой салбарын нэг бөгөөд ДНБ-ий 10 орчим хувийг, ХАА салбарын дийлэнх хувийг бүрдүүлдэг. 2020 оны мал тооллогын дүнгээр 67.1 сая толгой мал тоологдсоноос 4.1 сая адуу, 4.7 сая үхэр, 472.9 мянган тэмээ, 30.0 сая хонь, 27.7 сая ямаа байсан ба эдийн засгийн эргэлтэд оруулах мал сүргийн тоо толгой (тэмээнээс бусад сүргийн тоо толгой буурсан) өмнөх оныхоос 3.9 сая буюу 5.5 хувиар буурчээ. Үүнээс хонь 2.2 сая (6.9 хувиар), ямаа 1.5 сая (5.3 хувиар), адуу 122.1 мянган толгой (2.9 хувиар), үхэр 21.8 мянга (0.5 хувиар)-аар тус тус буурч, тэмээ 521 толгойгоор (0.1 хувиар) өссөн байна. Нийт мал сүрэгт 2020 оны тооллогын дүнгээр хонь 44.8 хувь, ямаа 41.3 хувь, үхэр 7.1 хувь, адуу 6.1 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж байна.

Өвөрхангай аймгийн малын тоо 1,146.4 мянга (20.4 хувиар), Баянхонгор аймгийнх 805.0 мянга (17.3 хувиар), Архангай аймгийнх 768.3 мянга (12.5 хувиар), Хөвсгөл аймгийнх 539.9 мянга (8.9 хувиар), Дундговь аймгийнх 352.0 мянга (8.6 хувиар), Говь-Алтай аймгийнх 286.9 мянга (8.0 хувиар)-аар тус тус буурсан нь голчлон нөлөөлжээ.

Мөн малын тоо толгой буурахад нөлөөлсөн бусад шалтгаанаас дурдвал

зуншлага оройтсон, зудын эрсдэл ихтэй, өвс, тэжээлийн эрэлт хэрэгцээ нэмэгдсэн, бэлчээрийн даац хэтэрсний улмаас малыг зах зээлд нийлүүлж мах бэлтгэлийг ихэсгэсэн нь малын тоо буурах гол шалтгаан болсон байна. Түүнчлэн, төллөсөн хээлтэгч 206.9 мянга, бойжсон төл 22,857.36 болсон нь өнгөрсөн оныхоос 809.9 мянган толгойгоор буурсан үзүүлэлт бөгөөд зүй бусаар хорогдсон мал 944.5 мянган толгойгоор нэмэгдсэн нь ихээхэн нөлөөлжээ.

Хүснэгт 12. Монгол Улсын малын тоо, мянган толгой

Малын төрөл	2016	2017	2018	2019	2020	Өөрчлөлт	Хувь
Адуу	3,635.49	3,939.81	3,940.09	4,214.82	4,093.86	-120.96	-2.9%
Үхэр	4,080.94	4,388.46	4,380.88	4,753.19	4,732.01	-21.18	-0.4%
Тэмээ	401.35	434.1	459.7	472.38	472.93	0.55	0.1%
Хонь	27,856.60	30,109.89	30,554.80	32,267.27	30,049.43	-2,217.84	-6.9%
Ямаа	25,574.86	27,346.71	27,124.70	29,261.66	27,720.25	-1,541.41	-5.3%
Бүгд	61,549.24	66,218.97	66,460.17	70,969.32	67,068.48	-3,900.84	-5.5%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Мал тооллогын 2020 оны дүнгээр нийт малтай өрхийн 74.8 хувь буюу 181.0 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллах нь амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа малчин өрх байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 9.4 мянга буюу 5.5 хувиар өслөө. Малчин өрхийг малын тоогоор нь бүлэглэж үзэхэд, 50 хүртэлх малтай өрх 16.5 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 18.5 хувиар, 201-500 малтай өрх 2.4 хувиар өссөн байхад, 501-999 малтай өрх 7.4 хувиар, 1,000-2,000 малтай өрх 16.8 хувиар, 2,001-ээс дээш малтай өрх 25.6 хувиар буурсан байна. Мал аж ахуйн үндсэн салбарт Ковид-19 цар тахал харьцангуй бага нөлөөлсөн ч эцсийн бүтээгдэхүүн болох ноолуур, мах, арьс ширний салбарт хүчтэй нөлөөлжээ.

Газар тариалан. Газар тариалангийн салбар нь хөдөө аж ахуйн салбарын 20.6хувийг, ДНБ-ий 2.2 хувийг эзэлдэг

бөгөөд Монгол Улсын нийт ажиллах хүчний 10 орчим хувь нь энэ салбарт ажиллаж байна. Улсын хэмжээгээр нийт газар тариалан эрхэлдэг 1,498 аж ахуйн нэгж, 16,292 өрхийн тариалан эрхлэгчид газар тариалангийн салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

2020 оны байдлаар улсын хэмжээнд нийт 587,862 га талбайд тариалалт хийсэн нь өмнөх оноос 64.8 (12.4 хувь) мянган га-гаар өссөн бөгөөд үүнээс 408.0 (69.4 хувь) мянган га-д үр тариа, 84.5 (14.4 хувь) мянган га-д таримал тэжээл, 19.0 (3.2 хувь) мянган га-д төмс, 10.6 (1.8 хувь) мянган га-д хүнсний ногоо тус тус тариалсан нь өмнөх оноос таримал тэжээл 40.7 (93.0 хувь) мянган га, үр тариа 38.5 (10.4 хувь) мянган га, төмс 4.1 (27.3 хувь) мянган га, хүнсний ногоо 2.1 (25.3 хувь) мянган га-гаар тус тус өссөн дүнтэй байна.

Хүснэгт 13. Хураан авсан ургацын хэмжээ, мянган тонн

Таримлын төрөл	2016	2017	2018	2019	2020
Үр тариа	377,802.2	390,860.2	366,809.3	369,445.2	407,985.8
Буудай	355,074.9	365,658.6	342,366.4	343,515.6	377,011.8
Төмс	15,024.3	15,147.8	12,924.9	14,941.9	19,021.9
Хүнсний ногоо	9,052.2	8,356.6	8,865.8	8,438.4	10,572.5
Таримал тэжээл	29,893.4	26,222.6	46,308.9	43,799.1	84,537.6

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Үр тариа 2020 онд 430.3 мянган тонн, төмс 244.3 мянган тонн, хүнсний ногоо 121.2 мянган тонн, таримал тэжээл 182.1 мянган тонн, техникийн ургамал 22.6 мянган тонныг хураан авч, 1.2 сая тонн хадлан, 42.2 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна. Үүнээс улсын хэмжээнд төмс, хүнсний ногооны 220.2 мянган тонн багтаамжтай 10 гаруй мянган зоорь, агуулах бүртгэлтэй байна. Үүнээс Улаанбаатар хотод 76.6 мянган тонн багтаамжтай зоорь, агуулах ашиглаж байна. Хадгалалтын дэвшилтэт технологитой, халаалт хөргөлтийг автомат, хагас автомат аргаар тохируулдаг механикжсан агуулахын багтаамж 62.0 мянган тоннд хүрсэн. Одоогийн хэрэглэгдэж байгаа нийт зоорийн 71 хувь нь энгийн болон нүхэн зоорь юм.

Инженерийн болон энгийн хийцтэй услалтын системд нийтдээ 57.0 мянган га-д усалгаатай газар тариалан эрхэлж байна. Энэ нь улсын хэмжээний нийт тариалангийн талбайн 12.5 хувийг эзэлж байгаа бөгөөд үр тарианы 1 хувь, төмсний 70.0 хувь, хүнсний ногоо, жимс жимсгэнийг 100 хувь усалгаатай тариалж байна. Өвлийн 27.5 га, зуны 68.5 га нийт 96 га талбайд хүлэмжийн аж ахуй эрхэлж 5.8 мянган тонн ургац хураан авч байгаа ба жил бүр 15.5 мянган тонн хүлэмжийн нарийн ногоо болон 5-8.0 мянган тонн улаан буудайн элит үрийг импортоор авч байна.

Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулдаг нийт 308 аж ахуйн нэгж байгаа

бөгөөд үүнээс улсын хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүний 204 үйлдвэр цех, 77 хөргөлтийн төв үйл ажиллагаа явуулж, нийтдээ 1,681 хүн ажиллаж байна. Үүнээс Улаанбаатар хотод 52 үйлдвэр цех үйл ажиллагаагаа явуулж байна. Сүү боловсруулах томоохон хүчин чадалтай үйлдвэрүүд олон улсын чанарын болон хүнсний аюулгүй байдлын тогтолцоо нэвтрүүлсэн /ISO 9000, ISO 22000, HACCP/ байна. Сүүний боловсруулах салбарын суурилагдсан хүчин чадал жилд 928 сая литр буюу хүчин чадал ашиглалт 18.1 хувьтай байна. Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр шингэн сүү 45 сая литр, тараг 15.9 сая литр, зайрмаг 103.3 сая ширхэг, шинэ цөцгий 5.6 тонн цөцгийн тос 250.2 тонн, зөөхий 574.4 тонн, шар тос 16.6 тонн тус тус үйлдвэрлэсэн ба үүнээс 2020 онд өвлийн улиралд хүн амын хэрэгцээнд үхрийн шингэн сүү 16.8 сая литр нийлүүлжээ.

Махны үйлдвэрлэл. Монгол Улсад жилдээ 12-14 сая толгой малыг хүн амын хүнсэнд хэрэглэдэг бөгөөд улсын хэмжээнд 2020 онд нийт 2,625 тэрбум төгрөг бүхий үйлдвэрлэлтэй байсан ба энэ нь өнгөрсөн оныхтой харьцуулахад 6.5 хувиар буурсан үзүүлэлт юм. Өнгөрсөн жил нийт 58.6 мянган тонн махыг экспортолсон. Нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх махны үнийг тогтвортой байлгах зорилгоор 2020 онд 10.5 мянган тонн нөөцийн мах бэлтгэн нийлүүлсэн байна.

Ноос, ноолуур. Монгол Улсын стратегийн түүхий эд болох ноолуурын салбарын хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, нөөцийн ашиглалтыг дээшлүүлэх, хүчин чадал нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх, үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгийг шийдвэрлэх, гадаад зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Ноолуур хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Дэлхийн ноолуурын зах зээлд жилд дунджаар 24 мянган тонн ноолуур бэлтгэдэг бөгөөд үүнээс БНХАУ дангаараа 12 мянган тонн буюу 50 хувийг, Монгол Улс 9.6 мянган тонн буюу 40 хувийг нийлүүлж байна. Ноолуур боловсруулах салбарт гүн боловсруулах үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр 59, өрхийн жижиг цех 150-200 үйл ажиллагаа явуулж, угаасан ноолуурыг Хятад, самнасан ноолуурыг Хятад, Итали, Англи, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Бельги, Франц зэрэг 20 гаруй оронд экспортолж байна. 2020 оны байдлаар улсын хэмжээнд 10 мянган тонн ноолуур бэлтгэж, 2.3 мянган тонныг дотооддоо боловсруулсан байна.

Нийт 200 гаруй мянган малчин өрхийн орлогын 40 хувийг ноолуурын борлуулалтын орлого эзэлж буй бөгөөд нийт нэмүү өртгийн сүлжээг бий болгодог 200 гаруй үйлдвэр цех ноолуурын боловсруулах үйлдвэр ажиллаж 8,000 гаруй хүн ажлын байраар хангагдаж, жилдээ 1.3 их наяд төгрөгийн экспорт хийдэг ба нийт экспортын үнийн дүнд 9 орчим хувийг эзэлдэг. Өөрөөр хэлбэл, дэлхийн экспортод Монгол Улсын ноолуурын эзлэх хувийг боловсруулалтын төвшнөөр нь авч үзвэл угаасан ноолуурын экспортод 88 хувь, самнасан ноолуурын экспортод 72 хувь эзэлж

байгаа бол эцсийн бэлэн бүтээгдэхүүн ердөө 1.4 хувийг эзэлж байна. Мөн угаах 34 үйлдвэрт суурилагдсан хүчин чадал нь 13,000 тонн бөгөөд хүчин чадлынхаа 77 хувийг л ашиглаж, 350 гаруй хүн тус салбарт ажиллаж байна. Ээрэх үйлдвэрт 2,278 тонн ээрмэл гаргах хүчин чадал суурилагдсан боловч 36 хувийг ашиглаж, 400 орчим хүн ажилладаг байна.

Салбарын хувьд дэлхий даяарх ноос ноолууран эдлэлийн эрэлт огцом буурсан нь тун хүнд цохилт болсон. Мөн Праймарк зэрэг дэлхийн томоохон үйлдвэрлэгчид түүхий эдийн захиалгаа цуцалсан ба зарим тохиолдолд гэрээгээ цуцалжээ. Мөн гол экспортын орон болох Хятад улс руу хийх тээвэрлэлтийн асуудлаас үүдэлтэйгээр хүндрэлтэй байдал бий болсон. 2019 онд дэлхийн зах зээлд 1 кг нь 39 доллар байсан ноолуур 2020 онд 16 доллар хүртэл унасан нь ноолуур хөтөлбөрөөр 20,000 төгрөгийн татаас өгөөд ч үнийг хангалттай хэмжээнд хүргэж чадахгүй байна.

Арьс ширний үйлдвэрлэл. Улаанбаатар, Дархан хотод арьс шир боловсруулах 34 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа ба арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 100 гаруй жижиг, дунд үйлдвэрүүд нийслэл, аймаг орон нутагт ажиллаж байна. Бүтцийн хувьд арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн салбарт арьс ширийг хагас боловсруулах 14, гүн боловсруулах хуурай цех 4, гүн боловсруулах жижиг үйлдвэр 12, гүн боловсруулах том үйлдвэр 10, завод ноос, ноолуур угаах 6 аж ахуйн нэгж, Урьдчилан цэвэрлэх байгууламж НӨҮГ, Хөнгөн үйлдвэрлэлийн судалгаа туршилт үйлдвэрлэлийн Армоно корпораци ТӨАТҮГ үйл ажиллагаа явуулж байна. 2020 оны байдлаар арьс ширний салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 31.7 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад даруй 43.8 хувиар өссөн үзүүлэлт юм.

Мод, модон бүтээгдэхүүн, тавилгын үйлдвэрлэл. 21 аймаг, нийслэлд нийт мод хөрөөдөх, харуулдах үйл ажиллагаа эрхэлдэг 214, мод хөрөөдөх, харуулдах үйл ажиллагаа явуулдаг 427, мод бэлтгэлийн 73 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж буй бөгөөд боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний 2-3 хувийг үйлдвэрлэж байна.

Мод бэлтгэл, зүсмэл материалын үйлдвэрлэлийг 110, Барилгын модон хийцийн үйлдвэрлэлийг 24, Хавтан хийцийн мебель тавилгын үйлдвэрлэлийг 70, зөөлөн тавилгын үйлдвэрлэлийг 12, гэрийн модны үйлдвэрлэлийг 50, хөгжмийн зэмсгийн үйлдвэрлэлийг 6, шахмал түлшний үйлдвэрлэлийг 16, жижиг мужааны үйлдвэрлэлийг 180 гаруй аж ахуйн нэгж байгууллага эрхэлж, 6,000 гаруй хүнийг ажлын байраар хангаж байна.

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн 90 орчим хувь нь 5-10 хүнтэй бичилаж ахуйн нэгжүүд бөгөөд 30-аас 300 хүртэл ажиллагсадтай томоохон аж ахуйн нэгжүүд 50 орчим байна.

Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл 7.8 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан нь өнгөрсөн оныхтой харьцуулахад 11.8 хувиар өссөн үзүүлэлт юм.

1.2.2. Уул уурхай, хүнд үйлдвэрлэл

Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 6.1 сая га талбайг хамарсан ашигт малтмалын 2,651 тусгай зөвшөөрөл, үүнээс 1.64 сая га талбай бүхий 1,697 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 4.5 сая га талбай бүхий 954 хайгуулын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Үүнийг задлан авч үзвэл, хайгуулын тусгай зөвшөөрөл нийт газар нутгийн 3.0 хувь, ашиглалтын тусгай

зөвшөөрөл нийт газар нутгийн 1.0 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 10,402.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1,638.4 тэрбум төгрөг буюу 13.6 хувиар буурсан байна. Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 2,673.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оныхоос 246.6 тэрбум төгрөг буюу 8.4 хувиар буурсан байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар авч үзвэл:

- Уул уурхайн салбараас 2,522.9 тэрбум төгрөг буюу 24.3 хувь,
- Газрын тосны салбараас 102.8 тэрбум төгрөг буюу 1.0 хувь,
- Тусгай зөвшөөрлийн төлбөр 32.7 тэрбум төгрөг буюу 0.3 хувь,
- Бусад орлого 14.9 тэрбум төгрөг буюу 0.1 хувь байна.

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 25.7 хувийг бүрдүүлж байна.

2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 40.5 сая тонн нүүрс, 1,276.7 мянган тонн зэсийн баяжмал, 20.2 тонн алт, 6,038.3 тонн молибдений баяжмал, 127.3 мянган тонн хайлуур жоншны хүдэр, 85.0 мянган тонн хайлуур жоншны баяжмал, 9,224.4 мянган тонн төмрийн хүдэр, 4,716.4 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал, 76.3 мянган ган тонн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оныхтой харьцуулахад алт 4.0 тонн буюу 24.6 хувь, зэсийн баяжмал 14.3 мянган тонн буюу 1.1 хувь, молибдений баяжмал 735.5 тонн буюу 13.9 хувь, төмрийн хүдэр 652.2 мянган тонн буюу 7.6 хувь, төмрийн хүдрийн баяжмал 1,330.1 мянган тонн буюу 39.3 хувь, хайлуур жоншны баяжмал 37.5 мянган тонн буюу 78.9 хувиар тус тус өссөн байна. Харин нүүрс 10.3 сая тонн буюу 20.3 хувь, хайлуур жоншны хүдэр 28.9 мянган тонн буюу 18.5 хувь, цайрын

баяжмал 6.8 мянган тонн буюу 8.2 хувиар тус тус буурсан байна.

2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2.1 тэрбум ам.долларын өртөг бүхий 28.6 сая тонн чулуун нүүрс, 1.8 тэрбум ам.долларын 1.4 сая тонн зэсийн баяжмал, 639.7 сая ам.долларын

8.2 сая тонн төмрийн хүдэр, баяжмал, 156.3 сая ам.долларын 678.9 мянган тонн хайлуур жоншны хүдэр, баяжмал, 167.7 сая ам.долларын 134.0 мянган тонн цайрын баяжмал, 40.7 сая ам.долларын 6.3 мянган тонн молибдений баяжмал тус тус экспортолсон байна.

Хүснэгт 14. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөг

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Гүйцэтгэлийн өөрчлөлт	
		2019	2020 (Тодотгол)	2019	2020	Зөрүү	хувь
Уул уурхай, олборлох салбар							
1	Алт	83	212.6	116.8	174	57.1	48.9
2	Зэс	1,304.00	1,127.70	1,090.10	1,122.50	32.4	3
3	Нүүрс	1,311.00	1,056.30	1,210.60	984.1	-226.5	-18.7
4	Бусад	302	301.5	204	242.3	38.3	18.8
Газрын тосны салбар							
5	Газрын тос	335.6	110	232.3	102.8	-129.5	-55.8
	Нийт	3,404.10	2,857.30	2,920.00	2,673.40	-246.6	-8.4

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

2005 онд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 44.5 хувийг ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон нутаг дэвсгэр эзэлж байсан бол 2009 онд 25.2 хувь, 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 4.7 хувь хүртэл болж буурсан байна.

2020 оны гүйцэтгэлээр уул уурхай, олборлох салбар төсөвт 2,522.9 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Зэс 1,122.5 тэрбум төгрөг (32.4 буюу 3.0 хувь өссөн),
- Нүүрс 984.1 тэрбум төгрөг (226.5 буюу 18.7 хувь буурсан),
- Алт 174.0 тэрбум төгрөг (57.1 буюу 48.9 хувь өссөн),
- Төмөр 90.3 тэрбум төгрөг (64.9 буюу 3.6 дахин их өссөн),
- Бусад ашигт малтмал 74.5 тэрбум төгрөг (3.0 буюу 3.8 хувь буурсан),
- Хайлуур жонш 43.3 тэрбум төгрөг (8.5 буюу 24.3 хувь өссөн),

- Цайр 34.2 тэрбум төгрөг (32.0 буюу 48.3 хувь буурсан).

2020 онд дэлхий нийтэд Ковид-19 цар тахал эрчимтэй тархсаны улмаас улс орнууд хэсэгчилсэн хөл хорио тогтоож, манай улсад ч мөн адил арга хэмжээ авч хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор оны эхний хагаст нэгдсэн төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 1.2 их наяд төгрөгөөр буурсан бөгөөд үүний дийлэнх буюу 50 гаруй хувь нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого багассанаас хамаарч байсан.

Холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлсний дүнд Монгол, Хятадын Ногоон гарц түр журмыг хэрэгжүүлэх бололцоо бүрдэж, нүүрс тээврийн жолооч нарыг Хятадын талд хонуулах арга хэмжээг авч эхэлсэн. Үүний дүнд өдөрт хилийн Гашуунсухайт боомтоор 1,000, Шивээхүрэн боомтоор 700 орчим тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрч байв. Гэтэл Монгол Улс Ковид-19 цар тахлыг дотоодод алдсаны улмаас Монгол Улс,

БНХАУ-ын талаас хилийн татан авалтыг багасган тээврийн жолооч нараас ПГУ шинжилгээ авах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Энэхүү нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас холбогдох арга хэмжээг авч 2020 оны 183 дугаар тогтоолоор Хилийн боомтуудыг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах, Тавантолгойн бүлэг орд, Нарийнсухайтын бүлэг орд, Оюутолгойн ордын хүрээнд байгуулагдсан аюулгүйн бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай уялдуулан Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг шинжилгээнд бүрэн хамруулан эдгээр боомтыг Ногоон бүс болгон зарласан.

Түүнчлэн уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч томоохон аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Тавантолгой, Нарийнсухайт, Айлбаян, Ерөө-Хүдрийн бүлэг ордод нэгдсэн байдлаар, Оюутолгой, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөшөөт, Таяннуур, Улаан, Төмөртийн овоо, Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун, Шарын голын уурхай, газрын тосны Зүүнбаян, Тосон уул, Тамсагийн орд тус бүрд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах Аюулгүйн тусгай бүсийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 297 дугаар тушаалын дагуу байгуулж хэрэгжилтийг хангаж байна.

Геологи. Монгол орны нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг танин мэдэж, улмаар эрдэс баялгийн сан хөмрөгийг баяжуулах ач холбогдол бүхий салбар юм.

Төсвийн хөрөнгөөр 2018 онд 13.1, 2019 онд 23.7, 2020 онд 20.2, 2021 онд 27.4 тэрбум төгрөг, нийт 84.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1:50000-ын масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 44, Улсын геологийн 1:200000-ын масштабын

иж бүрдэл зураг зохиох 3, сэдэвчилсэн судалгааны 20 төслийг үндэсний 62 аж ахуйн нэгж гүйцэтгэж байна.

- Монгол орны нутаг дэвсгэрийн 41.06 хувийг 1:50000-ын масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар 2020 оны жилийн эцсийн байдлаар бүрэн бүрхсэн.

- Улсын геологийн 1:200000-ын масштабын иж бүрдэл зургийг 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол орны өмнөд хэсэг буюу К хавтгайн хэмжээнд нэгтгэсэн.

- Агаарын геофизикийн 1:200000-ын масштабын 5 сувгийн судалгааны ажлыг Монгол орны баруун хэсэгт 104.044 км² талбайд хийх ажлыг 2020 онд эхлүүлсэн.


Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ын масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 1 км² талбайд 2018-2020 онд гүйцэтгэсэн төслүүдийн үр дүнгээс харахад дунджаар 290,000 төгрөг буюу 1 га талбайд 2,900 төгрөг зарцуулсан ба энэхүү судалгааны ажлын үр дүнд тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий хэтийн төлөвтэй талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 1 га тутамд 4,500 төгрөгөөр үнэлэн олгож байгаа нь улсын төсвөөс зарцуулсан зардлын зарим хэсгийг нөхөх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Хүнд үйлдвэрлэл. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Хүнд үйлдвэрийн салбар 6.7 хувийг эзэлж байна. Хүнд үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 553.4 мянган тонн нүүрсэн шахмал түлш, 9.5 мянган тонн катодын зэс, 15.3 мянган тонн металл бэлдэц, 16.6 мянган тонн металл цувимал, 5.2 сая тонн ган төмөр хийц, 74.3 тонн цахилгааны утас тус тус үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрсэн шахмал түлш 344.8 мянган тонн буюу 2.7 дахин их өссөн байна. Харин катодын зэс

2.3 мянган тонн буюу 19.3 хувь, металл бэлдэц 13.3 мянган тонн буюу 46.6 хувь, металл цувимал 10.2 мянган тонн буюу

38.1 хувь, ган төмөр хийц 4.0 сая тонн буюу 43.2 хувь, цахилгааны утас 7.8 тонн буюу 9.5 хувиар тус тус буурсан байна.

График 21. Хүнд үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уул уурхайн салбарын экспорт.

2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2.0 сая ам.долларын 9.9 мянган тонн кокс экспортолсон нь өнгөрсөн оныхоос үнийн дүнгээр 25.1 сая ам.доллараар буюу 92.6 хувиар, биет хэмжээгээр 134.8 мянган тонноор буюу 93.1 хувиар тус тус буурсан байна. 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 59.3 сая ам.долларын 9.6 мянган тонн катодын зэс экспортолсон нь өнгөрсөн оныхоос биет хэмжээгээр 2.3 мянган тонноор буюу 19.2 хувиар, үнийн дүнгээр 9.6 сая ам.доллараар буюу 13.9 хувиар тус тус буурсан байна.

Уул уурхайн салбарын импорт.

2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 190.4 мян.ам.долларын 1.0 мянган тонн кокс импортолсон байна. Өнгөрсөн оныхоос биет хэмжээгээр 1.1 мянган тонн-оор буюу 52.3 хувиар, үнийн дүнгээр 194.1 мянган ам.доллараар буюу 50.5 хувиар тус тус буурсан байна.

Өнөөгийн байдлаар хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр 86 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ган туйван, ган бөмбөлөг, катодын зэс, зэс утас, резин, газрын тосны бүтээгдэхүүн, металлургийн кокс, тээврийн хэрэгсэл угсрах болон

металл хийцийн үйлдвэрүүд ажиллаж байна.

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.10.2, 15.10.15, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/105 дугаар тушаалыг тус тус үндэслэн Хүнд үйлдвэрийн чиглэлээр төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх, үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх гэсэн хоёр төрлийн тусгай зөвшөөрлийг олгож байгаа бөгөөд үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 5, төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөлтэй 36 аж ахуйн нэгж байна.

Газрын тос. Монгол Улсын хэмжээнд 1993-2020 оны хооронд 14 аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан газрын тосны хайгуулын 33 талбай ялгаснаас өнөөдрийн байдлаар 18 талбайд газрын тосны хайгуулын, 5 талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын, 3 талбайд газрын тосны ашиглалт,

олборлолтын үйл ажиллагаа бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч компаниудын 27.3 хувь нь Монгол Улс, 40.9 хувь нь БНХАУ, 31.8 хувь нь бусад улсын харьяалалтай ба гэрээлэгч аж ахуйн нэгжүүд 1993 оноос 2020 оны хооронд газрын тосны хайгуул, судалгааны ажилд нийт 295,3 сая ам.доллар зарцуулсан байна.

Газрын тосны хайгуул, ашиглалтын талбайнуудад хийгдсэн хайгуул, судалгааны ажлуудыг дурдвал: Хүндийн хүчний судалгаа 1:200000 масштабээр 272,890 км² талбайд; Соронзон хайгуул 77,630 км² талбайд; Пассив сейсмийн судалгаа 210 физик цэгт; Магнито-теллурын судалгаа 180 физик цэгт хийгдсэн байна.

Газрын тосны ашиглалт, олборлолт, улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, хөрөнгө оруулалт: Улсын хэмжээнд 1996 оноос 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 9.3 сая тонн газрын тос олборлож, 8.85 сая тонн газрын тос экспортолж, Улсын төсөвт нийт 1.8 их наяд төгрөг төвлөрүүлснээс 2020 онд 102.8 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Гэрээлэгч компаниуд дээрх 3 талбайн газрын тосны хайгуул, ашиглалт, олборлолт, экспортын үйл ажиллагаанд нийтдээ 3.84 тэрбум ам.доллар зарцуулсан байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар Тосон-Уулын орд газарт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 489 цооног байгаагаас хоногт дунджаар 362 цооногоор 8,756 баррель буюу 1,161 тонн газрын тос олборлож, өдөрт 36 автоцистернээр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах Бичигт хилийн боомтоор, Тамсагийн орд газарт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 302 цооног байгаагаас хоногт дунджаар 280 цооногоор 9,000 баррель буюу 1,240 тонн газрын тос олборлож, өдөрт 37 автоцистернээр

Дорнод аймгийн Халхгол сумын нутагт байрлах Баянхошуу хилийн боомтоор тус тус БНХАУ-д экспортолсон.

Газрын тосны ордыг ашиглалтад шилжүүлэх ажлын хүрээнд Тосон-Уул XIX талбайд хоногт 4,200 тонн шингэн цэвэршүүлэх хүчин чадалтай түүхий тос цуглуулах, цэвэршүүлэх, хадгалах, ачих, буулгах олборлолтын ил байгууламжийг барьж байгуулан 2011 онд ашиглалтад оруулсан ба тос хадгалах савны багтаамж нийт 212.2 мянган баррель буюу 28.3 мянган тонн юм. Дорнод аймгийн Чойбалсан хотоос Тосон-Уул XIX талбай хүртэл 110 кВ-ийн хүчин чадал бүхий 188.6 км цахилгаан дамжуулах агаарын шугам, Тосон-Уул XIX талбайгаас Баянхошуу хилийн боомт хүртэлх 210 км хатуу хучилттай авто зам, мөн Тосон-Уул XIX талбайгаас Бичигтийн хилийн боомт хүртэлх 139 км сайжруулсан хайрган хучилттай замыг тус тус барьж байгуулан ашиглалтад шилжүүлсэн.

Газрын тосны бүтээгдэхүүний импорт, хэрэглээ. Өнөөгийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүнийхээ хэрэглээг 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд улс орны нийгэм эдийн засаг, уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүн ам, авто тээврийн хэрэгслийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж ирсэн ба 2020 онд 1.95 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэжээ.

1.2.3. Эрчим хүч

Монгол Улсын эрчим хүчний систем нь Төвийн бүсийн эрчим хүчний систем (ТБЭХС), Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний систем, Дорнод бүсийн эрчим хүчний систем, өмнөд бүсийн цахилгаан хангамж гэсэн таван хэсгээс тогтож байна. Нийтдээ 9 дулааны цахилгаан станц, Дөргөн, Тайширын усан цахилгаан станц,


Алтай, Улиастайн дизель станцууд болон бага чадлын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн 220 кВ, 110 кВ-ын дэд станц, дамжуулах сүлжээ, 35/10/6/0.4 кВ-ын дэд станц болон түгээх сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр ханган ажиллаж байна.

Үүний зэрэгцээ Ухаахудаг цахилгаан станц, Оюутолгой орд газрын хэрэглээг нөөц тэжээлийн үед дизель цахилгаан станцаар хангахын зэрэгцээ ОХУ болон БНХАУ-аас цахилгаан эрчим хүчийг

импортлон авч цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ ханган ажиллаж байна.

Дээрх биеэ даасан системүүдээс суурилагдсан чадал болон цахилгаан эрчим хүчний хэрэглээний хувьд хамгийн том нь Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ бөгөөд цахилгааныг хослон үйлдвэрлэдэг 8 дулааны цахилгаан станц бүхий эх үүсвэртэй юм. Мөн ОХУ-ын Буриадын эрчим хүчний систем (БЭХС)-тэй зэрэгцээ ажиллагаанд ажилладаг бөгөөд Монгол Улсын цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээний 76.5 хувийг эзэлж байна.

График 22. Цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Манай улс 2020 онд 6,259.28 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч, 9,279.5 мян.Гкал дулааны эрчим хүч тус тус үйлдвэрлэсэн. Эрчим хүчний системийн мөн үеийн үйлдвэрлэл, боловсруулалтыг эх үүсвэрийн бүтцээр авч үзвэл дотоодын үйлдвэрлэлтийн 90.6 хувийг дулааны цахилгаан станцууд, 9.3 хувийг нар, салхи, усны эх үүсвэрүүд, 0.01 хүрэхгүй хувийг дизель станцуудаас үйлдвэрлэсэн байна.

Нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээ 8,844.45 сая.кВт.ц, өмнөхоны гүйцэтгэлтэй харьцуулахад 82.33 сая.кВт.ц буюу 0.9 хувиар өссөн байна. Цахилгааны эрчим хүчний хэрэглээний 7,145.69 сая.кВт.ц буюу 80.7 хувийг дотоодын эх үүсвэрээс, 1,698.76 сая.кВт.ц буюу 19.3 хувийг

импортын цахилгаан эрчим хүчээр хангасан байна.

Монгол Улсын эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ДЦС-3-ын суурилагдсан хүчин чадлыг 75 мВт-аар өргөтгөх, Чойбалсангийн ДЦС-ыг 50 мВт-аар өргөтгөх, Улаанбаатар хотын Амгалангийн ДЦС-ыг 50 мВт-аар өргөтгөх, Тавантолгой 300 мВт-ын цахилгаан станцыг барих, Багануурын 400 мВт-ын ДЦС барих, Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын усан цахилгаан станц барих, Төвийн бүсийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхээр ажиллаж байна.

Хүснэгт 15. Дэд салбарын үйлдвэрлэлүүд

	Нэгж	2017	2018	2019	2020
Цахилгаан эрчим хүч	сая кв.цаг	6,027.3	6,535.4	6,900.4	6,259.28
Дулааны эрчим хүч	мян.Гкал	11,296.4	11,504.8	13,277.3	9,279.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цахилгаан эрчим хүч болон усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний улиралд 391.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 57.6 (17.2 хувь) тэрбум төгрөгөөр өссөн байна. Цахилгаан эрчим хүчний нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар, усан хангамжийн салбарынх 8.2 хувиар өссөн байна.

1.2.4. Зам, тээвэр

Зам, тээврийн салбар 2019 онд ДНБ-ий 4.6 хувийг эзэлж байсан бол 2020 онд 3.7 хувь болж буурсан бөгөөд гол шалтгаан нь цар тахал юм. Улсын хил хаасантай холбоотойгоор экспортоор гаргадаг зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, экспорт 7,576.3 сая ам доллар болж өмнөх оноос 0.5 хувиар, импорт 5,293.9 сая ам доллар болж өмнөх оноос 13.6 хувиар буурчээ.

Хүснэгт 16. Зам тээврийн салбарын зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2020/2019 (хувь)
Нийт тээвэрлэсэн ачаа, мянган тонн					
Төмөр зам	53,983.40	67,802.90	68,997.50	60,458.80	87.6
Авто зам	22,765.10	25,763.30	28,143.00	30,001.20	106.6
Агаарын зам	31,212.90	42,033.80	40,848.80	30,454.90	74.6
Агаарын зам	5.40	5.80	5.80	2.70	46.6
Нийт ачаа эргэлт, сая тонн километр					
Төмөр зам	19,167.80	21,969.50	23,564.00	23,861.00	101.3
Авто зам	13,493.30	15,315.30	17,384.10	19,167.60	110.3
Агаарын зам	5,661.30	6,640.60	6,203.80	4,685.30	75.5
Агаарын зам	13.20	13.60	13.40	8.10	60.4
Нийт зорчигчдын тоо, сая хүн					
Төмөр зам	216.10	197.00	173.00	126.50	73.1
Төмөр зам	2.60	20.60	3.00	2.00	66.7
Авто зам	212.20	193.00	168.40	124.10	73.7
Агаарын зам	1.30	1.40	1.60	0.40	25.0
Усан зам	0.00	0.00	0.00	-	-
Нийт зорчигч эргэлт, сая хүн километр					
Төмөр зам	5,434.00	6,598.10	7,157.90	3,416.90	47.7
Төмөр зам	973.20	993.70	1,113.40	579.30	52.0
Авто зам	2,040.90	2,919.90	2,925.10	2,178.00	74.5
Агаарын зам	2,420.20	26,842.00	3,113.20	659.60	21.2
Усан зам	0.40	0.60	0.60	0.40	66.7

Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг	1,422.20	1,754.40	2,003.50	1,504.90	75.1
Төмөр зам	530.00	616.00	708.60	775.90	109.5
Авто зам	506.40	695.90	796.10	564.40	70.9
Агаарын зам	385.50	442.30	498.20	161.10	32.3
Усан зам	0.30	0.50	0.40	0.50	125.0

Эх сурвалж: Зам тээвэр, хөгжлийн яам

Бүх төрлийн тээврээр 60.5 сая тонн ачаа 2020 онд тээвэрлэсэн нь өмнөх оноос 8.5 (12.4 хувь) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 10.4 (25 хувь) сая тонн, агаарын тээврээр тээсэн ачаа 3.3 (55 хувь) мянган тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.

Төмөр замаар тээсэн ачаа 2020 онд 30 сая тонн болж, өмнөх оноос 1.8 (6.6 хувь) сая тонноор өссөн. Үүнд нүүрсний тээвэр 74.7 (0.9 хувь) мянган тонноор, төмрийн хүдрийн тээвэр 810.6 (11.4 хувь) мянган тонноор, барилгын материалын тээвэр 149.1 (7.0 хувь) мянган тонноор нэмэгдсэн нь нөлөөллөө. Төмөр замын дотоодод тээвэрлэсэн ачаа 0.6 хувиар буурч, экспортын ачаа 14 хувь, импортын ачаа 3.0 хувь, дамжин өнгөрөлтийн ачаа 9.8 хувиар тус тус өссөн байна.

Бүх төрлийн зорчигч тээвэрлэлт 2020 онд давхардсан тоогоор 126.55 сая хүн болж өмнөх оноос 46.47 (26,8 хувь) сая хүнээр буурсан. Гадаадад болон дотоодод зорчигч тээвэрлэлтийн хөдөлгөөнийг хязгаарласан нь зорчигч тээвэрлэлтийн бууралтад шууд нөлөөлсөн юм.

Монгол Улсын хэмжээнд усан замын тээврээр 2020 онд 31,158 зорчигч тээвэрлэж өмнөх оноос 204 (0.6 хувь) зорчигчоор өссөн байна. Нийт зорчигчдын 31037 дотоодын иргэд бол 121 гадаадын иргэд байна. Зорчигч эргэлт 0.4 сая хүн км болж өмнөх оноос 33 хувиар буурсан байна. Усан замын тээврийн үйл ажиллагааны орлого 495 сая төгрөг болж өмнөх оныхоос 31 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2020 оны жилийн эцсээр 111,916.7 км байгаагийн 99,978.7 км нь буюу 89.3 хувь нь ердийн хөрсөн, 11,938 км буюу 10.7 хувь нь сайжруулсан авто зам байна. Нийт сүлжээний 14,918.7 км буюу 13 хувь нь улсын чанартай, 96,125.3 буюу 85.9 хувь нь орон нутгийн чанартай, 872.7 буюу 0.1 хувийг уул уурхайн зориулалттай авто зам эзэлж байна. 2020 онд 344 км хатуу хучилттай авто зам, 648.9 у/м гүүр ашиглалтад оруулсан байна.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2018 онд нийт 326.3 тэрбум төгрөгийн, 2019 онд 380.9 тэрбум төгрөгийн орлого олсон ба 2019 онд орлогын үзүүлэлт 17 хувиар өссөн байна. Ковид-19 цар тахлын нөлөөллөөс шалтгаалж 2020 оны орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 203.9 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 46.5 хувиар буурах төлөвтэй байна. Мөн улсын төсөвт төвлөрүүлсэн навигацийн орлого 2018 онд 167.7 тэрбум төгрөг, 2019 онд 156.0 тэрбум төгрөг байсан. Харин 2020 онд коронавирусийн нөлөөллөөс шалтгаалан Улсын төсөвт төвлөрүүлэх орлого буурсан юм.


1.2.5. Барилга, хот байгуулалт

Барилга угсралт, их засварын ажил 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.7 их наяд төгрөгт хүрчээ. Үүнээс 97.6 хувь буюу 4.6 их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 2.4 хувь буюу 114.3 тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага тус тус гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажил 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноосоо 3.6 хувь буюу 174.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Хэдийгээр

дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн ажил 17.6 тэрбум төгрөгөөр өссөн ч гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн ажил 191.8 тэрбум төгрөгөөр буурсан нь ийнхүү нөлөөлжээ.

График 23. Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, тэрбум төгрөг



Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

Барилга угсралт, их засварын ажлын 28.7 хувийг орон сууцны барилга, 36.0 хувийг орон сууцны бус барилга, 32.3 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.0 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оноос инженерийн барилга байгууламжийн эзлэх хувь 10.1 нэгж хувиар, их засварын эзлэх хувь 0.6 нэгж хувиар тус тус өсөж, орон сууцны бус барилгынх 10.5 нэгж хувиар, орон сууцны барилгынх 0.3 нэгж хувиар буурсан байна.

Мөн өргөн хэрэглээний 40 гаруй нэр төрлийн барилгын материалын 70 хувийг дотооддоо үйлдвэрлэх боломжтой болсон ба сүүлийн 5 жилд цементийн үйлдвэрлэл 6 дахин, бетон зуурмагийн үйлдвэрлэл 4 дахин, тоосгоны үйлдвэрлэл 1.5 дахин, хөнгөн бетоны үйлдвэрлэл 5 дахин, бусад үйлдвэрлэл 1-5 дахин нэмэгджээ. Цемент, барилгын дулаалга, хаалга цонхны дотоодын хэрэгцээг 100 хувь хангах болсон байна.

Сүүлийн 4 жилд барилгын салбарын ДНБ-д оруулсан хувь хэмжээ 1 их наяд

45.2 тэрбум төгрөг болж 10.1 хувиар, улсын хэмжээнд хийгдсэн барилга угсралт, их засварын хэмжээ 4 их наяд 9.8 тэрбум төгрөг болж 19.4 хувиар, улсын төсөвт төвлөрүүлсэн татварын орлогын хэмжээ 134.1 тэрбум төгрөг буюу 12 хувиар, барилгын салбарт ажиллагсдын дундаж цалин 1 сая 123 мянган төгрөг болж 30.7 хувиар нэмэгджээ.

Орон сууц. Монгол Улсын нийт өрхийн 45.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа нь 2010 онд хийсэн өмнөх тооллогын үеийнхтэй харьцуулахад 2.2 нэгж хувиар илүү байна. Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийслэл Улаанбаатар хотод 411.4 мянган өрх амьдарч байгаагийн 22.2 хувь (91,249) нь монгол ард түмний уламжлалт сууц гэрт, 77.3 хувь (317,944) нь байшин болон орон сууцанд, 0.5 хувь (2,227) нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 6.8 нэгж хувиар буурсан бол байшинд амьдардаг өрхийнх

7.7 нэгж хувиар нэмэгджээ. Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 141.7 мянган сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 387.8 мянган сууц тоологдсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.77.1-д Орон сууц үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхээр заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамнаас 150 мянган айл-Орон сууц үндэсний хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан.

Хотын төвлөрлийг сааруулах, ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийг орлогод нийцсэн орон сууцаар хангах хүрээнд Залуус-1 хорооллыг Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулахаар холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дээрх төслүүд хэрэгжсэнээр 2021-2024 онуудад 20,000 айлын орон сууцны бүтээн байгуулалт хийгдэж, хувийн хэвшил, төрийн болон орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны сан нэмэгдэх юм. Мөн Барилга, хот байгуулалтын яамнаас БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт Ногоон нуур – 1,008 айлын орон сууц төсөл, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр нийслэлийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт Солонго -I, Солонго - II 5,002 айлын орон сууцны төсөл, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт Баянголын аманд 2,007 айлын орон сууцны төсөл, АХБ, Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Улаанбаатар хотын дэд төвүүдэд нийт 10,000 айлын орлогод нийцсэн орон сууцны хороолол барих төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.


Мөн 150,000 айл орон сууцны үндэсний хөтөлбөрийн хүрээнд /2019-2023/ 4 зорилт бүхий 84 төсөл, арга хэмжээг тусган 16.86 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 18,488 түрээсийн орон сууц, дагуул хот дагаж барих 16,512 орон сууц, зах зээлийн орон сууц 57,000, ашиглалтын шаардлага хангахгүй байгаа барилгын ахин шинэчлэл 3,000, гэр хорооллын дахин төлөвлөлт 45,000 болон 10,000 амины орон сууц барихаар төлөвлөн ажиллаж байна.

1.2.6. Аялал жуулчлал

Дэлхий дахинд сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж, дэлхий нийтийн экспортын 7 хувь, үйлчилгээний экспортын 30 хувийг тус тус бүрдүүлж, ажил эрхэлж байгаа 10 хүн тутмын 1 нь тус салбарт ажлын байраар хангагдаж, шинээр бий болж байгаа 5 ажлын байр тутмын 1 нь аялал жуулчлалын салбарт бий болжээ.

Тус салбарт 120 гаруй тур оператор, 370 зочид буудал, 500 гаруй жуулчны бааз идэвхтэй үйл ажиллагаа явуулж, 80,000 гаруй хүн ажиллаж байна. 2019 оны байдлаар Монгол Улсад 577,300 жуулчин аялж, аялал жуулчлалын салбараас дотоодын эдийн засагт 607,231,369 ам.долларын орлого оруулсан нь 2018 онтой харьцуулахад гадаадын жуулчдын тоо 9 хувиар, салбарын орлого 10.2 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Харин 2020 онд 58,859 жуулчин ирж, дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн салбаруудад хүндрэл учирснаас аялал жуулчлалын салбарт хамгийн их нөлөөлж жуулчдын тоо, салбарын орлогыг 90 гаруй хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 24. 2010-2020 оны аялал жуулчлалын салбарын орлого (сая ам. доллар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улс орнууд хилээ хаах, халдвар тархсан улс орнуудад зорчихгүй байх арга хэмжээ авсан нь олон улсын аялал жуулчлалын урсгалд нөлөөлсөн. Монгол орны хувьд Ковид-19 цар тахлын нөлөө аялал жуулчлалын салбарын урсгалд ихээхэн нөлөөлж жуулчдын тоо ийнхүү буурсан бол харин дотоодын аялагчдын тоо нэмэгдэж давхардсан тоогоор 1 саяд хүрсэн.

Гадагш аялах жуулчдын урсгал хязгаарлагдсан, дотоодод цар тахлын халдвар дэгдээгүй байснаас шалтгаалан 2020 оны 5-10 дугаар саруудад дотоодын жуулчдын урсгал эрс нэмэгдэж давтагдсан тоогоор 1 саяд хүрсэн нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 211 зочид буудал, 526 жуулчны бааз, амралтын газруудад эергээр нөлөөлж, цар тахлыг эдийн засгийн хүндрэл багатай давж гарахад дэмжлэг болсон.

Цар тахлын үед аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлсэн нэгдсэн арга хэмжээнээс гадна салбарт чиглэсэн дараах ажлуудыг тус яамнаас хэрэгжүүлж ажилласан бөгөөд жуулчны бааз, амралтын газруудад зориулсан хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкнуудтай хамтран бий болгож, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцаас

зээлийн хүүгийн татаас олгосон. Үүнээс аялал жуулчлалын ногоон зээлд нийт 32 аж ахуйн нэгж хамрагдаж, 3.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон.

Цар тахлын нөлөөгөөр олон улсын хил хаагдсан энэ үед дотоодын аялал жуулчлалыг идэвхжүүлэх цогц ажлыг зохион байгууллаа. Энэ хүрээнд дотоодод аялсан жуулчдын тоо 20 гаруй хувиар нэмэгдэж, дотоодын аялал жуулчлалын эдийн засгийн эргэлт 800 гаруй тэрбум төгрөгт хүрсэн байна. Түүнчлэн жуулчны бааз, амралтын газрууд, орон нутгийн хоол, худалдаа үйлчилгээний газруудын орлого дотоодын жуулчдын урсгалыг дагаж өссөн үзүүлэлттэй байна.


Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын 72 хувь нь аялж, амрахаар, 10 хувь нь албан ажлаар, 6 хувь нь гэр бүл, найз нөхдийндөө зочлохоор, 3 хувь нь суралцах аяллаар, 2 хувь нь бал сар тэмдэглэхээр ирсэн байна. Жуулчдын 41 хувь нь хувиараа, 59 хувь нь аялал жуулчлалын байгууллагаар үйлчлүүлж, 76 хувь нь дунджаар 14 хоног хүртэл хугацаатайгаар, үлдсэн 24 хувь нь 14 ба түүнээс дээш хоногоор аялдаг бөгөөд аяллынхаа хугацаанд нэг жуулчин нийт 2,048 ам.долларыг зарцуулдаг байна. Хувиараа аялагчдын зардлын (олон улсын тээврээс бусад) 27 хувь нь байршуулах хэрэгсэл, 25 хувь нь ресторан, хоолны үйлчилгээ, 25 хувь нь бараа, худалдаа,

15 хувь нь орон нутгийн зорчигч тээвэр, үлдсэн 6 хувь нь бусад үйлчилгээнд зарцуулагдаж байна.

2019 онд Монгол Улсын 3 сая гаруй иргэд давтагдсан тоогоор гадаад улс орнуудад аялсан үзүүлэлттэй байна. Үүнээс үзэхэд 2019 онд Монгол Улсад ирсэн гадаад жуулчдын тооноос илүү дотоодын иргэд гадаад улс орнуудад аялсан байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт улсын болон орон нутгийн, хувийн хөрөнгө оруулалтын төсвөөс 2020 оны жилийн эцсийн байдлаар 63.9 тэрбум төгрөгийг гэрээний дүнгээр зарцуулсан байна.

График 25. Хүн амын дундаж наслалт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нялхсын эндэгдэл 2020 онд 1,000 амьд төрөлтөд 12 болж өмнөх оноос 1 тохиолдлоор буурсан байна. Эхийн эндэгдэл 2020 онд 23 болж өмнөх оноос 5-аар нэмэгджээ. Эхийн эндэгдлийн харьцаа (100,000 амьд төрөлтөд ногдох) 30.0 болж, өмнөх оноос 7 (1.3 дахин)-гоор нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2020 онд нийт нас баралтын 6.7 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, үүний дотор 82.4 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 67.9 хувийг нярайн эндэгдэл

1.3. Хүн, нийгмийн хөгжил

1.3.1. Эрүүл мэнд

2020 онд улсын хэмжээнд 76,271 хүүхэд төрсөн нь өмнөх оноос 2.5 хувиар буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн тоо 2018 онд 4.3 хувиар, 2019 онд 0.9 хувиар өссөн бол 2020 онд ийнхүү буурчээ. Хүн амын дундаж наслалт 70.4 байгаа ба эмэгтэйчүүдийнх 75.96, эрэгтэйчүүдийнх 66.4 байна. Өмнөх онтой харьцуулахад эмэгтэйчүүдийн дундаж наслалт 0.18-аар, эрэгтэйчүүдийнх 0.27-оор, ерөнхий дундаж наслалт 0.22 насаар нэмэгджээ.

тус тус эзэлж байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1065 болж, өмнөх оноос 198 буюу 15.7 хувиар, нялхсын эндэгдэл 878 болж, 163 буюу 15.7 хувиар, нярайн эндэгдэл 596 болж, 51 буюу 7.9 хувиар тус тус буурчээ.


Хүн амын өвчлөл. Монгол Улсын хүн амын өвчлөлийн нийтлэг шалтгаанд халдварт бус өвчин зонхилж, хүн амын нас баралтын 78 хувийг эзэлж, салбарын нийт төсвийн 70 гаруй хувийг зарцуулж байна. Халдварт өвчнөөр өвчлөгчид 2020 онд 33.4 мянга болж, өмнөх оноос 11.9

мянга (26.2 хувь)-аар буурсан байна. Үүнд салхин цэцгээр өвчлөгчид 7,769 (72.9 хувь)-өөр, цусан суулгаар өвчлөгчид 2808 (51.6)-аар, вирүст хепатитаар өвчлөгчид 174 (33.0 хувь)-өөр, сүрьеэгээр өвчлөгчид 285 (7.9 хувь) –аар, гонококкт халдвараар өвчлөгчид 641 (11.1 хувь)-ээр, трихомониазаар өвчлөгчид 534 (10.7 хувь)-өөр, тэмбүүгээр өвчлөгчид 540 (7.6 хувь)-өөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2020 онд 35.4 мянга болж өмнөх оноос 22 хувиар буурчээ. Мөөгөнцөрт өвчнөөр өвчлөгчдийн тоо 171 хувиар өссөн бол гэдэсний халдварт өвчний тохиолдол 50 хувиар, амьсгалын замаар дамжих

халдварт өвчний тохиолдол 48 хувиар, цусаар дамжих өвчний тохиолдол 30 хувиар, бэлгийн замаар дамжих өвчний тохиолдол 4 хувиар, гар, хөл, амны өвчний тохиолдол 2 хувиар тус тус буурчээ. Нийт халдварт өвчний тохиолдлын 48 хувийг бэлгийн замаар дамжих өвчин, 24 хувийг амьсгалын замаар дамжих өвчин, 15 хувийг мөөгөнцөрт өвчин, 8 хувийг гэдэсний халдварт өвчин, 6 хувийг гар, хөл, амны өвчин, 1 хувийг цусаар дамжих өвчин тус тус эзэлж байна. Халдварт өвчин, тэр дундаа амьсгалын замаар дамжих өвчнөөр өвчлөгчдийн тоо ихээр буурсан нь коронавируст цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн хөл хориотой холбоотой.

График 26. Халдварт өвчнөөр өвчлөгсөд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүн амын нас баралт. Хүн амын нас баралт 2020 оны 12 дугаар сарын байдлаар 15,922 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 1,201 тохиолдлоор буюу 7.5 хувиар буурсан байна. Нас баралтын эхний 10 шалтгаанд элэг, цэсний сувгийн өмөн, зүрх судасны өвчлөл, тархины цус харвалт зэрэг өвчлөл, архины хордлого, амиа хорлолт зэрэг гадна шалтгаант 9,440 тохиолдол нь нас баралтын 54.5 хувийг эзэлж байна. Сэргийлж болох нас баралтын шалтгаан болох архины


хордлого нийт нас баралтын 5 дахь, амиа хорлолт 8 дахь шалтгаан болж байна.

Монгол Улсын хэмжээнд 2019 онд хорт хавдрын шинэ тохиолдол 6,045 бүртгэгдсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 734-өөр, өмнөх оноос 232-оор тус тус нэмэгдсэн байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын мэдээллээр дэлхийн дунджаар 100,000 хүн амд ногдох элэгний хорт хавдрын тохиолдлын тоо 8.4, түүнээс их байхыг

өвчлөл маш өндөр гэж тооцдог. Гэвч Монгол Улсад энэ үзүүлэлт 2019 онд 68.4 болж, даруй 8.1 дахин их байна. Монгол Улсад 2010-2019 оны хооронд 38,119 хүн хорт хавдрын шалтгаанаар нас барж нийт нас баралтын 22.8 хувийг эзэлж байна. 2019 онд хорт хавдрын нас

баралтын 4,801 тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 989 (25.9 хувь)-өөр, өмнөх оноос 389 (8.8)-өөр тус тус нэмэгджээ. Монгол Улсад 2019 онд нас баралтын тэргүүлэх шалтгаан зүрх судасны тогтолцооны өвчин байгаа бөгөөд 5,531 хүн зүрх, судасны өвчлөлтөөр нас барсан байна.

График 27. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 2019 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрүүл мэндийн үйлчилгээ. Улсын хэмжээнд 2019 онд нийт 11,788 их эмч байгаа ба өмнө жилээс 5.5 хувиар буюу 619 их эмчээр нэмэгджээ. 1,284 удирдах ажилтан, 12,773 сувилалч, 1,051 эх баригч, 870 багийн эмч, 1,027 бусад бага эмч, шүдний техникч 652, лаборант 1,253, эм найруулагч 1,899, эм зүйч 2,509, бусад ажилчид 1,274 байна. Дунджаар нэг их эмчид 271 хүн, нэг сувилалчид 250 хүн ногдож байна. Нийт 4,459 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас өрхийн эрүүл мэндийн төв 209, тосгоны эрүүл мэндийн төв 6, сумын эрүүл мэндийн төв 321, дүүргийн нэгдсэн эмнэлэг 13, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, бүсийн оношилгоо эмчилгээний төв 5, төв

эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд 24, амаржих газрууд 3, ортой хувийн эмнэлэг 237, хувийн эмнэлэг 1,444, сувилал 109, эм ханган нийлүүлэх байгууллага 356, эмийн үйлдвэр 40, эмийн сан 1,541 байна.

Эрүүл мэндийн даатгал. 2020 оны 12 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо өмнөх оноос 6 хувиар буурч 3.26 сая болсон байна. Тэдгээрийн 30 хувь буюу 964.7 мянга нь шимтгэлийг ажил олгогч хариуцан төлөгч, 8 хувь буюу 264.8 мянга нь шимтгэлийг өөрөө хариуцан төлөгч, 62 хувь буюу 2.03 сая нь шимтгэлийг улсын төсвөөс хариуцагч иргэд байна. Өмнөх онтой харьцуулахад шимтгэлийг өөрөө хариуцан төлөгч бусад даатгуулагчдын тоо хамгийн ихээр буюу 35 хувиар буурчээ.

Хүснэгт 17. Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоо, өсөлт

Үзүүлэлт	12/1/2019	12/1/2020	Өсөлт, бууралт, хувиар
Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид	3,449,501	3,257,853	-6.0
Шимтгэлийг ажил олгогч хариуцан төлөх иргэд	982,351	964,703	-2.0
Төсөвт байгууллагын ажилтан	282,381	287,765	2.0
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	699,970	676,938	-3.0
Шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэд	335,412	264,822	-21.0
Малчин	100,381	76,298	-24.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	201,419	162,720	-19.0
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	33,315	25,611	-23.0
Бусад даатгуулагч	297	193	-35.0
Шимтгэлийг улсын төсвөөс хариуцах иргэд	2,131,738	2,028,328	-5.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 оны 12 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 49.1 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин зардал 27 хувиар өсөж 62.4 тэрбум төгрөг болжээ. Орлогын 70 хувийг ажил олгогч даатгуулагчийн төлсөн шимтгэл, 28

хувийг төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл, 1 хувийг өөрөө хариуцан даатгуулагчийн төлсөн шимтгэл бүрдүүлж байна. Зардлын 90 хувийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд, 3 хувийг сувиллын тусламж, үйлчилгээнд, 7 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд тус тус зарцуулжээ.

Хүснэгт 18. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөг

Үзүүлэлт	12/1/2019	12/1/2020	Өсөлт, бууралт, хувиар
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	46,998.9	49,108.3	4.0
Даатгуулагчийн төлсөн шимтгэл	739.8	719.3	-3.0
Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн	39,253.7	34,409.3	-12.0
Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн	7,005.4	13,979.7	100.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал	49,082.6	62,364.1	27.0
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал	40,350.9	55,964.1	39.0
Сувиллын тусламж үйлчилгээний зардал	1,564.7	2,177.0	39.0
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	7,167.	4,223.0	-41.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийгмийн хамгаалал. УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Ковид-19 цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх 4 төрлийн багц арга хэмжээний авах 21 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолын

дагуу нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дурдвал:

- Хүүхдийн мөнгө: Ковид-19 цар тахалтай холбогдуулан хүүхдүүдэд 2020 оны 10 дугаар сарын 1 хүртэл сар бүр олгож байгаа 100 мянган төгрөгийг 2020 он дуустал олгосон.

- Тэтгэвэр, тэтгэмж: Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд 2020 оны 10 дугаар сарын 1 хүртэл хугацаанд сар бүр олгож байгаа 288 мянган төгрөгийн тэтгэмжийг 2020 он дуустал олгосон.

- Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлсөн.

- Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд олгож байгаа хүнсний талоныг 5 дугаар сарын 1-ээс 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хоёр дахин нэмэгдүүлсэн.

Түүнчлэн цар тахалтай холбогдуулан Улсын онцгой комиссоос сургууль, цэцэрлэг, үзвэр, сургалтын төвүүдийн үйл ажиллагааг бүрэн зогсоож бар, ресторан, үйлчилгээний төвүүдийн ажиллах цагийн хуваарьт өөрчлөлт оруулан, хилийн бүрэн хориог тогтоосон. Үүнээс гадна түр хугацаанд орон нутгийн зорчих хөдөлгөөнийг түр хязгаарласан. Эдгээр арга хэмжээг авснаар 1,439 цэцэрлэг, 820 сургууль, 175 их дээд сургууль, коллеж, 345 үзвэр үйлчилгээний цэгүүд бүрэн зогссон⁵. Хөл хорио тогтоосноос хамааран хамгийн их хохирол амсаж байгаа салбаруудад аялал жуулчлал, зочид буудал, үзвэр үйлчилгээ, хүн тээвэр болон нүүрс тээвэр, нийтийн хоол, бэлэн хувцас, тавилгын худалдааны салбар орж байна.

Улс хоорондын зорчих хөдөлгөөнийг зогсоож, хил хаах, хөл хорио тогтоох зэрэг арга хэмжээ авсны улмаас олон ажилчин, тэр дундаа албан бус эдийн засагт ажиллаж байгаа, тохиолдлын чанартай ажил эрхэлдэг хүмүүсийн хувьд ажилдаа ирж очиж чадахгүй, ажил эрхлэх боломжгүйд хүрч, цалин, орлогод нь шууд нөлөөлсөн байна.

Цар тахалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас нийгмийн халамжийн тэтгэмжүүдийг нэмэгдүүлсэн нь иргэдийн орлогыг тодорхой хэмжээнд өсгөж эерэг үр дүн гарсан. Эдгээр арга хэмжээг авснаар өндөр настан, хүүхэд, өрх толгойлсон эхчүүд, ядуу өрхүүдэд тодорхой хэмжээний дэмжлэг болсноор энэхүү бүлгүүд цар тахлын хөл хорионы улмаас нийгэмд учирч буй эрсдэлд бага өртжээ⁶.

Цар тахлаас урьдчилан сэргийлж хөл хорио тогтоосон нь хувиараа хөдөлмөр эрхлэгч болон хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг өрхүүдэд илүү нөлөөлжээ. Цар тахал гарсаар ажлаас халагдсан иргэд зөвхөн ажилгүйдлийн тэтгэмж авсан боловч Ковид-19 -ийн вакцин гартал орлоготой байх боломжгүй байна. Сургууль, цэцэрлэг, үзвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагааг зогсоож, төсвийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалт худалдан авалтыг тодорхой хэмжээгээр хязгаарласан нь тэдгээрийн дэд бүтэц буюу үйлчилгээ үзүүлэн амьжиргаагаа залгуулдаг бүлгийн санхүү эдийн засгийн байдал нэлээд дордсон, зээлийн эргэн төлөлтдөө барьцаалагдсан байдалтай байгаа юм.

1.3.2. Боловсрол

Улсын хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилийн эхний байдлаар 1,454 цэцэрлэг, ерөнхий боловсролын 839 сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын 75 байгууллага, 88 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байна. Нийт цэцэрлэгийн 948 буюу 65.2 хувь нь төрийн өмчийн, 506 буюу 34.8 хувь нь хувийн өмчийн байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 672 буюу 80.1 хувь нь төрийн өмчийн, 167 буюу 19.9 хувь нь хувийн өмчийн сургууль байна.


⁵ Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурийн төлөөлөгчийн газраас эрхлэн гаргасан-Ковид-19 үеийн Монгол Улсын нийгэм хамгааллын нөхцөл байдал

⁶ Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурийн төлөөлөгчийн газраас эрхлэн гаргасан-Ковид-19 үеийн Монгол Улсын нийгэм хамгааллын нөхцөл байдал

Сургуулийн өмнөх боловсрол. 2020 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын 247 мянган хүүхэд байгаа нь өмнөх жилээс 6.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт хамрагдагсдын 85.7 хувь буюу 211.7 мянган хүүхэд төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа бол 14.3 хувь буюу 35.3 мянган хүүхэд

хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өмнөх жилээс 80-аар нэмэгдэж 1,156 болжээ. Үүнээс 80 нь харааны, 70 нь ярианы, 64 нь сонсголын, 323 нь хөдөлгөөний, 8 нь сэтгэцийн, 41 нь оюуны, 152 нь аутизм, 82 нь дауны хам шинж, 316 нь хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна.

График 28. Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтын тоо, мянган хүүхэд



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

2020-2021 оны хичээлийн жилд 1,454 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагийн 65.2 хувь буюу 948 нь төрийн, 34.8 хувь буюу 506 нь хувийн цэцэрлэг байна. Нийт цэцэрлэгийн 684 нь хотод, 770 нь хөдөөд байрладаг. Улсын хэмжээнд нийт 8,499 бүлэг байгаа ба бүлэг дүүргэлт дунджаар 29.1 байна. Үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 29.2, төрийн цэцэрлэгт 30.8, хувийн цэцэрлэгт 21.7 байна.

Улсын хэмжээнд 30,668 багш, ажилтан ажиллаж байгаагийн 8,827 нь үндсэн багш, 7,819 нь туслах багш, 1,383 нь эрхлэгч, 790 нь арга зүйч, 22 нь ээлжийн багш, 29 нь сэргээн засалч, 653 нь эмч, 749 нь нягтлан бодогч, 10,396 нь бусад ажилчид байна. Үндсэн багшийн тоо өмнө жилээс 759-өөр, туслах багшийн тоо 949-өөр өсөж, нийт багш, ажилтны тоо 9.3 хувиар өсжээ.

Ковид-19 цар тахлын тухайн салбарт үзүүлж буй нөлөөлөл, хариу арга хэмжээ 2019-2021 оны хичээлийн жилд дэлхий нийтийг хамарсан цар тахлаас үүдсэн хорио цээрийн дэглэмийн үед сургуулийн өмнөх боловсролын сургалтыг тасралтгүй явуулах зорилгоор 4 сарын турш 1,700 минутын 170 хичээлийг бэлтгэн телевизээр сургалтыг зохион байгуулсан.

Энэ хичээлийн жилд теле хичээл үзэж чадаагүй цэцэрлэгийн 44,038 хүүхэд байгаа бөгөөд эдгээрийн 12,077 нь бэлтгэл бүлгийн, 690 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Сургуулийн өмнөх насны хүүхдийн суралцах онцлог нь насанд хүрэгчдийн дэмжлэгт тулгуурласан, шаардлага хангасан сургалтын орчинд, хүүхэд өөрөө үйлдэн суралцдаг онцлогтойг харгалзан цэцэрлэгийн орчинд багш, гэр бүлийн орчинд эцэг эх асран хамгаалагчдын дэмжлэгт

тулгуурласан нэгдмэл агуулга бүхий сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулж, шинэ арга зүй технологийг туршин хэрэгжүүлж байна.

Ерөнхий боловсрол. 2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн тоо өмнөх жилээс 2.3 хувиар өсөж 839 болсон ба тэдгээрийн 33 хувь буюу 277 нь хотод, 67 хувь буюу 562 нь хөдөө байна. Нийт ерөнхий боловсролын сургуулийн 80.1 хувь буюу 672 нь төрийн өмчийнх ба өмнөх жилээс 10-аар нэмэгдсэн байна. Харин 19.9 хувь буюу 167 нь хувийн өмчийнх ба өмнөх жилээс 9-ээр нэмэгджээ. Төрийн өмчийн сургуулийн 148 хотод, 524 нь хөдөөд, хувийн өмчийн сургуулийн 129 нь хотод, 38 нь хөдөөд байрлалтай байна. Нийт 72 бага сургууль, 109 дунд сургууль, 611

ахлах сургууль, 47 цогцолбор сургууль байна.

Нийт суралцагчдын тоо өмнөх оноос 6.3 хувиар өсөж 680.8 мянга болсон ба тэдгээрийн 92.9 хувь нь төрийн өмчийн, 7.1 хувь нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна. Суралцагчдын 52.4 хувь буюу 356.9 мянга нь бага, 32.6 хувь буюу 222.1 мянга нь дунд, 15 хувь буюу 101.8 мянга нь ахлах ангид тус тус суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо өмнө жилээс 7 хувиар буурч, 5,628 болжээ. Харааны бэрхшээлтэй 1,129, сонсголын бэрхшээлтэй 568, ярианы бэрхшээлтэй 732, сэтгэцийн бэрхшээлтэй 775, хөдөлгөөний бэрхшээлтэй 850, хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1,516 хүүхэд суралцаж байна.

Хүснэгт 19. Ерөнхий боловсролын сургууль болон сурагчийн тоо


Үзүүлэлт		2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
Сургууль		778	798	803	820	839
Өмчийн хэлбэр	Төрийн	645	652	656	662	672
	Хувийн	133	146	147	158	167
Байршил	Хот	225	239	245	258	277
	Хөдөө	553	559	558	562	562
Суралцагч /өдөр/		551,953	572,752	593,150	640,449	680,837
Нийт суралцагчид	Нэгдүгээр ангид суралцагч	62,000	67,974	72,247	76,892	78,219
	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	8,362	7,279	6,518	6,053	5,628
	Малчдын хүүхэд	104,530	109,618	114,198	119,080	124,444
Төрийн өмчийн сургууль		520,201	537,740	553,562	593,438	632,499
Хувийн сургууль		31,752	35,012	39,588	47,011	48,338

Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Нийт 22,979 бүлэг байгаагаас 48.7 хувь буюу 11,201 нь бага, 33.7 хувь буюу 7,744 нь дунд, 17.6 хувь буюу 4,034 нь ахлах ангийнхан байна. Тэдний 71.3 хувь нь нэгдүгээр ээлжид, 28.67 хувь нь хоёрдугаар ээлжид, 0.03 хувь буюу 8 бүлэгт нийт 251 суралцагч гуравдугаар

ээлжид хичээллэж байна. Гуравдугаар ээлжийн бүлгийн 75.0 хувь нь бага ангийн, 25.0 хувь нь ахлах ангийн бүлэг байна. Улсын дундаж бүлэг дүүргэлт 29.6 байгаа ба ахлах ангийнх 25.2, дунд ангийнх 28.7, бага ангийнх 31.9 байна. Мөн бүлэг дүүргэлт хотод 32.9, хөдөөд 27.3 байна.

График 29. Ерөнхий боловсролын сургуулийн дундаж бүлэг дүүргэлт, хот хөдөөгөөр



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Ерөнхий боловсролын байгууллагад улсын хэмжээнд 54.5 мянган багш, ажилчид ажиллаж байгаа ба тэдгээрийн 62.5 хувь буюу 34.1 мянга нь үндсэн багш нар байна. Үндсэн багшийн тоо өмнө жилээс 6.2 хувиар буюу 2 мянгаар өсжээ. Үндсэн багш нарын 89.2 хувь буюу 30,383 нь төрийн өмчийн сургуульд ажиллаж байгаа бөгөөд тэдний 37.9 хувь нь хотод, 62.1 хувь нь хөдөө ажиллаж байна.

Улсын хэмжээнд 540 дотуур байранд нийт 35 мянган хүүхэд амьдарч байна. 529 дотуур байр төрийн өмчийн сургуулийнх бол 11 дотуур байр хувийн өмчийн сургуулийнх байна. Нийт дотуур байранд сууж байгаа хүүхдүүдийн 95.9 хувь буюу 33.7 мянга нь хөдөө, 4.1 хувь буюу 1.5 мянган хүүхэд нь хотод суралцдаг байна.

Ковид-19 цар тахлын тухайн салбарт үзүүлж буй нөлөөлөл, хариу арга хэмжээ цар тахлын улмаас ерөнхий боловсролын 103,771 хүүхэд теле хичээл үзэж чадаагүй буюу сурлагын хоцрогдолд орсон байна. Эдгээр хүүхдийн 48,343 буюу 46.6 хувь нь бага ангийн, 39,701 буюу 39.3 хувь нь дунд ангийн, 15,727 буюу 15.2 хувь нь ахлах ангийн сурагчид байна. Энэ хичээлийн жилд шинээр элссэн боловч теле хичээл үзэж чадаагүй 1 дүгээр ангийн 9,818, 2 дугаар ангийн 11,183, төгсөх анги буюу 12 дугаар ангийн 4,408 суралцагч байгаа бол бага ангид 1,289, дунд ангид 1,000,

ахлах ангид 196 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

Хот, хөдөө орон нутаг, хотын захын сургуульд суралцаж буй хүүхдийн сургалтын чанарын ялгааг бууруулах, боловсролыг тэгш хүртээмжтэй олгох ажлын хүрээнд хичээлийг цахимжуулах, хичээл үзэх интернэт хандалтын тусгай сувгийг үнэ төлбөргүй болгох зэрэг ажлуудыг хийж байна.

Дээд боловсрол. 2020-2021 оны хичээлийн жилд дээд боловсролын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын тоо 7-оор буурч 88 болжээ. Үүнээс 72 нь магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд байна. Өмчийн хэлбэрээр үзвэл 20 нь нийтийн өмчийнх, 65 нь төрийн бус өмчийнх, 3 нь олон нийтийн/ шашны өмчийнх байна. Нийт сургалтын байгууллагын 42 хувь буюу 37 нь их сургууль, 53.4 хувь буюу 47 нь дээд сургууль, 4.5 хувь буюу 4 нь коллеж байна. Гадаадын 3 салбар сургууль үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт 147,293 оюутан суралцаж байгаа ба тэдний 61 хувь буюу 89,463 нь эмэгтэй 39 хувь буюу 57,830 нь эрэгтэй оюутан байна. Тэдгээрийн 52 хувь нь нийтийн өмчийн сургуульд, 43 хувь нь төрийн бус өмчийн сургуульд, 5 хувь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна. Нийт

оюутны тоо өмнө жилийнхээс 1 хувиар буюу 1,153-аар буурсан бол эрэгтэй оюутны тоо 43-аар, эмэгтэй оюутны тоо 1,110-аар буурчээ.

Гадаадын их сургуулийн салбар сургуульд суралцагчдын тоо 23 хувиар өсөж 234-т хүрчээ. Нийт суралцагчдын 0.1 хувь буюу 124 нь дипломын боловсрол, 80.9 хувь буюу 119,108 нь бакалаврын боловсрол, 16.8 хувь буюу 24,813 нь магистрын боловсрол, 2.2 хувь буюу 3,248 нь

докторын боловсрол эзэмшихээр суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 400 суралцагч байгаа ба тэд нийт суралцагчдын 0.3 хувийг бүрдүүлж байна. Их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчдийн тоо өмнө жилээс 43.3 хувиар өсөж 25,165 болжээ. Манай улсад гадаадын 1,443 оюутан суралцаж байгаагийн 644 нь бакалаврын, 544 нь магистрын боловсрол эзэмшихээр суралцаж байна.

Хүснэгт 20. Дээд боловсролын сургалтын байгууллагуудад суралцагчдын тоо

Суралцагчид	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
Суралцагчдын тоо	157,138	155,248	157,625	148,446	147,293
Эмэгтэй	91,526	90,094	93,552	90,573	89,463
Эрэгтэй	65,612	65,154	64,073	57,873	57,830
Нийтийн өмчийн сургуульд суралцагчид	91,798	89,473	87,992	82,901	76,844
Төрийн бус өмчийн сургуульд суралцагчид	65,075	65,628	69,370	65,355	63,545
Олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцагчид	-	-	-	-	6,904
Гадаадын их сургуулийн салбар сургуульд суралцагчид	265	147	263	190	234


Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

Дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчдын тоо 2020-2021 оны хичээлийн жилд 11,970-д хүрсэн ба энэ нь өмнө хичээлийн жилээс 5.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт ажилчдын 62.7 хувийг эмэгтэй ажилчид, 37.3 хувийг эрэгтэй ажилчид бүрдүүлж байна. 59.7 хувь буюу 7,143 нь үндсэн багш нар байна.

1.3.3. Шинжлэх ухаан, технологи

2019 оны байдлаар шинжлэх ухааны 62 байгууллага нийт 4,254 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Нийт ажилчдын 50 хувь нь буюу 2,126 нь эмэгтэй ажилчид юм. Шинжлэх ухааны салбарт ажиллагсдын тоо 2017 оноос хойш буурсаар байна. Нийт ажилчдын 78.8 хувь буюу 3,352 нь эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажилчид бөгөөд 136 нь шинжлэх ухааны доктор, 657 нь боловсролын доктор, 38 нь академич, 136 нь профессор, 166 нь дэд профессор байна.

График 30. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

График 31. Нийт олгосон патентын тоо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2019 оны байдлаар улсын төсвөөс санхүүжүүлсэн шинжлэх ухаан, технологийн 94 төсөл, онолын суурь судалгааны 215 төслийн ажлыг гүйцэтгэж байна. 2020 онд нийт 349 патент олгосны 225 нь бүтээгдэхүүний загварт, 124 нь шинэ бүтээлд олгогджээ.

1.3.4. Соёл

Улсын хэмжээнд нийт 345 соёлын төв 2,603 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд 2019 оны байдлаар соёл, урлагийн нийт 791 байгууллага 7,047 ажиллагчтай үйл ажиллагаа явуулж байна. Соёл, урлагийн нийт байгууллагын 4.4 хувь нь урлагийн байгууллага, 6.0 хувь нь музей, 46.0 хувь нь нийтийн номын сан, 43.6 хувь нь соёлын төв ордон, 11.2 хувь нь кино

үзвэрийн байгууллага байгаа бол нийт ажиллагчдын 36.4 хувь нь урлагийн байгууллагад, 9.0 хувь нь музейд, 11.3 хувь нь нийтийн номын санд, 33.8 хувь нь соёлын төв ордонд, 12.6 хувь нь кино үзвэрийн байгууллагад ажиллаж байна.

1.3.5. Биеийн тамир, спорт

Улсын хэмжээнд спортын салбарт 31 төрийн байгууллага, төрийн өмчит улсын үйлдвэрийн 3 газар, 77 тогтмол үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, төрийн өмчийн биеийн тамирын 1 дээд сургууль, төрийн бус өмчийн биеийн тамирын 3 дээд сургууль, 10 спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын дунд сургуулиуд үйл ажиллагаа явуулж байна. Биеийн тамир, спортын төрийн байгууллагад

нийтдээ 566 ажилтан ажиллаж байна. Төрөлжсөн сургалттай спортын 10 дунд сургуульд нийт 2,380 мянган суралцагч, 201 багш ажиллаж байна.

1.3.6. Нийгмийн хамгаалал

Хүүхдийн хөгжил, хамгаалал. Монгол Улсын хүн ам 2020 оны эцэст урьдчилсан дүнгээр 3.4 сая болж, өмнөх оноос 62.0 мянган (1.8 хувь) хүнээр өслөө. 1,000 хүнд ногдох төрөлт 23.2, нас баралт 4.8, ердийн цэвэр өсөлт 18.4 байна. 1,000 хүнд ногдох төрөлт өмнөх оноос 1.1 нэгж хувь, нас баралт 0.4 нэгж хувиар буурчээ. Улсын хэмжээнд 2020 онд 77.9 мянган хүүхэд төрсний 1,685 (2.2 хувь) нь гадаадад, 76.3 мянган хүүхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт төрсөн нь өмнөх оноос 1,962 (2.5 хувь)-оор буурсан байна. Нийт нас баралтын 4,463 (28.0 хувь) нь эмнэлэгт, 11,461 (72.0 хувь) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх оноос 1,281 (7.4 хувь)-ээр, гэрийн (бусад газарт) нас баралт 839 (6.8 хувь)-өөр, эмнэлгийн нас баралт 442 (9.0 хувь)-оор тус тус буурчээ.

Улсын хэмжээнд 2020 онд 38.0 мянган өнчин хүүхэд байгаагийн 3.0 мянга (8.0 хувь) нь бүтэн өнчин хүүхэд, 35.0 мянга (92.0 хувь) нь хагас өнчин хүүхэд байна. Нийт өнчин хүүхдийн 3.6 мянга (9.6 хувь) нь 0-4 насны, 9.5 мянга (25.0 хувь) нь 5-9 насны, 13.7 мянга (35.9 хувь) нь 10-14 насны, 3.9 мянга (10.3 хувь) нь 15 насны, 3.7 мянга (9.7 хувь) нь 16 насны, 3.6 мянга (9.5 хувь) нь 17 насны хүүхэд байна.

Залуучуудын хөгжил, оролцоо. 2020 оны байдлаар нийт хүн амын 65 гаруй хувийг 35 хүртэлх насныхан эзэлж байна. 2020 оны байдлаар улсын хэмжээнд 1.2 сая ажиллах хүч байгаагийн 36.7 хувь нь 15-34 насны залуус байна. Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 53.9 хувийг 15-34 насны залуус, үүний дотор 3.3 мянга нь буюу 18.2 хувийг 15-


24 насны залуус, 6.4 мянга нь буюу 35.6 хувийг 25-34 насны залуус эзэлж байна.

Ахмад настны хөгжил, хамгаалал. Ганц бие амьдарч буй өндөр настай хүний тоо 2020 оны эцэст 41.7 мянга болж, өмнөх оноос 2,165 (5.5 хувь)-аар өссөн байна. Ганц биеэрээ амьдарч буй өндөр настай нийт хүний 11.0 мянга (26.5 хувь) нь 60 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүд, 30.7 мянга (73.5 хувь) нь 55 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүд байна. Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүний тоо 2020 оны эцэст 3.4 мянга болж, өмнөх оноос 204 (6.5 хувь)-өөр нэмэгдсэн байна. Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүний 1.1 мянга (33.8 хувь) нь 60 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүд, 2.2 мянга (66.2 хувь) нь 55 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2020 онд өмнөх оноос 1.3 мянгаар нэмэгдэж 108.3 мянгад хүрчээ. Үүний 43.5 хувь буюу 47.2 мянга нь эмэгтэйчүүд, 56.5 хувь буюу 61.2 мянга нь эрэгтэйчүүд байна. Тэдний 10.9 хувь нь харааны, 3.8 хувь нь ярианы, 8 хувь нь сонсголын, 20.1 хувь нь хөдөлгөөний, 19.1 хувь нь сэтгэцийн, 7.1 хувь нь хавсарсан, 30.9 хувь нь бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 293 (1.6 хувь) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 152 (51.9 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Нийгмийн даатгал. 2020 оны 12 дугаар сарын байдлаар нийт 1.15 сая хүн нийгмийн даатгалд хамрагдаж байгаагаас 83.4 хувь нь албан журмаар даатгуулагчид, 16.6 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Албан журмын даатгуулагчид өмнөх жилийн мөн үеэс 1.8 хувиар буурсан бол сайн дураар даатгуулагчид 3.3 хувиар өсөж, нийт нийгмийн даатгалын хамрагдалт 1 хувиар буурчээ.

График 32. Нийгмийн даатгалд хамрагдагсдын тоо, мянган хүн



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2020 оны 12 дугаар сард 2.2 их наяд төгрөг байсан нь өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өссөн үзүүлэлт

юм. Нийт тэтгэврийн 76.5 хувийг өндөр настны тэтгэвэр, 12.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, 3.7 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 7.0 хувийг цэргийн тэтгэвэр бүрдүүлж байна.

График 33. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ, төрлөөр, мянгаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тэтгэвэр авагчдын тоо 2020 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсөж 449.2 мянган хүнд хүрчээ. Үүний 75.5 хувь нь өндөр настны тэтгэвэр, 15.8

хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, 4.5 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 4.3 хувь нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

График 34. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, төрлөөр, мянгаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2016-2019 онд нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага өсөлттэй байсан ч 2020 онд орлого нь 4.8 хувиар буурч, зарлага нь 28.0 хувиар өсжээ.

Хүснэгт 21. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлт		2016-XII	2017-XII	2018-XII	2019-XII	2020-XII
Бүгд	Орлого	1,875,743	2,118,869	2,402,973	2,822,498	2,688,265
	Зарлага	1,786,182	1,890,084	2,145,714	2,507,086	3,210,047
Тэтгэврийн даатгалын сан	Орлого	1,284,009	1,447,847	1,703,832	2,069,433	2,043,301
	Зарлага	1,330,959	1,416,713	1,620,022	1,837,441	2,175,307
Тэтгэмжийн даатгалын сан	Орлого	90,581	109,019	130,028	156,594	127,606
	Зарлага	94,293	100,264	114,050	128,365	147,968
Эрүүл мэндийн даатгалын сан	Орлого	326,866	370,533	312,822	340,523	338,609
	Зарлага	273,070	293,886	311,734	344,013	322,111
ҮОМШӨ-ний даатгалын сан	Орлого	133,073	147,595	212,621	213,937	142,618
	Зарлага	48,855	44,064	64,967	114,706	469,673
Ажилгүйдлийн даатгалын сан	Орлого	41,214	43,875	43,671	42,012	36,131
	Зарлага	39,005	35,156	34,941	82,561	94,988

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.3.7. Нийгмийн халамж

2020 оны 12 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсад өмнөх жилийнхээс 8.3 хувиар өсөж, нийт 2.5 сая хүн халамжид хамрагдаж байна. Тэдгээрийн 16.8 хувь буюу 430 мянган хүн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээнд хамрагддаг бол 46.5 хувь буюу 1.2 сая хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагддаг

байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдагсдын тоо өмнөх оныхоос 18.6 хувиар өсжээ.

59.1 мянган хүн нийгмийн халамжийн тэтгэвэр, 64.3 мянган хүн асаргааны тэтгэмж, 57.4 мянган хүн онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж, 38.4 мянган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламж, 236.7 мянган хүн ахмад настны хөнгөлөлт, тусламж үйлчилгээг, 2.5 мянган хүн алдар цолтой ахмад настны

нэмэгдлийг тус тус халамжийн сангаас аваад байна. Түүнчлэн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 242 мянган хүн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 6.8 мянган хүн,

эхийн алдар одонгийн урамшуулалд 230 мянган хүн, насны хишгийн урамшуулалд 141.8 мянган хүн, цаатан иргэний тэтгэмжид 397.0 мянган хүн тус тус хамрагджээ.

График 35. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсад, 2016-2020 он, мянган хүн




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийгмийн халамжийн үйлчилгээнд 2020 оны 10-р сарын байдлаар нийт 1.3 их

наяд төгрөгийг зарцуулжээ. Энэ нь өмнөх оныхоос 2.3 дахин өссөн дүн юм.

График 36. Нийгмийн халамжийн үйлчилгээний зардлын дүн, 2018-2020 он, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардал 2018-2020 онд бусад нийгмийн халамжийн үйлчилгээний

зардлуудтай харьцуулахад өсөлт хамгийн ихтэй байсан ба үүн дотроос хүүхдийн мөнгөн тэтгэмж 2019-2020 онд 4.4 дахин өсжээ. Энэ өсөлт нь нийт нийгмийн халамжийн зардал өсөхөд нөлөөлжээ.

1.4. Байгаль орчин, ногоон хөгжил

Уур амьсгалын өөрчлөлт. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг улсын нэгт тооцогдож байна. Монгол Улсын хүлэмжийнхийн ялгаруулалтын нүнэмлэхүй хувь хэмжээ бага боловч нэг хүнд ногдох дотоодын үйлдвэрлэлд ногдож буй хувь хэмжээгээр дэлхийн дундаж хувиас давдаг. Түүнчлэн газар зүйн байрлал, аж ахуй эрхлэх арга, амьдралын хэв загвар зэрэг нь уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг улс үндэстний нэг гэж тооцогдоход нөлөөлж байна.

Хүлэмжийн хийн ялгаралтыг 23 хувиар бууруулах зорилт тавьж байна. Парисын хэлэлцээр 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн ба тус хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд Монгол Улс өмнө нь 2015 онд тодорхойлсон хүлэмжийн хийн ялгаралтыг 2030 он гэхэд 14 хувиар бууруулах зорилтоо ахиулан 22.7 хувь болгон тодорхойлж, Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг батлуулан НҮБҮАӨСК-ын Нарийн бичгийн дарга нарын газарт 2020 оны 10 дугаар сард хүргүүлсэн юм.

Тусгай хамгаалалттай газар нутаг. Нийт нутаг дэвсгэрийн 21 хувь буюу 32.7 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад аваад байна. Улсын хэмжээнд 13.8 сая га талбай бүхий 21 дархан цаазат газар, 13.5 сая га талбай бүхий 37 байгалийн цогцолборт газар, 5.3 сая га бүхий 48 байгалийн нөөц газар, 0.1 сая га газар бүхий 14 дурсгалт газар буюу нийт 120 газар нутгийн 32.7 сая га газрыг тусгай хамгаалалтад авч байгалийн үндсэн бүс, бүслүүрийн унаган төрхийг хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад голлох үүрэг гүйцэтгэж байна. Газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 50 хувь, ойн сан бүхий газрын 40 хувь, 350 орчим

зүйлийн ховор болон нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах боломж бүрдсэн. Мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 23.4 сая га газар буюу нийт газар нутгийн 15 хувь харьяалагдаж байна.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн хүрээнд хамгаалалтыг хэрэгжүүлж байна. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт 34 хамгаалалтын захиргаа ажиллаж байгаагаас 30 хамгаалалтын захиргааг Улсын төсвөөс санхүүжүүлж, 4 хамгаалалтын захиргааг хувийн хэвшил менежментийн гэрээгээр хариуцан ажиллаж, менежментийн төлөвлөгөөг олон улсын (open standard) аргачлалаар боловсруулж байгаль орчны багц хууль, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан нийт 827 албан хаагч ажиллаж байгаагаас 476 байгаль хамгаалагч байна. 2015-2020 онд ХБНГУ-ын Засгийн газар, Сэргээн босголт зээлийн банкны буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжсэн Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн хүрээнд нийт 17.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Ус. Манай орон хязгаарлагдмал усны нөөцтэй орны тоонд ордог. Нийт 564,800 сая шоо метр нөөцтэйгөөс 10,500 сая шоо метрийг ашиглах боломжит нөөц гэж тооцдог. Гэвч энэхүү усны нөөцийн дийлэнх буюу 80 хувь орчим нь нутаг дэвсгэрийн 30 хувьд буюу Хангайн бүсэд, томоохон голуудын хөндийд бүрэлдэн бий болдог. Одоо улсын хэмжээнд жилд 570 гаруй сая шоо метр ус ашиглаж байгаагийн 50 хувь гаруйг газрын доорх усаар хангаж байна. Нийт ус ашиглалтын 14 хувь унд ахуйн хэрэглээнд, 53.7 хувь хөдөө аж ахуйд, 5.6 хувь эрчим хүчний үйлдвэрлэлд, 15.7 хувь уул уурхайд, 11.1 хувь үйлдвэр, ахуй үйлчилгээнд ашиглагдаж байна.

Ирэх 10 жилд усны хэрэглээ 3-4 дахин нэмэгдэх тооцоотой байна. Монгол

орны хэмжээнд усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр усны 29 сав газарт хувааж, усны 21 Сав газрын захиргаанд 200 хүн, 8 сав газрын зөвлөл ажиллаж байна. Сав газрын захиргаадыг байгуулснаар усны салбарыг орон нутагт хариуцах байгууллагатай болж, усны ашиглалт, хамгаалалт сайжирч, үрэлгэн хэрэглээг багасгаж, орон нутгийн төсвийн орлого хэд дахин нэмэгдсэн. Хүн амын өсөлт, хотжилт, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн хөгжлийн хурдац, төлөвлөлтийг харгалзан гол ус хэрэглэгчдийн хэтийн төлөвийг тоймлон тооцож үзэхэд 2030 онд усны хэрэглээ 3-4 дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Усны нөөц хангалтгүй бөгөөд ширгэж байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Гэхдээ ойрын болон хэтийн хэрэглээг хангахад усны нөөцийн жигд бус тархалт, уур амьсгалын өөрчлөлт хүндрэл учруулахаар байна. 2019 оны усны тооллогын дүнгээр 264 гол горхи, 704 булаг шанд, 286 нуур тойром ширгэсэн. Цаашид усны температур нэмэгдэж, ууршиц ихэсч, урсац буурах хандлагатай байна. Ялангуяа говь хээрийн бүс байгалийн аясаар хуурайшиж, усны нөөцийг ууршилтаар алдаж байгаа нь усны хомстлыг бий болгож байна. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хур тунадасны хэмжээнээс хамаарч сүүлийн жилүүдэд гол, горхи, нуур, цөөрөм ширгэж байна. 2019 оны усны тооллогын дүнгээр 264 гол горхи, 704 булаг шанд, 286 нуур тойром ширгэсэн судалгааг гаргаад байна.

Агаарын бохирдол. Улаанбаатар хот төдийгүй аймгийн төвүүдийн агаарын бохирдол ихэсч, ялангуяа өвлийн улиралд Улаанбаатар хотын хэмжээнд нийт ажиглалтын 50 гаруй хувьд Монгол Улсын Агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой байгаа ба Улаанбаатар хот болон орон нутгийн агаарын чанарт нөлөөлж, бохирдуулж байгаа гол

бохирдуулах бодисууд нь тоосонцор, хүхэрлэг хий, азотын давхар исэл байна.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарч тодорхой ажлууд хийгдэж байгаа нь үр дүнгээ өгч Монгол Улсын Засгийн газрын 2017 онд баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд агаарын бохирдлын хэмжээг суурь түвшин (2016 он)-тэй харьцуулахад PM2.5 тоосонцрын агууламж 2020 онд 59 хувь, PM10 тоосонцрын агууламж 2020 онд 53 хувиар тус тус доогуур байна.

Агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын 196,588 айл өрхийн гэрийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын 2,742 халаалтын зуух гаргаж, 10 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа 501,683 авто тээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд гаргаж, 4 хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэрээс ялгарч байгаа утаа, тоос тортог эзэлж байна.

Орон нутагт 2020 онд агаарын чанарыг хянах 25 (аймгийн төвүүдэд 22, томоохон суурин газар 3) суурин харуул ажиллаж агаар дах хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂)-ийг хоногт 2-3 удаа 20 минутын дунджаар сорьц авч, лабораторид химийн урвалж бодис ашиглан тодорхойлж байна. Харин PM10 тоосонцрыг багаж тоног төхөөрөмжийн хүрэлцээ, хүчин чадлаас хамаарч 7 аймагт 7 хоногт 2 удаа, 3 аймагт өдөр бүр тасралтгүй 24 цагийн дунджаар хэмжиж байна.

2020 онд орон нутаг дахь агаарын чанарыг хянах суурин харуулуудын хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 4-43 мкг/м³-ийн хооронд хэлбэлзэж, үүнээс зөвхөн Баянхонгорт агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 2.1 дахин их байсан ба 2019 онтой харьцуулахад 17 мкг/м³-ээр буюу 65 хувиар их агууламжид

хүрсэн байна. Бусад аймгийн хувьд хүхэрлэг хийн 2020 оны жилийн дундаж агууламж агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй.

Ой. Монгол Улсын ойн сангийн нийт талбайн 84.9 хувийг нутгийн хойд хэсэгт тархах шилмүүст, навчит ой, 15.1 хувийг нутгийн өмнөд хэсгийн говь, цөлийн бүсэд тархах заган ой эзэлнэ. Ойн сангийн талбай 18,608.0 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.9 хувийг эзлэх ба үүний 12,452.0 мянган га нь ойгоор

бүрхэгдсэн (байгалийн болон таримал ой, гол мөрний дагуух бургас, сөөг), 5,634.4 мянган га нь ойгоор бүрхэгдээгүй (тармаг мод, байгалийн аясаар ойжиж байгаа болон зориудаар ойжуулж байгаа газар, түймэр, мод бэлтгэл, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ой), 521.6 мянган га нь ойн сан доторх ойн бус талбайд хамаарна. Ойн сангийн 15,471.5 мянган га буюу 83.1 хувь нь хамгаалалтын бүсийн, 3,136.5 мянган га буюу 16.9 хувь нь ашиглалтын бүсийн ойд хамаарч байна.

График 37. Ойн сав газрын төрлийн ангилал, 2020 он



Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Ойн сангийн талбайн 2020 оны үзүүлэлтийг 2018 онтой харьцуулахад нийт талбай 15.3 мянган га-аар, ойгоор бүрхэгдсэн талбай 59.2 мянган га-аар тус тус нэмэгдэж, ойрхог чанарын эзлэх хувь 8.0 хувь болж 0.1 хувиар өссөн байна. Ойн нийт нөөц 1,248,642,118.0 шоо метр бөгөөд үүний 79.28 хувийг шинэс, 8.91 хувийг хуш, 5.96 хувийг хус, 4.95 хувийг нарс, 0.23 хувийг гацуур, 0.01 хувийг жодоо, 0.18 хувийг улиас, 0.05 хувийг улиангар, 0.01 хувийг хайлаас, 0.28 хувийг бургас, 0.14 хувийг заг, тоорой тус тус эзэлж байна. Шилмүүст мод зонхилсон ойн дундаж нас 131 жил, 1га-ийн нөөц 142.8м³, өсөлт 1.1м³, навчит мод зонхилсон ойн дундаж нас 43 жил, 1

га-ийн нөөц 44.4м³, өсөлт 1.02м³, жилийн бүх дундаж өсөлт 10,251.5 м³ байна.

Улсын хэмжээнд 38 сум дундын ойн анги, 5 сумын ойн анги, аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дэргэд 8 ойн алба тус тус ажиллаж, орон нутагт ойн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж байна. 2020 оны байдлаар, 1342 ойн нөхөрлөл 4,541.9 мянган га, 131 аж ахуйн нэгж 627.4 мянган га ойн санг тус тус гэрээгээр эзэмшиж ашиглан хамгаалж байна.

Улсын хэмжээнд 2019-2020 онд 30 аймгийн /давхардсан тоогоор/ 140 суманд 263 удаагийн ой, хээрийн түймэр гарч 59.8

мянган га ой, 496.4 мянган га хээр, нийт 556.2 мянган га талбай өртжээ. Түймрийн улмаас 24.9 тэрбум төгрөгийн экологийн хохирол учирч, түймрийг унтраахад 548.5 сая төгрөгийн зардал гарч, нийт хохирол 25.4 тэрбум төгрөг болжээ. Ой, хээрийн түймрийн 2019-2020 оны мэдээг 2017-2018 онтой харьцуулахад түймрийн тоо 39 тохиолдлоор, түймэрт өртсөн талбайн хэмжээ 599.9 мянган га-гаар, хохирлын хэмжээ 91.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Ой, хээрийн түймрийн эрсдэлийн орон зайн тархалтын 1:1500000 масштабтай зургийг улсын хэмжээгээр болон түймрийн эрсдэл бүхий аймаг, улсын тусгай хамгаалалтай газар бүрээр боловсруулан гаргасан. Эрсдэлийн зургаас харахад Монгол орны ойн сангийн навчит шилмүүст ой болон Дорнод Монголын

хээр тал бүхэлдээ түймрийн өндөр болон нэн өндөр эрсдэлтэй бүсэд хамаарч байна.

Улсын хэмжээнд 2019 онд улс, орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 2,392.5 га талбайд, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 4,683.5 га талбайд, ойн зурвас байгуулах ажлыг 1,878.1 га талбайд хийж, ойжуулах, ойг нөхөн сэргээх ажлыг нийт 8,954.1 га талбайд хийсэн бол 2020 онд улс, орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 3,088.7 га талбайд, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 582.0 га талбайд, ойн зурвас байгуулах ажлыг 371.5 га талбайд хийж, ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг нийт 4,042.2 га талбайд хийсэн.

Хүснэгт 22. Ойн нөхөн сэргээх ажил, 2016-2020 он

Арга хэмжээ	2016	2017	2018	2019	2020
Үр бэлтгэх талбай, га	-	50.0	50.0	20.0	20.0
Үрийн нөөц, кг	477.0	460.0	314.0	175.5	64.5
Тарьц, сая.шир	30.0	34.6	34.6	38.9	41.6
Ойжуулалт, га	3163.0	2381.6	3221.8	2392.5	3088.7
Ойн зурвас, га	172.0	223.5	345.9	1878.1	371.5
Байгалийн сэргэн ургалтад туслах, га	100.0	1067.0	2459.9	4683.5	582.0
Нийт	3435.0	3672.1	6027.6	8954.1	4042.2

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Хөрс хамгаалал. Улаанбаатар хотын хөрсний бохирдол, экогеохимийн судалгаагаар 360 цэгээс сорьц авч шинжлэхэд 88 хувьд нь нян, хөгц мөөгөнцөр илэрсэн байна. Хот, суурин газарт гэр хорооллын ариун цэврийн

байгууламжтай (жорлон, муу усны нүх) холбоотой нянгийн бохирдол өндөр байдаг бол орон нутагт уул уурхайн үүдэлтэй хөрсний бохирдол их байна. Байгаль цаг уурын болон хүний үйл ажиллагаанаас үүдэн доройтсон газрын дөнгөж 1/3-ийг нь нөхөн сэргээж байна.

Хүснэгт 23. Цөлжилтийн үйл явцын хандлага, хувь

Цөлжилтийн үнэлгээ хийсэн он	Сул илэрсэн нутаг	Дунд зэрэг илэрсэн нутаг	Хүчтэй илэрсэн нутаг	Нэн хүчтэй илэрсэн нутаг	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
2006 он	23.0	26.0	18.0	5.0	72.0
2010 он	35.3	25.9	6.7	9.9	77.8
2015 он	24.1	29.8	16.8	6.1	76.8
2020 он	31.5	22.1	18.6	4.7	76.9

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

2020 онд хийсэн цөлжилт, газрын доройтлын судалгаанд нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь нь цөлжилт, газрын доройтолд тодорхой хэмжээгээр өртсөн бөгөөд үүнээс хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газар 23.3 хувийг эзэлж байна.

1.5. Засаглал, хууль, эрх зүйн шинэтгэл

Цагдаагийн байгууллага. Улсын хэмжээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 10,302 (цагдаа - 9,253, дотоодын цэрэг - 1,049) алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нийт бүрэлдэхүүний 5,046 буюу 49.0 хувь нь офицер, 4,834 буюу 46.9 хувь нь ахлагч, 470 буюу 4.6 хувь нь энгийн ажилтан, 8,771 буюу 85.1 хувь нь эрэгтэй, 1,531 буюу 14.9 хувь нь эмэгтэй алба хаагч байна. Нийт алба хаагчдын 6,470 буюу 62.8 хувь нь Улаанбаатар хотод, 3,832 буюу хувь 37.2 хувь нь орон нутагт ажиллаж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 23,064, нийслэлд 14,633 (63.4 хувь), орон нутагт 8,420 (36.5 хувь), бусад газар (хилийн чанадад үйлдэгдсэн) 11 (0.04 хувь) гэмт хэрэг бүртгэгдсэнийг өмнөх

онтой харьцуулахад нийт хэрэг 8,460 буюу 26.8, нийслэлийн хэмжээнд 5,628 буюу 27.8, орон нутгийн хэмжээнд 2,784 хэрэг буюу 24.8, бусад газар 48 буюу 81.4 хувиар тус тус буурсан. Улсын хэмжээнд нийт 2,276,868 зөрчил шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 101,043 буюу 4.6 хувиар, 2, 272,346 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 104,011 буюу 4.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэн батлагдсан 2017 оноос хойш баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн хүний тоо 120-оос 400 болж 2.3 дахин нэмэгдсэн. Мөн цагдан хорих төв, байруудад 2019 онд 8,206, 2020 онд 3,245 хүн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч хоригдсон байна.

Гадаадын иргэн харьяатын газар. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр УИХ-аар хэлэлцэн батлагдсантай холбогдуулан Хуульзүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан.

1.6. Гадаад харилцаа

Монгол Улс 193 улс оронтой дипломат харилцаатай. Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох зорилтын хүрээнд 2019 онд нэг улс, 2021 онд нэг улстай дипломат харилцаа тогтоосон.

Хөрш орнуудтай харилцах харилцаа. ОХУ-тай тогтоосон стратегийн түншлэлийн харилцааг шат ахиулах бодлогыг баримтлан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Владивосток хотноо 2019 оны 9 дүгээр сард болсон Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад оролцож, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтэй хоёр талын уулзалт хийсэн. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2010 оноос хойш анх удаа Засгийн газрын тэргүүний түвшинд ОХУ-д 12 дугаар сард албан ёсны айлчлал хийв. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2019 онд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр улсын төрийн тэргүүн нар гарын үсэг зурсан Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээг соёрхон батлах тухай хуулийг ОХУ-ын Төрийн Дум 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр баталсан.

БНХАУ-тай тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Ковид-19 цар тахлын ид үед буюу 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдөр БНХАУ-д айлчилж, БНХАУ-ын дарга Ши Жиньпин, Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көчян нартай уулзан 30 мянган хонь хандивлан, эв санааны нэгдлээ илэрхийлсэн нь хоёр талын улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлэх, ард түмний найрсаг харилцааг гүнзгийрүүлэхэд чухал түлхэц үзүүлсэн айлчлал болсон.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И Монгол Улсад 2020 оны 9 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр талууд Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ноот бичиг солилцож, ЭЗТХА-ны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, ГХЯ хоорондын 2021-2022 оны хамтран ажиллах төлөвлөгөө, Монгол Улсаас БНХАУ-д гурил экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээрийн шаардлагын тухай протокол зэргийг байгуулав.

Худалдаа эдийн засгийн харилцаа. Хөрш орнууд болон голлох түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, Монголын экспортын бараа бүтээгдэхүүний гадаад зах зээлийг өргөтгөх, худалдааг хөнгөвчлөх асуудлыг анхааран ажиллаж байна.

БНХАУ-д нийлүүлэх нүүрс, мах, махан бүтээгдэхүүний экспортыг сэргээхэд онцгой анхаарал хандуулж, Хятадын талтай зохицуулалт хийсний дүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 2020 оны 5 дугаар сараас жигдэрч, 7-11 дүгээр сард боомтуудаар нэвтрүүлж буй нүүрсний хэмжээ өнгөрсөн оны тухайн саруудаас 10 орчим хувиар өссөн.

Швейцарын Холбооны Улсын Давос хотноо 2020 оны 1 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд болсон Дэлхийн эдийн засгийн 50 дугаар чуулга уулзалтад Ерөнхийлөгч Х.Баттулга оролцсон нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн байдлыг танилцуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал ач холбогдолтой болсон.

Евразийн эдийн засгийн комиссын Зөвлөлөөс Монгол Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны

Ажлын хэсэг байгуулах шийдвэр гаргаж, анхдугаар хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулав.

Иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар

ГХЯ-наас санаачлан Ковид-19 цар тахлын улмаас гадаад улсад гацсан, ахуй амьдрал нь хүнд байдалд орж эх орондоо буцах хүсэлт гаргасан иргэдийг татан авах ажилд НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-тай хамтарч ажиллаж, хилийн чанадад гацсан, хүнд байдалд орсон 800 орчим иргэнд 3.16 тэрбум төгрөгийн тусламжийг үзүүлэв. ОУШХБ-аас нийт 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 618 иргэнийг татан авсан.

Олон улсын гэрээ, эрх зүйн харилцаа.

2020 онд манай улс олон талт 5 гэрээнд нэгдэн орсон бөгөөд Засгийн газар хоорондын 17 гэрээ байгуулж, өнгөрсөн онд байгуулсан 9 гэрээг хүчин төгөлдөр болгосон. Байгууллага хоорондын 24 гэрээ байгуулж бүртгэсэн бол гэрээний төсөлд санал өгөх, орчуулгыг хянах зэрэг байгууллага хоорондын нийт 79 гэрээ байгуулахтай холбоотой үйл явцад оролцов.

1.7. Батлан хамгаалах

Батлан хамгаалах салбарт мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгож, салбарын хөгжлийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж, шинээр боловсруулж батлуулан мөрдөж байна. 2018-2021 онд хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн түвшинд 5 дүрэм, журам, Засгийн газрын түвшинд 20 орчим журмыг баталгаажуулан хэрэгжүүлж байна. Түүнчлэн 2018-2021 онд Засгийн газрын хуралдаанаар батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэх,

Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх бодлого, үйл ажиллагаатай холбоотой 70 орчим асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Зэвсэгт хүчний хэмжээнд дагаж мөрдөх 40 орчим дүрэм, журам, зааврыг батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Зэвсэгт хүчний удаан хугацааны хадгалалтад байгаа хуягт танкийн техникийн 10 орчим хувьд сэргээн сайжруулах засвар, үйлчилгээ хийж, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр 30 гаруй нэгж цэргийн техник, гадаад орнуудын буцалтгүй тусламжаар 100 гаруй цэргийн техникийг хүлээн авсан.

Улаанбаатар цэргийн хүрээний ангиудын 80 орчим хувь, хөдөө орон нутагт байрлалтай анги, байгууллагуудын 40 хувь нь өндөр хурдны шилэн кабелд холбогдоод байна.

Батлан хамгаалахын гадаад харилцаа, энхийг дэмжих ажиллагаан дахь Зэвсэгт хүчний оролцоог өргөжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн түвшин:

Монгол Улсын аюулгүй байдлыг цэрэг улс төр, дипломатын аргаар хангах бодлогын хүрээнд батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, 37 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон, хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Үүнээс 5 улстай (ОХУ, БНХАУ, Украин, Беларусь, Турк) нь цэрэг техникийн хамтын ажиллагаатай байна.

Батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааны хүрээнд дараах гэрээ, хэлэлцээрийг байгуулсан байна. Үүнд:

Дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдал, хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, түүний хэрэгжилт, цаашдын төлөв, чиг хандлагын талаар харилцан ярилцаж, санал солилцох, шийдвэр гаргах зорилгоор 10 улс (ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГУ, БНСУ, Япон, Их

Британи, Австрали, БНТУ, БНЭУ), олон улсын нэг байгууллага (НАТО)-тай Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалтыг 2018-2020 онд амжилттай зохион байгууллаа.

2018-2021 онд Батлан хамгаалахын сайд Монгол Улстай стратегийн иж бүрэн, стратегийн түншлэлийн харилцаатай болон бүс нутгийн орнуудын Батлан хамгаалахын сайд нартай хийх уулзалтыг нэмэгдүүлж, батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тодорхой хувь нэмрийг оруулсан. Тухайлбал, Батлан хамгаалахын сайд ОХУ, БНХАУ, АНУ, Герман, Япон, БНСУ, Турк, Вьетнам, Энэтхэг Улсад албан ёсны айлчлал хийсэн.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь анх 2002 оноос хойших 19 жилийн хугацаанд НҮБ-ын энхийг сахиулах болон эвслийн цэргийн ажиллагаанд давхардсан тоогоор нийт 19,000 гаруй цэргийн алба хаагч оролцож, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, даян дэлхийн энх тайван, бүс нутгийн аюулгүй байдлыг тогтворжуулахад хувь нэмрээ оруулсаар байна.

Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд зэвсэгт хүчний оролцоо:

Зэвсэгт хүчний барилга-инженерийн ангиуд улс орны стратегийн томоохон бүтээн байгуулалтын ажилд голлох үүрэгтэй оролцсон байна.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн авто замын барилгын ажил: Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн 17.5 км хүнд даацын авто зам барих ажлыг богино хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн.

Дорнод аймгийн Халх гол сумын Шинэ сум төслийн бүтээн байгуулалтын ажил: Эмнэлэг, сургууль, дотуур байр, цэцэрлэг, спорт заал, урлагийн заалны барилгын ажлыг чанартай гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажил: Төмөр замын дээд, доод бүтэц, гүүр, хоолойн ажил болон ертөө, зөрлөгийн барилгыг Зэвсэгт хүчний барилга инженерийн ангиуд барьж байгуулаад байна.


Зэвсэгт хүчний хэмжээнд хийгдсэн бүтээн байгуулалтын ажил: 2018-2020 онд Зэвсэгт хүчний барилга-инженерийн ангиуд Зэвсэгт хүчний 3 ангид 200 цэргийн байр, 4 ангийн соёл, спортын төв зэрэг бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2019-2020 онд ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн барилга, номын сангийн барилга угсралтын ажил хийгдэж байна. Оюутан-цэрэг сургалтын хүрээнд батлагдсан хөрөнгө оруулалтаар ҮБХИС-ийн сургалтын төвд 100 цэргийн байрлах байр 10-ыг, хооллох байр, жагсаалын талбай зэрэг бүтэн байгуулалтыг хийж сургалт явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлээд байна.

ХОЁР. ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ОРОЛЦОО

Хувийн хэвшил дунджаар ДНБ-ий 78 хувийг бүрдүүлж байна. Засгийн газраас бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр

олон арга хэмжээ авсны дүнд хувийн хэвшил ДНБ-ий дунджаар 78 хувьтай тэнцэх хувь нэмрийг оруулж байна.

График 38. Хувийн хэвшлийн ДНБ-д эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк

Хувийн хэвшлийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр сүүлийн 8 жилийн хугацаанд буурах хандлагатай байна. Хувийн хэвшлийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг сүүлийн 10 жилээр авч үзвэл, 2010-2013 оны хооронд өсөж 80 хувьд хүрсэн хэдий ч 2014 оноос буурч 2019 оны байдлаар 75 хувьд хүрээд байна. Үүнд

нэг талаас дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, хөгжиж буй орнууд руу чиглэсэн хөрөнгийн урсгал татарсан, макро эдийн засгийн хүндрэл, улс төрийн тогтворгүй байдлаас үүдэн гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, нөгөө талаас төрийн эдийн засаг дахь оролцоо нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байна.

График 39. Хувийн хэвшлийн ДНБ-д эзлэх хувь, бүсээр, 2019 он




Эх сурвалж: Монголбанк

Хувийн хэвшлийн тээвэр, уул уурхайн салбар дахь оролцоо 65 хувиас бага байна. Монгол Улсын эдийн засагт оролцоо өндөр уул уурхай, олборлолт,

тээвэр, агуулахын салбар дах хувийн хэвшлийн оролцоо сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй буурч, 2019 оны байдлаар харгалзан 56.5 хувь болон 46.2 хувьтай байна.

График 40. Салбар болгоны хувийн хэвшлийн оролцоо




Эх сурвалж: Монголбанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалт үргэлжлэн буурсаар байна. Монгол Улсад 2000-2011 оны хооронд хийгдсэн ГШХО-ын хэмжээ нь уул уурхайн салбарын огцом өсөлттэй уялдан ихээхэн нэмэгдсэн. Ялангуяа Засгийн газраас Оюу Толгойн төслийн хөрөнгө оруулалтын гэрээг зурж, ил уурхайн бүтээн байгуулалт эхэлсэнтэй холбогдуулан томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын урсгал

эрчтэй орж ирсэн ч уул уурхайн түүхий эдийн үнийн супер мөчлөг дуусгавар болсонтой холбоотойгоор 2015 оныг хшртэл гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан билээ. Харин 2016-2019 оны хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт тогтвортой өсч байсан ч Ковид-19 цар тахлын нөлөөлөөр 2020 онд хөрөнгө оруулалт буурсан үзүүлэлттэй байна.

График 41. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал, сая ам.доллар




Эх сурвалж: Монголбанк

ГШХО-ын дотогшлох урсгалын 73 хувийг уул уурхай, олборлох салбар дахь хөрөнгө оруулалт эзэлж байна. Монгол Улсад 2011-2019 онд жилд дунджаар 2,979.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт орж ирж байсны 73 хувь буюу 2,187.0 сая ам.доллар нь уул уурхайн салбарт, дараагийнх болох бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 10 хувь буюу 311.1 сая ам.доллар орж иржээ. Монгол Улсын

хөрөнгө оруулалтын орчны шинэчлэлийн зураглал судалгаагаар ГШХО-ын 81 хувь нь байгалийн баялаг эрэлхийлсэн, 16 хувь нь зах зээл эрэлхийлсэн, 3 хувь нь стратегийн хөрөнгө эрэлхийлсэн, ихэвчлэн аялал жуулчлалын салбарт хийгдсэн гэж ангилан харуулсан байна. Харин үр ашиг эрэлхийлсэн хөрөнгө оруулалтын хувь хэмжээ маш бага байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар сул байгааг харуулсан.

График 42. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал, салбараар, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

ГШХО-ыг хөрөнгө оруулалт хийсэн улс орноор нь авч үзвэл цөөн орнуудаас хэт төвлөрсөн байдалтай байна. Монгол Улсад орж ирсэн ГШХО-ын талаас илүү хувь нь зөвхөн БНХАУ болон Канад гэсэн 2 орноос хийгдсэн байна. Энэ бүс нутагт байрлах байгалийн баялаг ихтэй бусад улс орнуудын адил Монгол Улсад орж ирсэн ГШХО-ын дийлэнх хэсгийг БНХАУ төвлөрүүлсэн байна. Түүнчлэн орж ирсэн ГШХО-ын дийлэнх хэсэг нь цөөн хэдэн орноос хийгдсэн байгаа нь Монгол Улсыг эдгээр орнуудын эдийн засгийн мөчлөгөөс хэт хамааралтай болгож хөрөнгө оруулалтын урсгалын тогтворгүй байдлыг нэмэгдүүлж байна. Статистик

тоо мэдээллээс харахад Ази (Хонг Конг, Сингапур) болон Европын (Люксембург, Нидерланд) санхүүгийн төвүүд нь Монгол Улсад ГШХО хийхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь харагдаж байна.


Үндэсний хөгжлийн газраас дотоодын бизнесийн орчны тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх зорилгоор ГШХО-тай хуулийн этгээдийн түүвэр судалгааг 2021 оны 3 дугаар сард зохион байгууллаа. Энэхүү судалгаанд ГШХО-тай 311 аж ахуйн нэгж оролцсоноос 35.0 хувь нь 10-100 сая төгрөгийн, 29.0 хувь нь 100-1,000 сая төгрөгийн, 28.0 хувь нь 1-10 сая төгрөгийн, үлдсэн 8 хувь нь 1 тэрбум төгрөгөөс дээш татвар төлдөг

аж ахуйн нэгжүүд байна. Судалгаанд оролцогчдыг голлох салбараар нь авч үзвэл, 16.4 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 14.8 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрлэл, 6.4 хувь аялал жуулчлалын, 12.9 хувь нь барилга байгууламж, дэд бүтцийн салбарын аж ахуйн нэгжүүд байна.

Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудал чухлаар тавигдаж байна. Үндэсний хөгжлийн


газрын дээрх судалгаагаар гадаадын хөрөнгө оруулагчдын 28 хувь нь хөрөнгө оруулагчдыг хамгаалах, тэдгээрийн гомдлыг шийдвэрлэх тал дээр үзүүлэх дэмжлэгийг муу гэж дүгнэсэн бол 41 хувь нь дунд гэж дүгнэсэн. Гадаадын хөрөнгө оруулагчдын төлсөн татварын хэмжээ нэмэгдэх тусам маш муу гэж дүгнэсэн хувийн жин нэмэгдсэн нь авилгын эсрэг тэмцэл, эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

График 43. Хөрөнгө оруулагчдыг хамгаалах, тэдгээрийн гомдлыг шийдвэрлэх тал дээр үзүүлэх дэмжлэг, төлсөн татварын дүнгийн ангиллаар



Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

График 44. Хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны хүртээмжтэй, үр дүнтэй байдал, төлсөн татварын дүнгийн ангиллаар



Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

ГУРАВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021-2024 ОНЫ ХАНДЛАГА

3.1. Дэлхийн эдийн засгийн төлөв

Дэлхийн эдийн засгийн сэргэлт үргэлжилж, эдийн засгийн өсөлт 2021-2022 онд 6.0-4.4 хувьд хүрэх төсөөлөлтэй байна. Цар тахлын дараагийн давлагаа, мутацид орсон вирус зэрэг шинэ эрсдэл үүсч байгаа хэдий ч дэлхийн нийтийн вакцинжуулалт, голлох эдийн засгийн бодлогын

дэмжлэгтэй холбоотойгоор ОУВС-гийн 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн шинэчилсэн төсөөллөөр өмнөхөөсөө бага хэмжээгээр нэмэгдсэн байна. Улс орнууд цар тахлын дараах эдийн засгаа сэргээх зорилгоор ихээхэн хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөсөн нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс нэмэгдүүлэхэд гол хүчин зүйл боллоо.

Хүснэгт 24. Дэлхийн эдийн засгийн өсөлт, хувь

	2019	2020 ХБГ	2021*	2022*
Дэлхийн эдийн засаг	2.8	-3.3	6.0	4.4
Өндөр хөгжилтэй орнууд	1.6	-4.7	5.1	3.6
АНУ	2.2	-3.5	6.4	3.5
Евро бүс	1.3	-6.6	4.4	3.8
Япон	0.3	-4.8	3.3	2.5
Канад	1.9	-5.4	5.0	4.7
Бусад орон	1.8	-2.1	4.4	3.4
Бүрэлдэж буй болон хөгжиж буй орнууд	3.6	-2.2	6.7	5.0
Бүрэлдэж буй болон хөгжиж буй Азийн орнууд	5.3	-1.0	8.6	6.0
Бүрэлдэж буй болон хөгжиж буй Евро бүсийн орнууд	2.4	-2.0	4.4	3.9
Дундад болон Төв Азийн орнууд	1.4	-2.9	3.7	3.8
Бага орлоготой хөгжиж буй орнууд	5.3	0.0	4.3	5.2

Эх сурвалж: ОУВС

Олон улсын валютын сангийн төсөөллөөр Евро бүсийн эдийн засаг 2020 онд 6.6 хувиар агшсаны дараа 2021 онд 4.4 хувиар өсөхөөр байна. Уг төсөөллөөс хойш Европын улс орнууд дахин хатуу хөл хорио тогтоогоод байгаа ч эдийн засгийн төлөвт 12 дугаар сараас хойш төдийлөн өөрчлөлт орохооргүй байгааг Европын Төв банкнаас мэдээлжээ⁷. Тэрээр энэ оны 3 дугаар сар хүртэл цар тахлын нөхцөл байдал хэр байхаас эдийн засгийн төлөв хүчтэй хамаарахаар байгааг онцолсон бөгөөд

хэрэв вакцинжуулалт удааширсан хэвээр, улс орнууд 3 дугаар сараас хойш хөл хориог үргэлжлүүлэх тохиолдолд Евро бүс төдийгүй дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч болзошгүйг анхааруулжээ.

БНХАУ-ын эдийн засаг 2021 онд огцом сэргэж, 2022 онд 6.0 хувь орчимд тогтворжих хандлагатай байна. БНХАУ-ын эдийн засаг цар тахлын өмнөх өсөлтийн түвшинд эргэн орж, 2021 онд 8.3 хувийн өсөлттэй гарах хүлээлттэй байна.

⁷ Монголбанк, Глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлтийн тойм-2021.01-р сар
* Төсөөлөл


Засгийн газрын хөрөнгө оруулалтаар дэмжигдсэн нийлүүлэлтийн сэргэлтийг дагаж, эрэлт аажим сэргэж байна. Энэ оны хүчтэй сэргэлтийн дараагаар эдийн засгийн өсөлт тогтворжиж, 2022 онд 5.5 хувиар өснө гэсэн хүлээлттэй байна. Хятадын Ардын банкнаас бодлогын хүүгийн түвшинг сүүлийн 10 сарын турш бага түвшинд хадгалж, дотоод эрэлтийг дэмжих бодлогыг баримталж байна. Цаашид Засгийн газрын Хос эргэлт (Dual Circulation) эдийн засгийн бодлогын хэрэгжилт эрчимжин эдийн засгийн өсөлт өмнөх түвшинд хадгалагдана гэж үзэж байна.

АНУ-ын эдийн засаг 2021 онд хурдацтай сэргэж, 2022 онд тогтворжих хандлагатай байна. Ерөнхийлөгч Байден үндэсний дэд бүтцэд хөрөнгө оруулахад чиглэсэн хөтөлбөр болох Ажлын байрыг сайжруулах төлөвлөгөөг танилцуулав. Энэхүү төлөвлөгөө нь олон арван жилийн турш хөрөнгө оруулалт хийгдээгүй дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийснээр АНУ-ын эдийн засгийн бүтээмж, бизнесийн өрсөлдөх чадварыг сайжруулж, эрсдэл

даах чадварыг нэмэгдүүлнэ гэж тооцож байна. Түүнчлэн энэхүү бодлого нь аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг богино хугацаанд нэмэгдүүлэх боловч улс орны эдийн засгийн өсөлтөд урт хугацаанд чухал түлхэц болно гэж үзэж байна. Ийнхүү дэлхийн хоёрдугаар дайнаас хойш ажлын байранд оруулсан хамгийн том хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөхөөр байна.


Дэлхийн эдийн засгийн сэргэлт вакцин жуулалтаас хамаарах нь хэвээр байна. Улс орнуудын вакцины хүртээмжийг хурдасгах COVAX байгууламжийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, вакцины түгээмэл тархалтыг баталгаажуулах, эмчилгээний хэрэгслийг хүн бүрд хямд үнээр хүргэх ажлыг хэр хурдацтай далайцтай хийхээс эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв хамаарч байна. Түүнчлэн вирусийн шинэ давлагаа, шинэ хувилбарууд дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвт эрсдэл дагуулсан хэвээр байна.

График 45. Түүхий эдийн үнийн хандлага




Эх сурвалж: Datastream, Continuum Economic

График 46. Түүхий эдийн үнийн хандлага



Эх сурвалж: Datastream, Continuum Economic

График 47. Зэс, хөнгөн цагааны үнийн хандлага, ам.доллар/тонн



Эх сурвалж: Дэлхийн банк

Хүснэгт 25. Экспортын голлох бүтээгдэхүүний үнийн төсөөлөл, тонн/ам.доллар

	2020	2021	2022
Цэвэр зэс	6,174.0	8,700.0	8,550.0
Төмрийн хүдэр	108.0	130.0	95.0

Эх сурвалж: Блүүмберг терминал


Дэлхийн эдийн засгийн төлөв сайжирснаар дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн төсөөлөл сайжирлаа. Сүүлийн 6 сарын хугацаанд суурь металлын үнийн индекс 30 хувиар

өслөө. БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн салбарын сэргэлт, өндөр хөгжилтэй орнуудын төсвийн тэлэлт нь металлын үнэ өсөхөд нөлөөллөө. Барилга, үйлдвэрлэлийн салбарт түлхүү

ашиглагддаг, зэс, төмрийн хүдрийн болон цахилгаан машины батарей үйлдвэрлэлийн орц болох кобальт, никелийн үнэ илүү хурдацтай нэмэгджээ. ОУВС-гийн 2021 оны 4 дүгээр сарын

төсөөллөөр суурь металлын үнийн индекс 2022 онд 4.5 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа бол ДБ-ны төсөөллөөр зэсийн үнэ ирэх жилүүдэд тогтмол өсөхөөр төсөөлж байна.

График 48. Нефть, нүүрсний үнийн хандлага, ам.доллар/тонн



Эх сурвалж: Дэлхийн банк

Зэсийн үнийн өсөлтөд аж үйлдвэр, ахуйн цахилгаан барааны эрэлтийн өсөлт голлон нөлөөлж байна. Зэсийн хэрэглээний 54 хувийг эзэлж буй БНХАУ-ын аж үйлдвэрийн салбар хурдацтай сэргэсэн, АНУ-д орон сууцны үйлдвэрлэл нэмэгдсэн нь зэсийн үнэ өндөр байхад голлон нөлөөлж байна. Цар тахал эхэлснээс хойш АНУ-д байшин барих, байшингаа шинэчлэх болон электрон барааны эрэлт огцом нэмэгдсэнээр 2021 оны сүүлийн хагаст зэсийн зах зээл нийлүүлэлтийн хомсдол руу шилжихээр байна. Тус улсын Статистикийн алба, Орон сууц болон хотын хөгжлийн яамны мэдээллээр барилгын зөвшөөрөл өнгөрсөн оны 9 дүгээр сараас эхлэн нэмэгдэж, 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар нэмэгдсэн байна. Сити банкны төсөөллөөр энэ хандлага 2022 болон 2023 онд ч хадгалагдахаар байна. БНХАУ-ын хувьд аж үйлдвэрээс гадна гэр ахуйн цахилгаан барааны эрэлт огцом нэмэгдэж байна. Ройтерс агентлагийн мэдээллээр хөргөгчийн экспорт 2020 оны 12 дугаар сард 45 хувиар, богино

долгионы зуух 35 хувиар тус тус өссөн байна.

3.2. Макро эдийн засгийн өсөлт

Монгол Улсын Макро эдийн засгийн дунд хугацааны төсөөллийг рекурсив динамик ерөнхий тэнцвэрийн загварыг ашиглан тооцоолов. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулсан.


Макро эдийн засгийн төсөөллийг суурь, өөдрөг, гутранги гэсэн 3 хувилбараар тооцсон ба 2022 онд өөдрөг төсөөллөөр 7.1 хувь, гутранги төсөөллөөр 2.0 хувь, суурь төсөөллөөр 4.6 хувь байна. Монгол Улсын эдийн засаг уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнээс хэт хамааралтай тул хувилбарын шокийг худалдааны нөхцөлөөр авлаа. Төсөөллийн өөдрөг хувилбарт тус бүтээгдэхүүний үнэ ам.доллар утгаараа бүх хугацаанд суурь хувилбараас 5 хувиар өндөр, гутранги хувилбарт суурь

хувилбараас 5 хувиар бага байх, бусад нөхцөлүүд суурь хувилбартай ижил гэж үзэв.

Суурь төсөөллөөр эдийн засгийн өсөлт 2021 онд 7.6 хувь, 2022 онд 4.6 хувь байх тооцоололтой байна. Засгийн газраас цар тахлын тархалтыг хумих зорилгоор энэ оны 2, 3 дугаар саруудад тогтоосон хатуу хөл хорио нь эхний хагас жилийн эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй ч вакцинжуулалтын хурд нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт 2 дугаар хагаст

огцом сэргэх төлөвтэй байна. Харин 2022 онд дотоод эрэлт сэргэн уул уурхайн бус салбар идэвхжих хэдий ч Оюутолгойн зэсийн баяжмал, түүний алтны агууламж буурах нөлөөгөөр уул уурхайн үйлдвэрлэл буурах нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлэхээр байна. Монголбанкнаас 2021, 2022 оны эдийн засгийн өсөлтийг харгалзан 6.1 хувь, 5.3 хувь гэж тус тус төсөөлж байгаа бол АХБ 5.1 хувь, ДБ харгалзан 4.3 хувь, 5.4 хувь гэж таамаглаж байна.

График 49. ДНБ-ий төсөөлөл, их наяд төгрөг



Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

Монголбанкны тооцооллоор инфляц 2021, 2022 оны эцэст харгалзан 7.2 болон 5.8 хувь байх тооцоололтой байна. Инфляцын түвшин 2021 онд бага зэрэг өсөхөөр байгаа нь энэ онд шатахууны үнэ нэмэгдэх төсөөлөлтэй холбоотой. Ирэх оны хувьд дотоод эрэлт тогтворжиж, инфляц зорилтот түвшний орчимд тогтворжих хандлагатай байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд тогтворжиж 2023, 2024 онд 6.3

хувь болон 6.4 хувь байх төсөөлөлтэй байна. Эдийн засгийн өсөлт 2021 оны сүүлийн хагасаас сэргэж, 2022 онд тогтворжиж эхэлснээр 2022-2024 онд дунджаар 6.0 хувиар өсөхөөр байна. Засгийн газраас төсвийн тогтвортой байдлыг хангаж, инфляцын түвшинг 6.0 хувь голчтой хадгалан макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаснаар гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх төсөөлөлтэй байна.

Хүснэгт 26. Макро эдийн засгийн голлох үзүүлэлтийн төсөөлөл

Үзүүлэлт	2018	2019	2020	2021 ХБГ	2022 Төс
Эдийн засгийн өсөлт (хувь)	7.2	5.1	-5.3	7.6	4.6
Төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	0.1	-2	-12.3	-5.1	-3.6
ГШХО (сая ам.доллар)	2,136.70	2,316.40	1,648.80	1,492.80	2,837.70

Эх сурвалж: Сангийн яам

3.3. Улсын төсөв, хөрөнгө оруулалт

Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөөллийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн төсөлд үндэслэн боловсруулав. Сангийн яамнаас дунд

хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дунд хугацааг илүү өөдрөгөөр буюу 2022 оны төсвийн орлогыг 14.78 их наяд төгрөгөөр төсөөлж байна.

Монгол Улсын төсвийн нийт орлого 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 13.1 их наяд төгрөг байх төсөөлөлтэй байна.

Хүснэгт 27. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, 2021-2022 он, тэрбум төгрөг

	2018	2019	2020	2021	2022
	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Урьдчилсан гүйцэтгэл	Төсөөлөл	Төсвийн хүрээний мэдэгдэл
Төсвийн нийт орлого	12,172.80	12,040.30	10,402.00	13,134.00	14,781.10
Тогтворжуулалтын сан	207.00	94.60	66.20	156.00	552.90
Ирээдүйн өв сан	620.70	1,040.20	914.10	1,180.10	1,021.70
Тэнцвэржүүлсэн нийт орлого	9,345.10	10,905.50	9,421.60	11,797.80	13,206.40
Татварын орлого	8,227.80	9,813.20	8,501.80	10,754.40	11,849.10
Татварын бус орлого	1,117.30	1,092.30	919.90	1,043.40	1,357.40
Төсвийн нийт зарлага	9,137.20	11,661.70	13,960.80	13,951.60	14,852.00
Урсгал зарлага	7,350.30	8,228.60	10,871.60	10,968.80	11,327.10
Хөрөнгийн зардал	1,680.40	3,016.70	3,051.70	3,541.70	3,768.90
Эргэж төлөгдөх цэвэр зээл	286.50	416.40	37.60	-558.90	-244.00
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	27.90	-756.20	-4,539.10	-2,153.70	-1,645.60

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн орлогыг 2022 онд 12.5 хувиар буюу 1.65 их наядаар нэмэгдэхээр төсөөлөв. Уул уурхайн салбарын нөлөөгөөр эдийн засаг хурдацтай сэргэх хэдий ч хувийн хэвшлийн үйл ажиллагаа, өрхийн хэрэглээ сэргэж эхэлнэ хэмээн үзэж татварын орлогын өсөлтийг ийнхүү тооцов.

Төсвийн нийт зарлагын хувьд 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 6.5 хувиар нэмэгдэхээр төсөөлөв. Засгийн газраас

төсвийн тогтвортой байдлыг хангах, гадаад өр төлбөрийг бууруулах зорилтын хүрээнд төсвийн зардлын өсөлтийг сааруулж, тэнцлийг дунд хугацаанд сайжруулах зорилтыг тавьж байна. Энэ хүрээнд 2022 оны урсгал зардлыг 11.3 их наяд төгрөгт, эргэн төлөгдөх цэвэр зээл 244 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов.

Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь 2021 он 2022 онд тус тус буурснаар тэнцэл сайжрахаар байна. Төсвийн

орлого зарлагаас илүү хурдацтай өсөхийн зэрэгцээ эдийн засгийн өсөлт нэмэгдсэнээр төсвийн төлөв дунд хугацаанд сайжрах хандлагатай байна.

3.4. Бодит салбарын хөгжил

Оны сүүлийн хагаст эдийн засаг идэвхиж, зочид буудал, барилга,

уул уурхайн салбарт хамгийн өндөр өсөлттэй гарах төсөөлөлтэй байна. Ирэх онд барилгын салбар 16.3 хувь, хөдөө аж ахуй 5.5 хувь, цахилгаан, хий уур, агааржуулалтын хангамж, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа болон мэдээлэл, холбооны салбарууд 5 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

Хүснэгт 28. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, салбараар, хувь

	2020	2021	2022
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур,	6.2	(2.5)	5.5
Уул уурхай, олборлох үйлдвэр	(9.4)	16.9	(6.7)
Боловсруулах үйлдвэр	1.3	4.1	11.2
Цахилгаан, хий уур, агааржуулалтын хангамж	2.4	5.0	5.0
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	(2.3)	5.0	5.0
Барилга	(7.4)	6.1	16.3
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	(11.1)	7.8	7.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	(20.1)	12.2	10.2
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	(29.7)	2.0	2.0
Мэдээлэл, холбоо	0.4	5.0	5.0
бусад	(4.0)	8.0	8.0
Дотоодын нийт бүтээгдэхүүн	(5.3)	7.6	4.6

Эх сурвалж: Сангийн яам

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө нь хөгжлийг урт, дунд хугацаанд хязгаарлаж буй хүчин зүйлсийг шийдвэрлэх, хөрөнгө, санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээнд төвлөрүүлж, үр ашигтай зарцуулахад чиглэгдэж байгаа бөгөөд энэ хүрээнд 6 бүлэг, 23 зорилго, 263 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 10 их наяд 22 тэрбум 668 сая 100 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр тусгалаа. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 870 тэрбум 427 сая 400 мянган төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 111 тэрбум 688 сая төгрөг, гадаадын зээл, тусламжаар 2 их наяд 151 тэрбум 611 сая 700 мянган төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 1 их наяд 194 тэрбум 290 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 5 их наяд 694 тэрбум 651 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

Бүлэг 1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого

Зорилго 1.1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Энэ зорилгын хүрээнд эрүүл мэнд, боловсрол, бизнесийн салбарын 8 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд тэдгээр нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц

төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд Ковид-19 цартахалтай холбоотой судалгааны ажлыг хийж, халдварын геномын дарааллыг тогтоох, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, орон нутагт шинжилгээний цэгүүдийг байгуулах зэрэг асуудал тусгагдсан.

Ковид-19 цар тахлын үед Засгийн газраас богино хугацаанд яаралтай горимоор хэрэгжүүлсэн багц арга хэмжээ нь бизнесийн дампуурал, ядуурлын гүнзгийрлээс сэргийлж чадсан боловч цаашид цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулахад чиглэсэн эрүүл мэнд, боловсрол, бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, тогтворжуулах шаардлага үүсэж байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Ковид-19 цар тахалтай холбоотой хийгдэх судалгааны ажлыг хийж, Монгол Улсад зөөвөрлөгдөж ирсэн коронавируст халдварын геномын дараалал, бүтэц тодорхойлно.
- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барина.
- Дэлхий дахинаа бүртгэгдэж байгаа нийт халдварт өвчний 70 гаруй хувь нь зоонозын өвчний гаралтай халдвараас үүдэлтэй бөгөөд улс орны хил хязгаарыг үл харгалзан халдварт өвчин тархах эрсдэл улам бүр нэмэгдсээр байгаатай уялдан зоонозын өвчин судлалын төвүүдийг орон нутагт шинээр барьж, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд БХ-ПГУ (бодит хугацааны полимеразын гинжин урвал) шинжилгээний төхөөрөмжийг суурилуулснаар халдварт өвчний эрсдэлийг бууруулах, оношлох үйл явцыг түргэсгэх боломжтой болно.

Бүлэг 2. Хүний хөгжлийн бодлого

Энэхүү бүлгийн хүрээнд хүн төвтэй нийгмийн хөгжлийг цогц байдлаар авч үзсэн бөгөөд иргэдийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, боловсрол, нийгмийн хамгаалал, түүнчлэн эрдэм шинжилгээ, судалгаа, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг багтаасан 6 зорилго, 75 арга хэмжээг тусгасан.

Зорилго 2.1. *Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.*

Сүүлийн жилүүдэд шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчний тохиолдлын тоо нэмэгдсээр байна. Монгол Улс сүрьеэгийн өвчлөлөөр ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн орнуудаас 4 дүгээрт бичигдэж байгаа бөгөөд 2015 онд хийгдсэн сүрьеэгийн тархалтын судалгаагаар 10,000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөл 438 байсан.

Хорт хавдрын нас баралт хүн амын нас баралтын 2 дахь шалтгаан болж, өвчлөлийн тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаанаас харвал хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг шинжилгээг идэвхтэй зохион байгуулснаар өвчний эрт илрүүлгийн хувь өсөхийн зэрэгцээ хорт хавдрын улмаас эмчилгээний хяналтад байж 5-аас дээш жил амьдарч байгаа хүний эзлэх хувь нэмэгдсэн байна.

ДЭМБ-аас тооцоолсноор 2030 онд дэлхийн хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан нь зүрхний судасны өвчин, тархины судасны өвчин байхаар тооцоолол гаргасан. Судалгаагаар манай оронд зүрх судасны өвчний шалтгаант мэс ажилбарын тоо өнөөгийн түвшнээс даруй 72.4 хувиар өсөх хандлагатай байгааг

мэргэжлийн байгууллагын гаргасан судалгаа харуулж байна. Яаралтай тусламжийн дуудлага жил бүр нэмэгдэж, дунджаар 700 гаруй мянган дуудлага бүртгэгдэж байна. Улсын хэмжээнд түргэн тусламжийн дуудлага хүлээн авах 23 нэгж ажиллаж байгаа хэдий ч яаралтай тусламжийг газар дээр нь шуурхай үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хөдөө орон нутагт 336 сум, тосгоны эрүүл мэндийн төв тусламж үйлчилгээ үзүүлж байгаагийн 238 нь дулаан хангамж, ариун цэврийн системд холбогдоогүй байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Сүрьеэгийн эмнэлэг барих ажлыг эхлүүлснээр халдварыг бууруулах, өвчтөн эмнэлэгт хэвтэн, бүрэн эмчлэх бололцоогоор хангагдах болно.
- Орчин үеийн стандартад нийцсэн цогц тусламж үйлчилгээг үзүүлэх Эрхтэн шилжүүлэн суулгах төвийг байгуулснаар иргэдийг иргэд эх орондоо эрүүл мэндийн үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлж, гадаад улс руу урсах эрүүл мэндийн зардлыг 3-4 дахин бууруулна.
- Зүрх судасны мэргэшсэн төв байгуулагдсанаар иргэд тусламж үйлчилгээг нэг дороос цогцоор нь авах боломж бүрдэнэ.
- Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ. Ингэснээр эрүүл мэндийн байгууллагуудад дүрс архивлан хадгалах систем бүрэн ашиглагдаж эхэлнэ.
- Харшлаас сэргийлэх болон “Хавдрын эсрэг” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зорилго 2.2. *Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.*

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлж, нийслэлийн усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлж, Баянзүрх, Налайх дүүргийн спортын цогцолборыг ашиглалтад оруулснаар нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгоход дэмжлэг үзүүлнэ.

Зорилго 2.3. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.

2021-2022 оны хичээлийн жилд 625,226 хүүхдийн хүчин чадал бүхий 863 сургуулийн байгууллагад 688,739 суралцагч, 243,080 хүүхдийн хүчин чадал бүхий 1,538 цэцэрлэгийн байгууллагад 249,226 суралцагч суралцаж байна.

Ковид-19 цар тахлын боловсролын салбарт үзүүлж буй нөлөөлөл, хариу арга хэмжээ Цар тахлын улмаас ерөнхий боловсролын 103,771 хүүхэд теле хичээл үзэж чадаагүй буюу сурлагын хоцрогдолд орсон байна. Эдгээр хүүхдийн 48,343 буюу 46.6 хувь нь бага ангийн, 39,701 буюу 39.3 хувь нь дунд ангийн, 15,727 буюу 15.2 хувь нь ахлах ангийн сурагчид байна. Энэ хичээлийн жилд шинээр элссэн боловч теле хичээл үзэж чадаагүй 1 дүгээр ангийн 9,818, 2 дугаар ангийн 11,183, төгсөх анги буюу 12 дугаар ангийн 4,408 суралцагч байгаа бол бага ангид 1,289, дунд ангид 1,000, ахлах ангид 196 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт үе шаттай хамруулж, тэдэнд боловсрол, эрүүл мэнд,

хамгааллын цогц үйлчилгээ үзүүлж, 10 бүлэг нээж, 250 хүүхдийг хамруулна.

- Багш мэргэжлийн стандартыг батлуулж, Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлж, сурагчдын амжилтыг үнэлэх олон улсын (PISA) үнэлгээнд хамрагдана. Ингэснээр манай улсын сурлагын амжилтыг олон улсынхтай харьцуулах боломж бүрдэнэ.

- Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах ажлыг зохион байгуулж, 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байрыг төвлөрсөн болон бие даасан ариун цэврийн байгууламжтай болгоно.

- Тусгай цэцэрлэг, сургуулийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, тавилга хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүрэгт сувиллын цэцэрлэг, сургуулийн цогцолборын барилга, тусгай 25, 63 дугаар сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг үргэлжлүүлнэ.

- Боловсролын салбарт мэдээллийн системийн инновацыг нэвтрүүлж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж, сургууль, цэцэрлэгийн сүлжээний дэд бүтэц, тоног төхөөрөмжийг сайжруулна.

- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах хүүхдүүдийн хувийг 78.8-аас 87.9 хувьд хүргэж нэмэгдүүлнэ.

Зорилго 2.4. Шинжлэх ухаан, технологи, инновац. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.

Энэхүү зорилгын хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр өгөөжийг үйлдвэрлэлд нэвтрүүлж,

бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ тусгагдсан. Үүнд:

- Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгож, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах;
- Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, инновацын тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх;
- Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах ажлыг үргэлжлүүлэх.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Судалгааны үр дүнд бий болсон шинэ мэдлэг, патентын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, Инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, инновацын үйл ажиллагаа эрхлэгчид, гарааны компаниудын өрсөлдөх чадварыг бэхжүүлнэ.

Зорилго 2.5. *Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.*

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулахад чиглэсэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж, мөрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ялангуяа өрхийн үйлдвэрлэл эрхлэх, аж ахуйгаа хөтөлж, ажлын байраа өргөжүүлэхэд

нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх төрийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх, түүнчлэн борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр «халамжаас-хөдөлмөр» эрхлэх иргэдийн тоо нэмэгдэж, өрх бүрийн гишүүд ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдэх болно.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах хүрээнд нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөр төслийн үйл ажиллагааг нэгтгэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийг 6 аймагт байгуулна.
- Орлого багатай өрхийн гишүүдэд мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлнэ.

Зорилго 2.6. *Үндэсний бахархал, өв соёл. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.*

Соёлын салбарт томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлж, соёлын барилга, байгууламж баригдана.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Үндэсний номын санг бүрэн ашиглалтад оруулна.

- Цахим мэдээллийн санг бүрдүүлж, үүлэн технологийн орчинд бүрэн шилжүүлнэ.
- “Чингис хаан” хаад, язгууртны музейн шилэн хорго, витрин, тоног төхөөрөмжийг суурилуулан тохижуулна.
- Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 50 хувийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр хамгаалуулна.
- Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл ажиллагааг шинэчилж иргэдийн гар дээрх 1000 баримтат өвийг бүртгэн баримтжуулна.

Бүлэг 3. Эдийн засгийн бодлого

Энэхүү бүлгийн хүрээнд макро эдийн засгийн болон эдийн засгийн бодит салбаруудыг хөгжүүлэх 7 зорилго, 91 арга хэмжээг тусгасан.

Зорилго 3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.

2019 оны сүүлийн хагаст эхэлсэн Ковид-19 цар тахалтай холбоотой нийгмийн эрүүл мэндийг хамгаалахаар хэрэгжүүлсэн гадаад болон дотоод хөл хорионы арга хэмжээ нь бизнесийн үйл ажиллагааг хумьж, эдийн засагт уналтыг бий болгосон бөгөөд Засгийн газраас эдийн засгийн хариу арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлсний үр дүнд 2020 онд 5.3 хувийн бууралттай байсан эдийн засаг 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6.2 хувьд хүрэх төлөвтэй байна.

2022 онд цар тахлын тархалт намжиж, гадаад эрэлт сэргэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, уул уурхайн салбар идэвхжих зэрэг нь эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөхийн зэрэгцээ гадаад эрэлтийн таатай байдал үргэлжилж, уул уурхайн үйлдвэрлэл

өсөлтийг тэтгэх нөхцөл бүрдэх төлөвтэй байна.

Цаашид эдийн засгийг тогтворжуулах, ажлын байрыг хадгалах, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үнийн тогтвортой байдлыг хангах, улмаар технологийн болон оюуны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь нэн чухлаар тавигдаж байна. Үүнтэй уялдуулан төсвийн сахилга батыг чанд сахиж, нэгж төгрөгт ногдох үр өгөөжийг хамгийн өндөр байх төсөл арга хэмжээ, бүтээн байгуулалтыг дэмжиж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Макро түвшинд эдийн засгийн бодит өсөлтийг 4.6 хувьд хүргэнэ.
- Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлж, зээлийн хүүг бууруулж, банкны салбарын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж зээлийн хүүг жилийн 13.8 хувьд хүргэнэ.

Зорилго 3.2. Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.

Уул уурхайн салбар нь манай улсын ДНБ-ий 25.0 орчим хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70 гаруй хувь, экспортын 90.0 хувийг дангаараа бүрдүүлдэг, эдийн засгийн голлох салбарын нэг юм. 2020 онд 28.6 сая тонн чулуун нүүрс, 1.4 сая тонн зэсийн баяжмал, 8.2 сая тонн төмрийн хүдэр, баяжмал, 678.9 мянган тонн хайлуур жоншны хүдэр, баяжмал,

134.0 мянган тонн цайрын баяжмал, 6.3 мянган тонн молибдений баяжмал тус тус экспортолсон дүнтэй байна.

Цаашид уул уурхайн салбарыг дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар дэмжиж, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэх нь уул уурхайн бус салбаруудыг хөгжүүлэх, нийгмийн хамгаалалд зарцуулах зардлын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цаашлаад улсын төсвийн бүрдэлт, төлбөрийн тэнцлийн тэнцвэртэй байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Түүнчлэн тус салбарт геологи хайгуулын ажлыг үргэлжлүүлэх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, өргөтгөх, сайжруулах, уурхайг шинээр байгуулж, ашиглалтад оруулах замаар Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлж буй уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг ахиулах зорилтыг хэрэгжүүлэх, бусад дагалдах үйлдвэрүүд бий болох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Геологийн зураглалын 2 ажил үргэлжлэн хийгдэж, Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох судалгааны ажлыг дуусгана. Ингэснээр геологийн салбараас гадна хөдөө аж ахуй, эрүүл мэнд, байгаль орчин, зам, барилгын салбарт мэдээллийн чухал бааз суурийг бий болгоно.
- Газрын тос дамжуулах хоолой барих ажлыг 40.0 хувьд хүргэнэ. Ингэснээр газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн тогтвортой байдал хангагдаж, үйлдвэрлэлийг саадгүй явуулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр бий болох, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.
- Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулагдсанаар Евро-5 стандартын шаардлагад нийцсэн 1.3 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж,

бүтээгдэхүүн худалдан авах 1.0 тэрбум ам.долларын гадагшлах урсгал зогсож, шатахууны үнэ тогтворжиж, шинээр 550 орчим ажлын байр бий болох нөхцөл бүрдэнэ.

- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл технологийн паркийн авто зам, дулаан, ус хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээ баригдана.
- “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологийн катодын зэсийн үйлдвэр баригдана.
- “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг 25 хувьд хүргэнэ.

Зорилго 3.3. *Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.*

Хөдөө аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурийг эзэлж, хүн амыг хүнсээр хангадаг үндсэн салбар бөгөөд мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ технологийг нэвтрүүлж, нэгж малаас авах малын ашиг шим, нэг га газраас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эдийг үйлдвэрийн аргаар боловсруулж, импортын бараа бүтээгдэхүүнийг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд ахиц, дэвшил гаргах нь салбарын нэн тэргүүний зорилт болж байна.

Манай улсын нийт тариалангийн талбайн 10 гаруйхан хувьд нь инженерийн болон энгийн хийцийн усалгаатай тариалалт эрхэлж байгаа нь нэгж талбайгаас хураах ургацын хэмжээг дэлхийн дундаж үзүүлэлтээс 2-3 дахин доогуур

байх нөхцөл болж байна. Цаг агаарын онцлогоос хамаарч өвлийн улиралд жил бүр 15.5 мянган тонн хүлэмжийн нарийн ногоо, 5.0-8.0 мянган тонн улаан буудайн элит үрийг импортоор авч байна.

Үүнтэй уялдан ганд тэсвэртэй, ургац өндөртэй үр тариа, тос, тэжээл, буурцагт таримлын нутагшсан сортын үрийг үржүүлж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх шаардлагатай байна.

Мал аж ахуйн түүхий эдийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь боловсруулах аж үйлдвэрийн хувийн жинг нэмэгдүүлж, эдийн засгийн бүтцэд эерэг өөрчлөлтийг бий болгоход ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Энгийн болон инженерийн хийц бүхий услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 500 га-гаар нэмэгдүүлнэ.
- Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлж, үрийн чанар, хангамжийг сайжруулж, улаан буудайн супер элит үрийг 150 тонноор, элит үрийг 1,000 тонноор, төмсний бичил булцууны үрийг 210.0 мянган ширхгээр, хүнсний ногооны 6 нэр төрлийн үрийн үйлдвэрлэлийг 11,000 кг-аар тус тус нэмэгдүүлнэ.
- Жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлнэ. Шинээр 2,000 ажлын байр бий болно.

Зорилго 3.4. *Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.*

Аялал жуулчлалын салбар нь ДНБ-ий 4 орчим хувийг бий болгодог бөгөөд байгалийн үзэсгэлэнт газруудад суурилсан жуулчлалын төрлүүдийг

нэмэгдүүлж, дэлхийн улс орнуудын жуулчлалын урсгалыг татаж, орлого нэмэгдүүлэх өргөн боломжтой салбар юм.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Хөвсгөл, Хэнтий аймагт хэрэгжүүлж эхэлсэн Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг үргэлжлүүлж, аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг бий болгон, түүх соёлын дурсгалын сэргээн засварлах ажлыг гүйцэтгэнэ.
- Мянганы суут хүн-Их Эзэн Чингис хаан түүхэн аялал жуулчлалын үндэсний парк байгуулах зорилгын хүрээнд Шихихутаг-Их засаг цогцолбор, Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг дэвсгэрт Монгол төрийн Их Хуралдай цогцолборыг ашиглалтад оруулна.
- Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 100 км тутамд амрах талбай байгуулах төслийг эхлүүлснээр 10 байршилд амрах талбай байгуулагдсан байна.

Зорилго 3.5. *Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана.*

Эрчим хүчний салбар нь улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн салшгүй хэсэг бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахад эрчим хүчний эх үүсвэрийг шинээр бий болгох, одоо байгаа системийг шинэчлэх, сайжруулах, өргөтгөх, шинэ технологийг нэвтрүүлж үр ашгийг нь нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Манай улсын эрчим хүчний систем нь Төвийн бүсийн эрчим хүчний систем, Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний систем, Дорнод бүсийн эрчим хүчний систем, Өмнөд бүсийн цахилгаан хангамж гэсэн таван хэсгээс бүрддэг. Цахилгааны эрчим хүчний хэрэглээний 80.7 хувийг дотоодын

эх үүсвэрээс, 19.3 хувийг импортын цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Монгол Улсын хэмжээнд эрчим хүч хэрэглэгчийн хэрэглээ байнга нэмэгдэж, жилд дунджаар 7.0-8.0 хувийн өсөлттэй байгаа бол жилийн 4.0-5.0 хувийн өсөлттэй байгаа дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлээр 2022 оны өвлийн улирлын эрчим хүчний хэрэгцээг хангаж чадахгүйд хүрч, эрсдэл тулгарахаар байна. Түүнчлэн ирэх онд төлөвлөгдсөн бүтээн байгуулалтууд нь эрчим хүчний илүү их хэрэгцээг шаардах бөгөөд үүнтэй уялдан эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өндөр хүчин чадал бүхий эх үүсвэрийг ашиглалтад оруулах, одоогийн байгаа станцуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх асуудлыг цаг алдалгүй эхлүүлэх нь энэ салбарын хойшлуулшгүй зорилт болж байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. Төслийн хүчин чадал 90МВт, жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, баруун 5 аймгийн 253.3 сая кВт.ц хэрэглээг хангана. 52,000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун 5 аймгийн 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,413 гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана. ОХУ, БНХАУ-аас авч буй импортын эрчим хүчний төлбөр болох 17.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ. Бүтээн байгуулалтын үед 800, ашиглалтад орсон үед 66 байнгын ажлын байр бий болно.
- Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ. Энэ нь жилд 3,150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдол бүхий өмнөд

бүсийн уул уурхайн төслүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангана. Оюутолгой ХХК-ийн импортын эрчим хүчинд одоогийн байдлаар төлж буй 110-120 сая ам.доллар дотооддоо үлдэнэ.

- Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөснөөр бүс нутгийн уул уурхайн төслүүдийн хүлээгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг бүрэн хангана. Жилд 350.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, Дорнод, Сүхбаатар аймгуудын 27 сумын 25,139 айл өрх, 3,133 аж ахуйн нэгж, албан байгууллагын цахилгаан хангамжийн чанар, хүртээмж сайжирна. Станцын үйлдвэрлэх нэгж цахилгаан эрчим хүчний өртөг 148.0 төгрөгөөс 111.59 төгрөг болж 36.41 төгрөгөөр буурна. 90 ажлын байр шинээр бий болно. Чойбалсан хотын агаарын бохирдол буурна.

- Дулааны хоёрдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станцын ажлыг эхлүүлнэ. Импортын цахилгаан эрчим хүчний төлбөрт төлөх валютын урсгал дотооддоо үлдэнэ. Улаанбаатар хотын цахилгаан, дулааны өсөн нэмэгдэж буй хэрэглээг найдвартай, тогтвортой хангана.

- 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барина.

- Налайх дүүрэгт дулааны станцын өргөтгөл шинэчлэлт хийж, эрчим хүчний шинэ эх үүсвэр, дэд станц шинээр бий болгоно.

- Чойр-Сайншанд 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.

- Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл (салхины цахилгаан станцын 2 төсөл 15 МВт, нарны цахилгаан станцын 4 төсөл 35 МВт)-ийг хэрэгжүүлнэ.

- Багануур 400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэнэ.

Зорилго 3.6. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

Тээвэр/логистик/-ийн салбар нь авто, агаар, төмөр зам, далайн тээврээр бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэдэг, дэд бүтцийн үндсэн салбарын нэг юм.

Монгол Улс нийт 112.4 мян.км авто замын сүлжээтэй, 1 мянга нь олон улсын чанартай авто замын сүлжээнд хамаардаг. Нийт 16 агаарын хаалгатай, ОХУ-тай 10 агаарын хаалгаар, БНХАУ-тай 6 агаарын хаалгаар хиллэдэг. Нийт 1,922.1 км төмөр замын сүлжээтэй, ачааны 5,945, зорчигчийн 329 вагонтой.

Зам, тээврийн үйлчилгээг сайжруулж, олон улсын стандартад нийцсэн чанар сайтай зам, гүүр барих, одоо ашиглагдаж байгаа авто болон төмөр замын засвар, шинэчлэлийг хийх нь уул уурхайн салбарт экспортын гол нэрийн бүтээгдэхүүний тээвэрлэх эргэлтийг нэмэгдүүлэх төдийгүй иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээг эцсийн хэрэглэгчдэд шуурхай хүргэх, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Өнөөдрийн байдлаар улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээний 22.6 хувьд нь ээлжит засвар, 13.4 хувьд нь их засвар, шинэчлэлийн ажил хийх шаардлагатай. Авто замын засвар, арчлалтын ажлыг санхүүжилтийн дутагдалтай байдлаас шалтгаалж нормативт хугацаанд нь хангалттай хийж гүйцэтгэхгүй байгаагаас авто зам, гүүрийн ашиглалтын байдал муудаж, эвдрэл даамжирч, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх болсон.

Үүнтэй уялдан ногоон хөгжил, аялал жуулчлалыг дэмжсэн, хилийн боомтын

хүчин чадлыг нэмэгдүүлж, уул уурхайн тээвэрлэлтийг эрчимжүүлэх, олон улс, бүс нутгийн сүлжээнд холбогдсон тээвэр логистикийн сүлжээг бий болгох нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам, Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто зам барина. Нийтдээ 8 байршилд 1232.8 км авто зам барина. Авто замуудыг барьж, байгуулснаар Монгол Улсын ашигт малтмалын нөөц бүхий ордуудыг ашиглах, тэдгээрийн бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулах боломжтой болно.
- Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барьж, Улаанбаатар төмөр замын гол замд техникийн шинэчлэл төслийг эхлүүлнэ.
- Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг шатахуун түгээх станц, үйлчилгээний газруудыг түшиглэн төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.
- Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 100 км тутамд амрах талбай байгуулагдана.

Зорилго 3.7. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын салбарт импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, нутаг дэвсгэрийг зурагжуулах, шугам, сүлжээг хяналт, удирдлагын нэгдсэн системд холбох зэрэг зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.
- Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.
- Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээний хэрэгжилт 30.0 хувьд хүрсэн байна.

Бүлэг 4. Засаглалын бодлого

Зорилго 4.1. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

Зорилго 4.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.

Зорилго 4.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.

Зорилго 4.4. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.

Зорилго 4.5. Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого. Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж,

хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.

Зорилго 4.6. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.

Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, цахим үйлчилгээг хөгжүүлж, нэгдсэн мэдээллийн санг үүсгэснээр иргэдэд хүртээмжтэй, олон төрлийн үйлчилгээг шуурхай үзүүлэх, олон нийтэд нээлттэй болгох чиглэлийг баримталснаар иргэн төвтэй засаглалын бодлого бэхэжнэ.

- Төрийн цахим үйлчилгээний e-Mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэн, иргэдэд танин мэдүүлж, цахим үйлчилгээний нэгдсэн платформоор дамжуулан үйлчилгээ авч буй иргэдийн тоог 200,000-аар нэмэгдүүлнэ.

- Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлж, үйлчилгээний 20 хувийг цахимжуулна.

- Стандарт, хэмжил зүйн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгох, e-standard, e-certification, e-metrology үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим сургалтын орчин бүрдүүлсэн байна.

- Зохицуулалтын бүх байгууллагуудыг цахим гарын үсэгт шилжүүлнэ.

- Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформыг хөгжүүлж, бий болгосон байна.

- Шилэн кабельд холбогдоогүй 7 сум, 23 багт шилэн кабелийн сүлжээ татаж, өндөр хурдны интернэтийн үйлчилгээ авах дэд бүтцийг бий болгосон байна.

Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалж, төвлөрлийг сааруулж,

төрийн албан хаагчийг мэргэшүүлж, чадавхжуулснаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг харгалзан үнэлж, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

- Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулна.

- Бүтээн байгуулалт, мега төсөл болон экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүний стандартыг бий болгоно.

Иргэний аюулгүй, амар амгалан байдлыг хангах нь иргэн төвтэй засаглалын бодлогын үндсэн суурь байх болно.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжийг шинэчилж, хилийн салбаруудыг төвлөрсөн эрчим хүчинд холбоно.

- Монгол Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэний хурууны хээ, био мэдээллийн сангаас мэдээлэл унших, оршин суух үнэмлэх олгох системийг хөгжүүлж, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай холбоно.

- Хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулна.

- Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангана.

Бүлэг 5. Ногоон хөгжлийн бодлого

Зорилго 5.1. *Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.*

Засгийн газрын өмнө цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүнд нөхцөл байдлыг тогтворжуулж сэргээх, даван туулах, ард иргэдийн ажлын байр, орлогыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, хувийн хэвшлийн бизнесийг дэмжих, томоохон төслүүдээ хөдөлгөж, эдийн засгийн эргэлтэд оруулахын зэрэгцээ өвөг дээдсээс уламжилж үлдээсэн эх байгалиа хайрлан хамгаалж экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байлгах, байгалийн нөөц баялгийг үр өгөөжтэй, хаягдалгүй, хэмнэлттэй ашиглаж хэвших шаардлага тулгарч байна.

Иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэн, хүлэмжийн хийн ялгаруулалт, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдлыг бууруулж, усны хомсдолыг багасган, баталгаат ундны усаар хүн амыг жигд ханган, хүрээлэн байгаа орчны доройтол, бохирдлыг багасгаж, ойн санг хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор түүхий нүүрсний хэрэглээг халж, бохирдлыг эх үүсвэрийг багасгаж, Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламжийг 50 мкг/м³, PM10 тоосонцрын агууламжийг 107 мкг/м³-д хүргэж, бууруулна.
- Цөлжилт, газрын доройтлыг бууруулах хүрээнд орон нутагт 200-аас доошгүй га талбайд цөлжилтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 8.0 мянгаас доошгүй га талбайд ойжуулалт нөхөн сэргээлт хийж, 200 мянган га-гаас багагүй талбайд ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил гүйцэтгэнэ.
- Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн 2,000 га талбайг нөхөн сэргээнэ.
- Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг зохион байгуулна.

Бүлэг 6. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого

Зорилго 6.1. Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах болон ус хангамжийн баруун эх үүсвэрийг барих төслийг хэрэгжүүлнэ.

- Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд “Ногоон нуур 1,008 айлын орон сууц төсөл”-ийн хэрэгжилтийг 70 хувьд хүргэнэ.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд 30,000 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна.

Зорилго 6.2. Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барих ажлын гүйцэтгэл 80 хувьд хүрсэн байна.
- Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэнэ.
- Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлж, Хэнтий аймгийн Хэрлэн суманд үерийн хамгаалалтын 1000 у/м далан, Цэнхэрмандал суманд үерийн хамгаалалтын 1539.8 у/м суваг, Баянхонгор аймгийн төвд ус хүлээн авах 3400 у/м цутгамал төмөр бетон сувгийг байгуулж, Баян-Өлгий аймгийн төвийн 11,735 у/м үерийн хамгаалалтын далан сувгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70.0 хувьд хүрсэн байна.
- Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хот хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.



**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТӨСӨЛ**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны
... дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч	Хамтрагч	
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр			
1	2	3	4	5	6	7	8	9	
<p>Бүлэг 1. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого</p> <p>Зорилго 1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>									
1.1.1	АХ-2050-2.2.2, МУТЖҮЧ-2.4.1, ЗГҮАХ-АХТ-1.1.2.7	Коронавируст халдвар (Ковид-19)-тай холбоотой хийгдэх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулж, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлэх, үр дүнг хүлээн авах	Судалгааны ажил эхлэх шатандаа явж байна.	Монгол Улсад зөвөрлөгдөж ирсэн коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлсон байна. Вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж дархлаа тогтох хугацааг тодорхойлсон байна.	600.00	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-	
1.1.2	АХ-2050-2.2.7, МУТЖҮЧ-2.4.1, ЗГҮАХ-АХТ-1.1.3.1	Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх	Нөөцийн бэлэн байдлыг эмгнэлгийн хэрэгсэл тус бүрээр тухай бүрд тооцон гаргаж байна.	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж нөөцийг шинэчилж сэлгэсэн байна.			Эрүүл мэндийн сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга	
1.1.3	АХ-2050-2.2.7, МУТЖҮЧ-2.2.1, ЗГҮАХ-АХТ-1.1.3.2	Орон нутагт Зоонозын өвчин судлалын төв, хил дагуух дагуух боомтод тандалтын нэгж байгуулах	Тооцоо судалгаа хийгдсэн.	2 аймагт Зоонозын өвчин судлалын төв, хил дагуух 10 боомтод тандалтын нэгж байгуулсан байна.	1,220.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Аймгийн Засаг дарга	
1.1.4	АХ-2050-2.2.5, МУТЖҮЧ-2.2.1, ЗГҮАХ-АХТ-1.1.3.4	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулах	0 хувь	Агуулахын барилгын ажлын явц 30 хувьд хүрсэн байна.	1,000.00	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-	
1.1.5	АХ-2050-2.2.28, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-1.1.3.7	Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн молекул биологийн лабораторийн чадавхыг бэхжүүлэх	6 аймагт ПГУ-ын шинжилгээ хийх молекул биологийн лаборатори байгуулагдсан.	5 аймгийн НЗ, БОЭТ-д БХ-ПГУ-ын шинжилгээ хийх төхөөрөмжтэй болж, лабораторийн чадавх нэмэгдсэн байна.	1,500.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Аймгийн Засаг дарга	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
1.1.6	АХ-2050- 2.1.43, МУТЖҮЧ-2.1.10, ЗГҮАХ- АХТ-1.1.12.1	Сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, цахим хичээлийн сан бүрдүүлэн сонголттой хувилбарыг бий болгох Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийн зээлийг Азийн хөгжлийн банктай тохирч, идэвхтэй хамтран ажиллах	ЕБ-ын 45 сургуульд сургалтын удирдлагын системийг туршсан.	ЕБ-ын 100 сургуульд үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн байна.			Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
1.1.7	ЗГҮАХ-АХТ-1.1.7.2	Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийн зээлийг Азийн хөгжлийн банктай тохирч, идэвхтэй хамтран ажиллах	1 үе шат буюу 100 сая ам.доллар	Төсвийн тогтвортой байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эх үүсвэрийг хүлээж авсан байна.	296,000.00	Гадаадын зээл, тусламж	Сангийн сайд	-	
1.1.8	ЗГҮАХ- АХТ-1.1.10.1	Улсын төсөв, Засгийн газрын дотоод үнэт цаасны эх үүсвэр, гадаад хөнгөлөлттэй зээлээс Засгийн газрын тусгай сан, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон өр авлагыг барагдуулах	1 үе шат буюу 100 сая ам.доллар	Засгийн газрын эх үүсвэрээр олгосон ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг банк, санхүүгийн байгууллагад худалдан эх үүсвэрийг төвлөрүүлэх, дампуурсан банкууд дээрх улсын төсвийн авлагын асуудлаар Монголбанк, банкуудын эрх хүлээн авагчидтай хамтран ажиллаж, хууль, журмын дагуу шийдвэрлүүлж, ТОСК болон Засгийн газрын тусгай сангуудаас улсын төсөвт төлөх өглөгийг бууруулсан байна.	-	-	Сангийн сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	Удсэн хариуцагч		
1	2	3	4	5	6	7	8	9	
Бүлэг 2. Хүний хөгжлийн бодлого									
Зорилго 2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.									
2.1.1	АХ-2050-2.2.15, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.3.2	Зүрх судасны төв байгуулах	Барилгын зураглал гарсан, ТЭЗҮ хийгдсэн.	Барилгын ажлын явц 10 хувьд хүрсэн байна.	40,000.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.2	АХ-2050-2.2.15, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.3.1	Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулах	Барилгын ажил эхлээгүй байна.	Барилгын ажлын явц 10 хувьд хүрсэн байна. Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн (хүний нөөц, тоног төхөөрөмж, бусад) тооцоолол хийсэн байна.	40,000.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.3	АХ-2050-2.2.15, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.3.3	Сурьезийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулах	Барилгын зураглал гарсан, ТЭЗҮ хийгдсэн. Газрын асуудал баталгаажсан.	Барилгын ажлын явц 30 хувьд хүрсэн байна.	8,000.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.4	АХ-2050-2.2.15, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.3.4	Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах	Барилгын ажлын явц 46 хувьтай байна.	Барилгын ажлын явц 70 хувьд хүрсэн байна.	5,600.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.5	АХ-2050-2.2.17, МУТЖҮЧ-2.2.4, ЗГҮАХ-АХТ-2.1.4.1	Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулах	Орон нутагт яаралтай тусламжийн цэг байхгүй.	Орон нутагт шаардлагатай 10 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулсан байна.	5,000.00	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга	
2.1.6	АХ-2050-2.2.15, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.3.8	Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барина.	Төсөл тооцоолол батлагдсан.	Зураг төсөв хийгдэж, Барилгын хөгжлийн төвөөр батлагдсан байна.	-	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.7	АХ-2050-2.2.3, МУТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-АХТ-2.1.5.3	Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Төлөвлөгөөт сургалт сурталчилгаа бүрэн хийгдсэн.	Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулна.	1,500.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.8	АХ-2050-2.2.25, МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-АХТ-2.1.6.1	Салбарын түвшинд мэдээллийн технологийн сүлжээний дэд бүтцийг бий болгох	48 байгууллагын сүлжээний дэд бүтцийн санхүүжилтийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.	26 байгууллага сүлжээний дэд бүтэцтэй болсон байна.	700.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.1.9	АХ-2050-2.3, МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-АХТ-2.1.6.2	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх	Мэдээлэл солилцооны платформ нэвтрээгүй.	Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд нь мэдээлэл солилцооны платформ нэвтрэсэн байна.	9,800.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	
2.1.10	АХ-2050-2.3, МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-АХТ-2.1.6.3	Дүрс архивлан хадгалах (PACS) нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	Эрүүл мэндийн байгууллагад PACS систем ашиглаж эхлээгүй.	Эрүүл мэндийн байгууллагуудад PACS систем бүрэн ашиглагдаж эхэлсэн байна.	5,800.00	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.11	АХ-2050-2.2.25, МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-АХТ-2.1.6.4	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлэх	Эрүүл мэндийн 29 байгууллагад телемедицин ашиглах боломж бүрдсэн.	Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 15 аймгийн А зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд телемедицин нэвтрэсэн байна.	500.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.12	АХ-2050-2.2.63, 2.2.5, МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.6.8	Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өргийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх	Төлөвлөлтийн шатанд явж байна.	Эрүүл мэндийн байгууллагын 20 хувьд цахим бүртгэлийн тогтолцоо нэвтрэсэн байна.	600.00	Бусад	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.13	АХ-2050-2.2.6, 2.2.19 МУТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ-АХТ-2.1.7.11	Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-ийн орлогыг нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтын хувь - 94.2	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтын хувь - 95.0			Эрүүл мэндийн сайд	-	
2.1.14	АХ-2050-2.2.7, МУТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ-АХТ-2.1.7.12	Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлэх	Цахим санг нэвтрүүлэх талаар Олон улсын байгууллагатай гэрээ байгуулсан.	Олон улсын эмнэлзүйн удирдамжийг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлсэн байна.	1,400.00	Бусад / ЭМДС/	Эрүүл мэндийн сайд	-	

III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.1.15	АХ-2050-2.2.3, МУТЖУЧ-2.2.7, ЗГҮАХ-АХТ-2.1.8.1	Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлэх	Төлөвлөлтийн шатанд явж байна.	Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтад эм ханган нийлүүлэх байгууллага 100 хувь хамрагдсан байна.			Эрүүл мэндийн сайд	-	
2.1.16	АХ-2050-2.2.35, МУТЖУЧ-2.2.7, ЗГҮАХ-АХТ-2.1.8.4	Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлэх	8 аймгийн нэгдсэн эмнэлгийн лаборатори сүлжээнд холбогдсон.	21 аймгийн нэгдсэн эмнэлгүүд сүлжээнд нэгдэж, нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн байна.	500.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.17	АХ-2050-2.2.28, МУТЖУЧ-2.2.7, ЗГҮАХ-АХТ-2.1.8.6	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих	Эмнэлтийн хэрэгслийн үйлдвэрлэл дотоодын зах зээлийн 1.4 хувийг эзэлж байна.	Эмнэлтийн хэрэгслийн үйлдвэрлэл дотоодын зах зээлийн 2 хувийг бүрдүүлдэг болсон байна.			Эрүүл мэндийн сайд	-	
2.1.18	АХ-2050-2.2.4, 2.2.26, МУТЖУЧ-2.2.8, ЗГҮАХ-АХТ-2.1.9.1	Эмнэлтийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг Бүсийн оношилгоо, амчилгээний төв (БОЭТ)-д бий болгон, чадавх бэхжүүлэх	Төгсөлтийн дараах сургалтыг 2 БОЭТ явуулж байна.	3 БОЭТ төгсөлтийн дараах сургалт явуулдаг болно.	250.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга	
2.1.19	АХ-2050-2.2.26, МУТЖУЧ-2.2.3, ЗГҮАХ-АХТ-2.1.11.1	Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийн барилга байгууламжийг барьж, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг бүрдүүлэх	АХБ-ны төсөл батлагдсан. Хэрэгжилт - 0 хувь	Увс, Ховд аймгийн бүсийн эмнэлэг, оношилгооны төвийн барилгын ажлыг 40 хувьд хүргэнэ.	3,000.00	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.20	АХ-2050-2.2, МУТЖУЧ-2.2, ЗГҮАХ-АХТ-2.1.13.2	Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэний дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх	4 багц тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.	Бүх өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлж эхэлнэ.	250.00	Бусад / ЭМДС/	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.21	АХ-2050-2.2.1, МУТЖУЧ-2.2.2, ЗГҮАХ-АХТ-2.1.1.3	"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөлтийн шатанд явж байна.	Арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.	3,000.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтог түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	Үндсэн хариуцагч		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.1.22	АХ-2050-2.2.1, МУТЖУЧ-2.2.2, ЗГҮАХ-АХТ-2.1.1.4	"Хавдрын эсрэг" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөлтийн шатанд явж байна.	Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хүрэх түвшин 50 хувьд хүрсэн байна.	600.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.23	АХ-2050-2.2.1, МУТЖУЧ-2.2.2, ЗГҮАХ-АХТ-2.1.1.5	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөлтийн шатанд явж байна.	Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна.	13,000.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.24	АХ-2050-2.2.1, МУТЖУЧ-2.2.2, ЗГҮАХ-АХТ-2.1.1.6	"Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөлтийн шатанд явж байна.	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.	200.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.25	АХ-2050-2.2.17	Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.	Чадавч бэхжүүлэх зорилгоор ЭМБ-уудад нийлүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжийн тооцоо судалгаа бүрэн хийгдсэн.	Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавч бэхжсэн байна.	8,100.00	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-	
2.1.26	АХ-2050-2.2.3, МУТЖУЧ-2.2.5, ЗГҮАХ-АХТ-2.1.7.10	Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах	ЭМБ-уудад e-health, h-info, health.gov.mn програмуудыг ашиглаж байна.	Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог бий болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно.	300.00	Бусад / ЭМДС/	Эрүүл мэндийн сайд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	
Зорилго 2.2. Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.									
2.2.1	МУТЖУЧ-3.5.2, ЗГҮАХ-АХТ-2.2.3.3	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Газар, зураг төсөл бэлэн болсон.	Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	25,000.00	Гадаадын зээл, тусламж	Ерөнхий сайд	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	
2.2.2	АХ-2050-2, МУТЖУЧ-3.5.2, ЗГҮАХ-АХТ-2.2.3.5	Нийслэлийн усан бассейны бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлж, Баянзүрх, Налайх дүүргийн спортын цогцолборыг ашиглалтад оруулах	Барилга угсралтын ажлын 90-95 хувь нь хийгдсэн.	Спортын цогцолборыг ашиглалтад оруулсан байна.	3,400.00	Улсын төсөв	Ерөнхий сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
Зорилго 2.3. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.									
2.3.1	АХ-2050-2.1.13, МУТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-АХТ-2.3.9.3	Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах ажлыг зохион байгуулах	Санхүүжилт шийдвэрлэгдсэн.	113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байр төвлөрсөн болон бие даасан ариун цэврийн байгууламжтай болсон байна.	50,000.00	Бусад	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.2	АХ-2050-2.1.13, МУТЖҮЧ-2.1.1, ЗГҮАХ-АХТ-2.3.2.1	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах насыг 3-5 нас болгон хамран сургалтыг нэмэгдүүлэх	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн дагуу 2-5 насны хүүхдийн хамран сургалт - 78.8 хувь	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 87.9 хувьд хүргэсэн байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.3	АХ-2050-2.1.13, МУТЖҮЧ-2.1.1, ЗГҮАХ-АХТ-2.3.2.2	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг тогтмол хийх	Хамран сургалтын хувь - 93.4	Хамран сургалтыг 95.0 хувьд хүргэсэн байна.	50.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.4	АХ-2050-2.1.15, МУТЖҮЧ-2.1.1, ЗГҮАХ-АХТ-2.3.2.3	Малчин болон алслагдсан хязгаар бүсэд амьдарч буй ерхийн 3-5 насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулж, хөгжлийг дэмжих	2020-2021 оны хичээлийн жилд хувилбарт сургалтад 17,141 хүүхэд хамрагдсан.	Сургалт, гал тогооны зориулалттай 50 гэр бүлэг нийлүүлж, хувилбарт сургалтад 500 хүүхэд нэмж хамрагдсан байна.	8,700.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.5	АХ-2050-2.1.15, МУТЖҮЧ-2.1.1, ЗГҮАХ-АХТ-2.3.2.4	Хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн ерхийн хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт үе шаттай хамруулж, тэдэнд боловсрол, эрүүл мэнд, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх	2020-2021 оны хичээлийн жилд 32 цэцэрлэгийн 24 цагийн 77 бүлэгт 2,226 хүүхэд хамрагдсан.	10 бүлэг нээж 250 хүүхдийг хамруулсан байна.	4,895.30	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.3.6	АХ-2050-2.1.21, МУТЖҮЧ-2.1.2, ЗГҮАХ-АХТ-2.3.3.1	Сууралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийх	Ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалтын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн журмыг баталсан. Хэрэгжилт 30 хувьтай байна.	Улирал тутмын хөндлөнгийн үнэлгээг шинэчилсэн журмын дагуу хийсэн байна (100 хувь).	500.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.7	АХ-2050-2.1.21, МУТЖҮЧ-2.1.2, ЗГҮАХ-АХТ-2.3.3.2	Бага, дунд боловсролын чанарыг үнэлэх судалгааг жил бүр зохион байгуулж, үнэлгээний дундаж хувийг ахиулах	Хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөө боловсруулсан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 40 хувьд хүргэнэ.	600.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.8	АХ-2050-2.1.20, МУТЖҮЧ-2.1.2, ЗГҮАХ-АХТ-2.3.3.3	Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын (PISA) үнэлгээнд хамрагдах	Судалгаанд хамрагдах бэлтгэлийг ханган туршилт шалгалтуудыг эхлүүлээд байна. Хэрэгжилт 30 хувьтай байна.	Үнэлгээнд хамрагдсан байна (100 хувь).	5,415.00	Гадаадын зээл, тусламж	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.9	АХ-2050-2.1.20, МУТЖҮЧ-2.1.3, ЗГҮАХ-АХТ-2.3.4.5	Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах	Монгол хэл, бичгийн сургалтын чанарын үнэлгээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хийсэн.	Монгол хэл, бичгийн сургалтын чанарын үнэлгээнд дунд, ахлах анги төгсөгчдийг хамруулсан байна. Монгол бичгийн хэвлэмэл болон цахим сурах бичиг, гарын авлагыг боловсруулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.10	АХ-2050-2.1.20, МУТЖҮЧ-2.1.3, ЗГҮАХ-АХТ-2.3.4.7	Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлж, хос хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Гадаад улсад амьдарч байгаа хүүхдэд зориулсан вебөд суурилсан цахим сурах бичиг 1-ийг боловсруулсан.	Монгол хэл, эх хэлний сургалтын хөтөлбөрийг туршиж, хэлэлцүүлж, сайжруулж, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулсан байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	

III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.3.11	АХ-2050-2.1.15, МУТЖҮЧ-2.1.3, ЗГҮАХ-АХТ-2.3.4.6	Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах журам батлагдсан. Хэрэгжилт 25 хувьтай байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, суралцах чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, багш нарыг арга зүйгээр хангаж хэрэгжүүлсэн байна (100 хувь).	60.00	Гадаадын зээл, тусламж	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.12	АХ-2050-2.1.34, МУТЖҮЧ-2.1.7, ЗГҮАХ-АХТ-2.3.8.1	Багш мэргэжлийн стандартыг батлуулж, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	"Чадварлаг багш" арга хэмжээ батлагдсан. Хэрэгжилт 10 хувьтай.	Хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ.	150.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.13	АХ-2050-2.1.41, МУТЖҮЧ-2.1.7, ЗГҮАХ-АХТ-2.3.8.5	Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлэх	"ЕБС дээр байгуулагдсан хүүхэд хөгжлийн загварт танхимд ажиллах багш, удирдах ажилтнуудыг чадавхжуулах" сургалтад 100, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад чадавхжуулах" сургалтад 100, нийт 200 багшийг мэргэшүүлсэн байна.	165 багшийг мэргэшүүлсэн байна.	20.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.14	АХ-2050-2.1.12, МУТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-АХТ-2.3.9.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх	80 сургууль, 80 цэцэрлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдахад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангасан.	140 сургууль, 140 цэцэрлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдахад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангасан байна.	300.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.3.15	АХ-2050-2.1.19, МУТЖҮЧ-2.1.8, ЗГУАХ-АХТ-2.3.9:5	Тусгай цэцэрлэг, сургуулийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, тавилга хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангах	2021 оны улсын төсөвт Сонгино хайрхан дүүрэгт тусгай хэрэгцээт сургууль, тусгай хэрэгцээт цэцэрлэгийн барилга /150 х/ч/ баригдахаар батлагдсан.	Сонгино хайрхан дүүрэгт сувиллын цэцэрлэг, сургуулийн цогцолборын барилга, тусгай 25, 63 дугаар сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг үргэлжлүүлсэн байна.	4,500.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.16	АХ-2050-2.1.43, МУТЖҮЧ-2.1.10, ЗГУАХ- АХТ-2.3.12.1	Бүх насны иргэд насан туршдаа суралцах боломжийг дэмжих, тэдний бие даан олж авсан мөдлэг, үр чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах чиглэлээр насан туршийн боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгож өргөжүүлэх	Боловсролын ерөнхий хууль, түүнийг дагалдан гарах хуулийг төслийг боловсруулсан.	Улсын Их Хуралд өргөн барьсан байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.17	АХ-2050-2.1.4.3, МУТЖҮЧ-2.1.10, ЗГУАХ- АХТ-2.3.12.2	Цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлж, багшид өөрийн бэлтгэсэн цахим агуулгыг нийтийн хүртээл болгох боломжийг бүрдүүлэх	Цахим сургалтын нэгдсэн платформыг үүсгэх ажлыг эхлүүлэн, цахим контентийг шинэчлэн боловсруулсан.	Цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлж, багшид өөрийн бэлтгэсэн цахим контентийг нийтийн хүртээл болгох боломжийг бүрдүүлсэн байна.	4,000.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.18	АХ-2050-2.1.44, МУТЖҮЧ-2.1.7, ЗГУАХ- АХТ-2.3.12.2	Багш бэлтгэх сургуулийн хөтөлбөрт цахим боловсролын агуулгыг баяжуулан нэмэх	Багш бэлтгэх сургуулийн хөтөлбөрт цахим боловсролын агуулгыг баяжуулан бүх хичээлийг цахимаар явуулж байна.	Багш бэлтгэх сургуулийн хөтөлбөрт цахим боловсролын агуулгыг баяжуулан нэмэгдүүлсэн байна.	200.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.3.19	АХ-2050-2.1.42, МУТЖҮЧ-2.1.11, ЗГҮАХ-АХТ-2.3.12.3	Боловсролын салбарт мэдээллийн системийн инновацыг нэвтрүүлж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх	Төрийн өмчийн ЕБС-ийн шилэн кабелийн дэд бүтцийг засварлан шинэчилж, боловсролын нэгдсэн сүлжээнд нийт сургуулийн 70 хувийг холбосон.	Боловсролын нэгдсэн сүлжээнд төрийн өмчийн бүх сургуулийг холбоно. Сургууль, цэцэрлэгийн сүлжээний дэд бүтэц, тоног төхөөрөмжийг сайжруулсан байна.	2,500.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.20	АХ-2050-2.1.28, МУТЖҮЧ-2.1.5, ЗГҮАХ-АХТ-2.3.12.7	Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, өгөгдлийн шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх хөтөлбөрийг боловсруулах	Хэрэгжилт 10 хувьтай байна.	Хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.21	АХ-2050-2.1.43, МУТЖҮЧ-2.1.10, ЗГҮАХ-АХТ-2.3.12.9	Цахим агуулга, цахим хичээл боловсруулан насан туршийн боловсролыг бүх хэлбэрээр дэмжих	Цахим сургалтын нэгдсэн системийг боловсруулж эхэлсэн.	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цахим агуулгыг баяжуулан сайжруулсан байна.	600.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.22	АХ-2050-2.1.33, ЗГҮАХ-АХТ-2.3.13.1	Багшийн хөгжлийн институт, Боловсролын судалгааны хүрээлэн, Боловсролын чанарын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын хөгжлийн төвийг шинэчлэн зохион байгуулж, Боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгох	Суурь судалгааны 10 хувьтай хийгдэж байна.	Боловсрол, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээ, насан туршийн боловсролын байгууллагын эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна (100 хувь).	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.3.23	АХ-2050-2.1.27, МУТЖҮЧ-2.1.4, ЗГҮАХ-АХТ-2.3.14.1	Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлэх	Боловсролын ерөнхий хуулийн болон дагалдаж гарах хуулийн төсөлд төрийн өмчийн их, дээд сургуульд төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбоотой зохицуулалт тусгагдсан.	Судалгааны болон бусад зардалд төрөөс дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг хийсэн байна.	500.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.24	АХ-2050-2.1.42, МУТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-АХТ-2.3.9.1	Газар зүйн мэдээллийн системд суурилж боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөдөг болох	Газар зүйн мэдээллийн системд суурилж боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөдөггүй.	Салбарын хөрөнгө оруулалтын газарзүйн мэдээллийн системд төлөвлөлийн модулийг нэмж хөгжүүлсэн байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
2.3.25	АХ-2050-2.1.42, МУТЖҮЧ-2.1.11, ЗГҮАХ-АХТ-2.3.12.5	Салбарын үйлчилгээг цахимжуулан иргэд, байгууллагад хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод хүргэх	Дээд боловсролын үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжээгүй.	Дээд боловсролын сургалтын байгууллагын тусгай зөвшөөрөл, сургалтын зээл, тусламж, тэтгэлгийн бүртгэл, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн байна.	200.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	
Зорилго 2.4. Шинжлэх ухаан, технологи, инновац, Эрдэм шинжилгээний ажлын зарлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зарлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.									
2.4.1	АХ-2050-2.4.1, МУТЖҮЧ-2.1.4, ЗГҮАХ-АХТ-2.3.5.6	Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгож, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах	Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/131 дугаар тушаалаар шилдэг эрдэм шинжилгээний бүтээл шалгаруулах журмыг баталсан.	Судалгааны үр дүнд бий болсон шинэ мэдлэг, патентын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, патент эзэмшигчид мөнгөн урамшуулал олгосон байна.	50.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.4.2	Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, инновацын тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх	Технологи дамжуулах төв, эсвэл хамтын оффист бүртгэлтэй гарааны компаниудад дэмжлэг үзүүлэх журмыг боловсруулсан.	Инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, инновацын үйл ажиллагаа эрхлэгчид, гарааны компаниудын өрсөлдөх чадварыг бэхжүүлсэн байна.	2,000.00	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-		
2.4.3	Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах ажлыг үргэлжлүүлэх	Нээлттэй лабораторийн ажиллах журмын төсөл боловсруулагдсан.	Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах ажлыг эрчимжүүлж хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор, их сургуулиудыг түшиглэн хөгжүүлсэн байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-		
Зорилго 2.5. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргыг монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.									
2.5.1	Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Нийгмийн даатгалын эрх зүйн шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна.	Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна.	-	-	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	-		
2.5.2	Ажилтны бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалт бий болгох	Ажилтны бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалт бий болгох	Ажилтны бүтэн бус цагаар, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалтыг бий болгосон байна.	-	-	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	-		

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтог түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
2.5.3	АХ-2050-2.1.6, МУТЖҮЧ-2.6, ЗГҮАХ-АХТ-2.5.6.3, 2.5.15	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлж, цахим хөдөлмөрийн бирж бий болгох	4	5	6	7	8	9	
			Хөдөлмөр зуучлал үйлчилгээний Ejob.gov.mn вэбсайт ажиллаж байна.	Хөдөлмөр зуучлалын цахим програм хангамжийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаатай холбосон байна. Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.	2.820.00	Гадаадын зээл, тусламж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	-	
2.5.4	АХ-2050-2.1.6, МУТЖҮЧ-2.6, ЗГҮАХ-АХТ-2.5.6.5	Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээг ил тод, нээлттэй болгон цахимжуулах	4	5	6	7	8	9	
			Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний үйл ажиллагаанд ezuvsuuurl.mn цахим систем нэвтрүүлж, бүрэн ашиглалтад оруулахаар туршилт хөгжүүлэлт хийгдэж байна.	ezuvsuuurl.mn цахим системийг бүрэн нэвтрүүлсэн байна. Нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдсэн байна. Ejob платформд нэгтгэсэн байна.	150.00	Гадаадын зээл, тусламж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд		
2.5.5	АХ-2050-3.1.18, МУТЖҮЧ-2.3.1, ЗГҮАХ-АХТ-2.1.7, 2.5.8.5	Ахмад настанд тусламж үйлчилгээг үзүүлэх тогтолцоог нэвтрүүлэх "Үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх	4	5	6	7	8	9	
			"Техникийн тусалцааны (KSTA 9928)" төслийг Монгол Улсад 2022 оны 11-р сар хүртэл хэрэгжүүлэхээр 2019 оны 12-р сарын 19-ний өдөр баталсан.	Жишиг загвар үйлчилгээнүүдийг 3-аас доошгүй төвд туршиж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 20-иос доошгүй хувьд хүрсэн байна.	1,140.00	Гадаадын зээл, тусламж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Эрүүл мэндийн сайд	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
2.5.6	АХ-2050-2.3.3, 3.1.8, МУТЖҮЧ-2.3.4, ЗГҮАХ-АХТ-2.5.8.9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийг 6 аймагт байгуулах (Архангай, Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл)	1. Аймаг, орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүнд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх бүтэц, тогтолцоо байхгүй. 2. Архангай, Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл аймгуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажлыг эхлүүлсэн.	Архангай, Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл аймгуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв баригдсан байна.	4,360.00	Гадаадын зээл, тусламж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд		
2.5.7	АХ-2050-2.3.3, 3.1.8, МУТЖҮЧ-2.3.4, ЗГҮАХ-АХТ-2.5.8.9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгын зургийн ажлыг эхлүүлсэн.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.	1,940.00	Гадаадын зээл, тусламж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд		
2.5.8	АХ-2050-2.3.1, 2.6.12, МУТЖҮЧ-3.3, ЗГҮАХ-АХТ-2.5.9.1	Орлого багатай өрхийн гишүүдэд мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн арга хэмжээ, төсөл хэрэгжүүлэх	Мэргэжлийн ур чадвар олгох тусгайлан төсөл, арга хэмжээ байхгүй.	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	1,000.00	Улсын төсөв	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд		

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтрагч
			Суурь түвшин	Зорилтог түвшин	Хөрөнгийн хэмжээ (сая.төгрөг)	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
2.5.9	АХ-2050-2.6.6, ЗГҮАХ-АХТ-2.5.10.1	Үндэсний мэргэшлийн хүрээг бүрдүүлэх бодлогын баримт бичгийг шинэчлэх, ажил мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгон, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн мөрдүүлэх	49 мэргэжлийн чиглэлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулан батлан мөрдөж байна.	15 хүртэлх мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг боловсруулан, сургалтад нэвтрүүлсэн байна.	13.00	Улсын төсөв	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Боловсрол, шинжлэх ухааны сайд	
2.5.10	АХ-2050-2.6.6, ЗГҮАХ-АХТ-2.5.10.2	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын засаглал, удирдлагыг сайжруулах, багш, хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор цахим мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх	Тэтгэлтийн систем буюу Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын 15 хувь цахимжсан.	Системийн хоёрдугаар шатны хөгжүүлэлт хийгдэж 50 хувь нь цахимжсан байна.	2,153.00	Улсын төсөв	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	-	
2.5.11	АХ-2050-5.1.1, ЗГҮАХ-АХТ-2.5.6.1	Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх	Нийгмийн халамжийн үйлчилгээний 15 хувь цахимжсан байна.	Нийгмийн халамжийн үйлчилгээний 60 хувь цахимжсан байна.	100.00	Гадаадын зээл, тусламж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Сангийн сайд	
2.5.12	АХ-2050-2.1.6, МУТЖУЧ-2.6, ЗГҮАХ-АХТ-2.5.6.4	Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Үйлчлүүлэгч төвтэй аргачлал"-ыг нэвтрүүлж, цахимжуулах	Хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг үйлчилгээг хэрэгжүүлэх аргачлалыг ХНХ-н Сайдын тушаалаар баталгаажуулсан.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Үйлчлүүлэгч төвтэй аргачлал"-ыг 6 аймаг, дүүрэг туршин нэвтрүүлж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоог шинэчлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.	100.00	Гадаадын зээл, тусламж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	-	

Д/д	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч	Хамтрагч
